

*ISSN: 2663-256X*

---

# **MANDAKH RESEARCH**

---

INTERNATIONAL SCIENTIFIC JOURNAL

Дугаар #6, 2021

*Сэтгүүлийн талаар санал, хүсэлтээ доорх хаягаар ирүүлнэ үү.*

Мандах Их Сургууль,

Баянгол дүүрэг, 16-р хороо,

Амарсанаагийн гудамж 18/1, Улаанбаатар хот, Монгол,

Шуудангийн хаяг: УБ-16040, ш/х88,

7018-5950, 7018-5949

Цахим шуудан: [journal@mandakh.edu.mn](mailto:journal@mandakh.edu.mn)

Цахим хуудас: <https://mandakh.edu.mn/mandakh-erdem-setguul>

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Эрхлэгч:	Г. Нанжид, профессор
Редактор:	Ч. Төрбадрах, Ph.D, дэд профессор
Нарийн бичиг:	А. Наранцэцэг, Ph.D
Гишүүд:	Б. Цэцгээ, Sc.Ph.D, профессор
	Л. Энх-Амгалан, Ph.D, профессор
	Б. Нацагдорж, Ph.D, профессор
	Д. Бадарч, Ph.D, профессор
	С. Ганцэцэг, Ph.D, дэд профессор
	Г. Цагаач, Ph.D, дэд профессор
	С. Цолмон, Ph.D, дэд профессор
	Б. Оюунтунгалаг, Ph.D, дэд профессор
	Jiang Ailin, Ph.D, профессор
	Masaaki Aoki, Ph.D, профессор
	Andrii Kostryzhev, Ph.D, дэд профессор
	Dee Jitaree, Ph.D, дэд профессор
	Andrew Eric Shimunek, Ph.D, дэд профессор

## АГУУЛГА

### **Л.Дансранбавуу, Ж.Гантулга**

“Говь” хувьцаат компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх цар тахлын болон бусад нөлөөллийг судлах нь. BUS 601..... 1

### **Erdenebat Tuvshinjargal, Kong-Ting Yeh, Cheng-Nan Kang**

Identifying the critical business model elements for mongolia horse-riding tourism with fuzzy delphi method. BUS 602.....15

### **А.Наранцэцэг, Д.Цэвэлмаа, З.Ундармаа, Э.Энх-Амгалан, Г.Золбоо, Г.Энх-Отгон, Ц.Намуун**

Нягтлан бодогч мэргэжилтэнд шаардагдаж буй ур чадварыг тодорхойлох нь. BUS 603.....39

### **Б.Сайнжаргал, М.Жанузах**

Фейсбүүк хэрэглэгчдийг хэрэгцээнд суурилж сегментчлэх нь. BUS 604..... 57

### **Ш. Болор, Б. Оюунтунгалаг**

Сүлжээ дэлгүүрийн маркетингийн стратегит хийсэн судалгаа. BUS 605.....69

### **Ө.Тэргэл**

Шилийн гол аймгийн монголчуудын гэр бүлийн хэлний хэрэглээний зөрөөт шинжийн тухай судалгаа. HUM 601..... 89

### **Jiang Ailin**

Preliminary study Xi Jinping’s Thoughts on Administering the Country. HUM 602.....103

### **П.Баасанжаргал, Б.Нацагдорж**

Мандах их сургуулийн оюутны чөлөөт цагийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа. HUM 603.....115

Article info: Mandakh Research, 2021, Vol.06, BUS 601

## “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ ЦАР ТАХЛЫН БОЛОН БУСАД НӨЛӨӨЛЛИЙГ СУДЛАХ НЬ

Л.Дансранбавуу <sup>1,a\*</sup>, Ж.Гантулга <sup>2,b</sup>

<sup>1,2</sup>Мандах Их Сургууль, Инженер-эдийн засгийн сургууль, Эдийн засаг  
бизнесийн тэнхим

<sup>a</sup> dansranbavuu@mandakh.edu.mn, <sup>b</sup> j\_gantulga@mandakh.edu.mn

### Хураангуй

2019 оны сүүлч үеэс эхэлсэн ковид-19 цар тахал нь хөгжиж байгаа болон ядуу буурай улс орнуудын эдийн засагт илүү хүчтэй сөрөг нөлөөллийг үзүүлж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаанд нөлөөлж эхлээд байна. Монгол Улсын нийт экспортын орлогын 80-90 хувийг уул уурхайн салбар дангаараа эзэлж байгаа өнөөгийн нөхцөл байдалд бид эдийн засгаа солонгоруулах, экспортын орлогоо олон талтай болгоход хөдөө аж ахуйн гаралтай, түүний дотор мал аж ахуйд суурилсан экспортын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлага байна.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын нийт мал сүргийн 41.3 хувийг эзэлдэг ямаан сүргээс авдаг үнэ цэнтэй, органик түүхий эд болох ноолуурыг анхан шатнаас эхлэн эцсийн шатны боловсруулалтыг хийдэг “Говь” ХК-ны борлуулалт, ашигт ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг хийх зорилготой хийгдсэн.

Судалгаанд олон хүчин зүйлийн регрессийн OLS аргыг ашигласан бөгөөд үнэлгээний үр дүнд тус компанийн ашигт ажиллагаанд ковид-19 цар тахал болон дансны өглөг, ашиглалтын зардлын харьцаа нь сөргөөр нөлөөлж байсан бол санхүүгийн хөшүүрэг нь цэвэр ашгийг өсгөх чиглэлд нөлөөлж байв.

**Түлхүүр үг:** мал аж ахуй, ноолуурын үйлдвэрлэл, ковид 19, борлуулалт, ашигт ажиллагаа

## ОРШИЛ

Монголчууд хэдэн зуун жилээр малаа маллаж, малаасаа гарах ашиг шимийг нь хүртэж, илүү гарсан зүйлсээ хөрш улсууддаа арилжин борлуулж ирсэн. 2020 оны мал тооллогын дүнгээс харахад, Монгол Улсад 67.1 сая мал байна. Үүний 30 сая буюу 44.8 хувь нь хонь, 27.7 сая буюу 41.3 хувь нь ямаа, 4.7 сая буюу 7.1 хувь нь үхэр, 4.1 сая буюу 6.1 хувь нь адуу, 0.5 сая буюу 0.7 хувь нь тэмээ байна (ҮСГ, 2021). Нийт мал сүргийн дотор 40 илүү хувийг дангаараа эзэлдэг ямаан сүргээсээ жил бүр авдаг ноолуурын экспорт нь уул уурхайн бус экспортын багахан орлогод томоохон байр суурийг эзэлдэг билээ. Монгол Улс жил бүр 9.5 орчим мянган тонн ямааны ноолуур бэлдэж зах зээлд нийлүүлж байгаа нь дэлхийд БНХАУ-ын дараа хоёрдугаар байранд орох үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл бидэнд дэлхийн нийт ноолуурын 30 шахам хувийн нөөц байна гэсэн үг. Гэтэл ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлэх цор ганц гарц болсон эцсийн боловсруулалт хийх хувь хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа, ноолуурын бодит үнэ төдийлөн нэмэгдэхгүй байгаагаас шалтгаалан ямаан сүргийн тоо 2020 онд өмнөх жилээсээ 1.5 саяар буюу

5.3 хувиар буурсан байна (ҮСГ, 2021).

Цаашид ийм байдлаар тоо толгой нь буураад явбал 181 мянган малчин өрхийн орлогод томоохон цохилт болно. 2019 оноос эхэлсэн ковид 19 өвчний улмаас ядуурал нэмэгдэж, төв суурин газрууд дахь ажлын байрууд олноор алдагдаж байгаа өнөөгийн нөхцөлд бид хөдөө орон нутаг дахь гол ажлын байр болсон мал аж ахуйн орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн бус экспортын орлогыг өсгөх боломж бололцоог хайх шаардлага үүсээд байна.

“Говь” ХК нь 1981 онд Япон Улсын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан үндэсний томоохон үйлдвэрлэгчдийн нэг юм (Говь ХК, 2021). Салбарын хамгийн том, ууган үйлдвэрлэгч болсон тус компанийн ашиг, орлогод нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг судалснаар ковид 19 цар тахлын улмаас салбарын өмнө тулгамдаад байгаа асуудлууд, ямаан сүргийн тоо толгой буурах болсон шалтгааныг тодруулж, цаашид ноолуурын экспортыг нэмэгдүүлэх зарим боломжуудыг тодруулж болох юм гэсэн үүднээс судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

## НООЛУУРЫН САЛБАР

Ноолуур нь Евроазийн өндөрлөг, хуурай газар дахь зарим улсуудын ямаан сүргийн хялгасны доор ургаж, ямааг хүйтнээс хамгаалах үүрэгтэй нарийн ширхэгтэй, нягт ихтэй үс юм. Энэхүү ховор нандин, органик түүхий эд нь хөнгөн, дулаан, зөөлөн, биед эвтэй хувцас болдгоороо эртний Ромын үеэс ихэд үнэлэгдэж ирсэн. Өөрөөр хэлбэл Европын улс орнууд энэ үеэс эхлэн ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэж, “Хаадын хувцас” гэж нэрлэж ирсэн байна. Тэдгээр хаадын нэг нь алдарт Наполеон Банопорт байсан бөгөөд өөрийн эхнэр Жозефинадаа ноолууран ороолт бэлэглэж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ (Gresa, 2021). Мөн Хятадад ч гэсэн ноолуурыг өндрөөр үнэлэн “Зөөлөн алт” эсхүл “Зөөлөн алмаз” (Shānyángóng, 2009) гэж үнэлж байсан бол Монгол Улсад ургадаг алт гэж дуудах, бичих тохиолдол ч түгээмэл байдаг. Ноолуур нь аль болох нарийн ширхэгтэй, урт байх тусмаа илүү зөөлөн, илүү үнэ цэнтэй байдаг.

Ноолуурын үйлдвэрлэл, маркетинг, боловсруулалт хамгийн хурдацтай өөрчлөгдөж байна. Зарим улс нийлүүлэлтийн сүлжээнд шинээр нэвтэрч, боловсруулах үйлдвэрлэлээ эхлүүлж, зарим нь үйлдвэрлэлийн технологио

шинэчлэн хөгжүүлж байна. Ноолуур, ноолууран бүтээгдэхүүн нь олон улсын зах зээл дээр арилжаалагддаг, илүү баян, хөгжингүй улс орнуудад борлуулалтаа түлхүү хийгддэгийн хувь улс үндэстнүүдийн хил хязгаарыг дамнан, зарим нь улсад бэлтгэгдэж, дараагийн хэд хэдэн оронд үе шаттайгаар боловсруулагдаж, тухайн улсууддаа эсхүл гуравдагч орны хэрэглэгчдэд борлуулдаг. Иймээс ноолуур нь олон олон улсын малчид, үйлдвэрлэгчдийн амьжиргааны үндэс болж, улс орнуудын эдийн засагт хүчтэй нөлөөллөө үзүүлж байдаг.

Хятад бол дэлхийн ямааны тоогоороо дэлхийд тэргүүлж, хамгийн их ноолуурыг бэлтгэхийн зэрэгцээ сүүлийн үед Азийн бусад ямаа бүхий улсуудаас ноолуурыг авах гол худалдан авагч, боловсруулагч үйлдвэрлэгч улс болоод байна (Carol Kerven Odessa Centre Ltd., and Kyrgyz Sheep and Goat Breeders Association, 2007). БНХАУ-ын ноолуурын үйлдвэрүүд цаашид ноолуур худалдан авах, боловсруулах тал дээр дэлхийд тэргүүлэх зорилготой ажиллаж байгаа нь тодорхой байна. Харин боловсруулсан ноолуурын хувьд гол худалдан авагч нь Итали улс бол хоёрдугаар байранд Англи улс

ордог. Англи улсын компаниуд нь ноолуурын үйлдвэрүүдэд хөрөнгө оруулах, эсхүл өөрсдийн үйлдвэрүүдээ байгуулах зэргээр БНХАУ-ын ноолуур боловсруулах салбарт хүчтэй байр суурийг эзэлж байна.

АНУ бол ноолууран цамцны хамгийн том зах зээлүүдийн нэг бөгөөд 2006 онд 493 сая долларын үнэтэй цамц импортолсноос, 87 хувийг Хятадаас импортолж, нэг бүрийг нь 32 орчим ам.доллаар авч байсан бол Италийн ноолууран цамц 71 орчим ам.доллаар, Английн ноолууран цамц 116 орчим ам.доллар байна (Carol Kerven Odessa Centre Ltd., and Kyrgyz Sheep and Goat Breeders Association, 2007).

Дээрх бүхнээс харахад, ноолуур нь Азийн орнуудад буюу Афганистан, Иран, Казахстан, Киргизстан, Энэтхэг, Монгол, Тажикстан, Узбекистан, Туркменистан, Пакистан, Хятадын баруун хэсгийн бусад мужуудад бэлтгэгдэж, дийлэнх нь БНХАУ-ын үйлдвэрүүдэд, багахан хэсэг нь Итали, Англи улсуудад боловсруулагдан эцсийн бүтээгдэхүүн болж, АНУ, Европын улсууд зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудад борлогддог байна.

## **КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НООЛУУРЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

Дэлхий нийтэд ноолуурын бэлтгэл, импортын худалдан авалт, боловсруулалтын хэмжээгээр тэргүүлэгч БНХАУ-д ковид 19 цар тахал хамгийн түрүүнд буюу Европт илрэхээс 45 хоногийн өмнө гарч эхэлсэн. Ковид 19 цар тахлын улмаас малчид ямаан сүргийн тоо толгойг цөөлөх шаардлагагүй учраас ноолуур бэлтгэл нь өмнөх жилийнхтэй буюу цар тахлын өмнөх жилийнхтэй ойролцоо байсан. Гэсэн ч ковид 19-ийн нөлөөллөөр эрэлт нь огцом буурч, БНХАУ дахь ноолуурын үнэ нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 30 хувиар унасан байна (Thomas, 2021). Үүнд голлон нөлөөлсөн зүйл бол цар тахал тархаж эхэлсэн цаг хугацаа байв. Ноолуур бэлтгэгдэж, ноолууран утасны зарим хэсэг үйлдвэрлэгдсэн боловч, үүнийг эцсийн бүтээгдэхүүн болгож, үйлдвэрлэх цаг хугацаа байхгүйгээр хөл хорио тогтоогдож, үйлдвэрүүд олноороо зогссон нь ноолуурын үнэ буурахад нөлөөлсөн. 2020 оны эхнээс унаж эхэлсэн БНХАУ-ын ноолууран бүтээгдэхүүний дотоодын эрэлт ч гэсэн төдийлөн сэргэхгүй байгаа, экспортын ихэнх захиалга хойшлогдож, цуцлагдаж



байгаа нөхцөл байдал үргэлжилсээр байна.

Дэлхий дахины ноолуур бэлтгэл 2020 онд 25,208 тонн орчим байсан нь өмнөх оныхоос 7 хувиар буюу 1,748 тонноор өссөн үзүүлэлт юм. Ковид 19 цар тахал эхэлсэн ч гэсэн энэ нь ноолуур бэлтгэлд төдийлөн нөлөөлөлгүй 2019 онд ноолуур бэлтгэл урьд жилийнхээсээ 0.8 хувиар өссөн байна. Бэлтгэх ноолуурын хэмжээ нэмэгдэж байгаа ч гэсэн дэлхийн зах зээл дээр түүхий ноолуурын болон түүгээр хийгдэх бүтээгдэхүүнүүдийн эрэлт, үнэ буурсан нь Монгол Улсын ноолуурын бизнест ноцтой нөлөөлж байна. Учир нь түүхий ноолуурын нийлүүлэлтээр дэлхийд хоёрдугаар байранд ордог Монгол Улсын хувьд ноолуурын ач холбогдлыг үнэлэхгүй байхын аргагүй. Монгол Улсын нийт өрхийн 20 хувь буюу 181 мянган малчин өрхийн дийлэнх нь ноолуурын орлогоос хамаарч байдаг (UN Mongolia, 2020).

Дэлхий нийтийн ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад ковид 19 цар тахал үлэмж хэмжээний өөрчлөлт оруулж байгаа өнөөгийн нөхцөлд Монгол Улсын тэргүүлэх үйлдвэрлэгч болох “Говь” ХК нь үйл ажиллагаагаа хэрхэн өөрчлөн зохион байгуулах, өрсөлдөх чадвараа хэрхэн дээшлүүлэх, бэлтгэн нийлүүлэгч

олон зуун мянган малчдын амьдрал ахуйг дээшлүүлэхийн тулд яаж ажиллах талаараа судалгаанд суурилсан шийдвэрүүдийг гаргах шаардлагатай нь тодорхой. Энэхүү судалгааны ажил нь тус компанийн өнөөгийн нөхцөл байдлыг тоон өгөгдлөөр судлах, тодруулах зорилготой хийгдсэн болно.

### **“ГОВЬ” ХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Говь корпорац нь ямааны ноолуур, тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Монголын хамгийн том компани юм. Тус компани 1981 онд төрийн өмчит аж ахуйн нэгжээр байгуулагдаж, дараа нь 2007 онд бүрэн хувьчлагдсан. Анхан шатны түүхий эд хүлээн авч, эцсийн бүтээгдэхүүн хүртэл ноолуурын үйлдвэрлэлийн бүхий л үе шатны боловсруулалт хийдэг Монголын цорын ганц үйлдвэрлэгч юм. “Говь” ХК нь одоогоор 35 орны 100 гаруй худалдан авагчдад бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. Тус компани нь дотоодын зах зээлд хамгийн том, хүлээн зөвшөөрөгдсөн ноолууран брэнд бөгөөд зах зээлийн 71 хувь, олон улсын зах зээлд экспортлох ноолууран бүтээгдэхүүний 61 хувийг тус компани нийлүүлж байна.

Өнөөгийн байдлаар хөдөө аж ахуйн салбар нь Монголын эдийн засгийн үндсэн тулгууруудын нэг болж байгаа бөгөөд эдийн засгаа солонгоруулах, уул уурхайн салбарын эзлэх хувийг багасгахад тус салбар чухал үүрэгтэй. Монгол Улс ноолуур бэлтгэлээрээ дэлхийд хоёрдугаар байранд ордог хэдий ч нийт бэлтгэсэн ноолуурынхаа дөнгөж 10 хувийг дотооддоо боловсруулж, үлдсэнийг нь БНХАУ руу түүхий эд байдлаар экспортолдог. Угаасан ноолуурын 70 гаруй хувийг экспортолдог, хөдөө аж ахуйн салбар нь ихэвчлэн анхан шатны үйлдвэрлэлд төвлөрч байгаа, боловсруулах хүчин чадал хязгаарлагдмал байгаа (ADB, 2015) өнөөгийн нөхцөл байдалд “Говь” ХК нь гадаад, дотоодод салбараа төлөөлж байна гэж хэлж болно.

Говь ХК нь Улаанбаатар дахь үйлдвэртээ жил бүр 1200 гаруй тонн ноолуур, тэмээний ноос боловсруулж, үүгээрээ 500,000 гаруй ширхэг сүлжмэл эдлэл, 250,000 метр урттай даавуу, 25,000 ширхэг захиалгын хувцас үйлдвэрлэдэг (WIPO, 2021). Энэ нь Монгол Улсад үйлдвэрлэж байгаа ноолуур, тэмээний ноосон бүтээгдэхүүний 1/5-ийг дангаараа үйлдвэрлэдэг, дотоодын зах зээлийн 60 орчим хувийг дангаараа хангадаг гэсэн үг юм. Ноолуур, тэмээний

ноос худалдан авснаараа хөдөө орон нутгийн малчдын амьжиргааны нэг гол эх үүсвэрийг бий болгож байдаг. Компанийн бүтээгдэхүүнүүд нь Канад, Европын Холбоо, Япон, ОХУ, АНУ зэрэг олон оронд экспортолдог байна.

Монголын Ноос, Ноолуурын Холбоо нь Говь ХК, Буян ХХК, Кашмир холдинг ХХК, Блю скай ХХК болон салбарын бусад үйлдвэрлэгчидтэй хамтран бэлтгэдэг ноолуураа 100 хувь дотооддоо боловсруулах зорилго бүхий “Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээл дээр Монгол брэндийг бий болгох бизнес төсөл” боловсруулан ажиллаж байна (МННХ, 2020). Монголын тэргүүлэгч үйлдвэрүүд ингэж бодлогоо нэгтгэн, хамтарч ажиллаж чадвал жил бүр бэлтгэдэг 387 сая ам.долларын үнэ бүхий 9,500 тонн ноолуурыг 24 сая эцсийн бүтээгдэхүүн буюу 1.7 тэрбум ам.доллар болгон өсгөх боломжтой.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны тус хэсэгт бид Монгол Улсын ноос, ноолуурын салбарт голлох байр суурийг эзлэх “Говь” хувьцаат компанийн ашигт ажиллагаанд үзүүлэх хүчин зүйлсийн нөлөөллийг эмпирик нотолгоонд тулгуурлан тодорхойлохыг зорьсон.

## Хүснэгт 1. Хувьсагчдын тайлбар

Хувьсагчийн төрөл	Хувьсагчид	Тайлбар	Хэмжих нэгж
Үл хамаарах	Covid	2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөллийг хэмжих дамми хувьсагч	0, 1
	Mt	"Говь" ХК-ны МУ-ын ноос, ноолуурын салбарт эзлэх хувь хэмжээ	Хувь
	Im	Тайлант хугацаан дахь Говь компанийн бараа материалын эргэлт, ашиглалтын зардал / [(Хугацааны эхэн үеийн цэвэр бараа материал + Хугацаа дуусах үеийн цэвэр бараа материал) / 2]	Коэффициент
	Paid	Нийлүүлэгчидтэй хийсэн данс, t хугацааны туршид бүртгэлтэй компаниудын төлөх дансны харьцаа. Дансны өглөг / ашиглалтын зардал	Коэффициент
	Prec	Дистрибьюторуудтай хийсэн данс, Компанийн t хугацааны тайлангийн харьцаа. Дансны авлага / үйл ажиллагааны орлого	Коэффициент
	Dta	Компанийн t хугацааны актив, пассивын харьцаа	Коэффициент
	Lnta	T хугацаан дахь тус компанийн нийт хөрөнгийн хэмжээний логарифм	Логарифм
Хамаарах	Gpr	Компанийн t хугацааны борлуулалтын хэмжээ	Төгрөг
	Ope	Компанийн t хугацааны цэвэр ашгийн хэмжээ	Төгрөг

Хүснэгт 1-д хувьсагчдын тойм тайлбарыг тодорхойлж өгсөн бөгөөд одоо бид тус үнэлгээг хийх эконометрик загварын тавилыг эмпирик нотолгоонд үндэслэн тодорхойлно. Ингэхдээ “Говь” хувьцаат компанийн ашигт ажиллагаанд үзүүлэх хүчин

$$Y_t = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \epsilon_t \quad [1]$$

$\epsilon_t$  – нь олон хүчин регрессийн функцийн алдааг илтгэх санамсаргүй хувьсагч байх ба

зүйлсийн нөлөөлөл, тэдгээрийн зүй тогтол хамаарлыг ердийн хамгийн бага квадратын аргаар (OLS) үнэлэх болно. Судалгааны энэ хэсэгт судлагдах эконометрик загварыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

шугаман регрессийн сонгодог нөхцөл буюу дор хаяж Гаусс Марковын эхний 4 нөхцөлийг

хангаснаар BLUE чанар хангагдана. Тодорхойлогдсон хувьсагчдаар Тэгшитгэл [1] дэх санамсаргүй дэлгэрэнгүй тэгшитгэл хэлбэрээр хувьсагчдыг хүснэгт 1-д илэрхийлбэл:

$$Gpr_t = \beta_0 - \beta_1 Covid_t \pm \beta_2 Mt_t \pm \beta_3 Im_t \pm \beta_4 Paid_t \pm \beta_5 Prec_t \pm \beta_6 Dta_t \pm \beta_7 lnta_t + \varepsilon_t \quad [2]$$

$$Ope_t = \beta_0 - \beta_1 Covid_t \pm \beta_2 Mt_t \pm \beta_3 Im_t \pm \beta_4 Paid_t \pm \beta_5 Prec_t \pm \beta_6 Dta_t \pm \beta_7 lnta_t + \varepsilon_t \quad [3]$$

гэсэн хэлбэртэй болно.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд 2012-2020 оны хоорондох хагас жилээрх санхүүгийн тайлан, тоон өгөгдлийг ашиглав. Тайлангийн дансдууд болох бараа материал, дансны өглөг, дансны авлага, актив, пассив,

борлуулалт, цэвэр ашгийг санхүүгийн тайлангаас, “Говь” компанийн дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээг монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байрлах тухайн байгууллагын үйл ажиллагааны тайлангаас тус тус авч ашиглав.

### Хүснэгт 2. Дискрптив статистик

	COVID	MT	IM	PAID	PREC	DTA	LNTA	GPR	OPE
Mean	0.12	0.71	0.02	593.14	0.13	1.88	18.92	71120852	2392230
Median	0.00	0.68	0.02	4.48	0.09	1.92	18.73	55647981	4087435
Maximum	1.00	0.83	0.03	8191.14	0.26	2.71	19.81	210000000	17502984
Minimum	0.00	0.65	0.00	1.99	0.03	1.18	18.03	12767661	-46182020
Std. Dev.	0.33	0.07	0.01	1995.79	0.09	0.44	0.61	55391735	15420586
Skewness	2.37	0.92	-0.16	3.54	0.34	-0.24	0.15	1.21	-2.10
Kurtosis	6.63	2.18	2.28	13.96	1.38	2.29	1.66	3.60	7.17
Jarque-Bera	25.31	2.86	0.45	120.59	2.17	0.53	1.33	4.38	24.75
Probability	0.00	0.24	0.80	0.00	0.34	0.77	0.51	0.11	0.00

Дээрх хүснэгтэд судалгаанд ашиглагдаж буй хүчин зүйлсийн статистик үзүүлэлтүүд болох дундаж, медиан, максимум утга,

минимум утга, стандарт хазайлт, скевнесс, куртосис, жако-берро, магадлал зэрэг үзүүлэлтүүдийг харуулсан ба нийт түүврийн урт 17

байна. Загварын үнэлгээг гарган авахаас өмнө бид хугацаан цуваан эконометрикийн үндсэн ойлголтуудын нэг болох нэгж язгуурын шалгуурын талаар авч үзэх болно.

### **Интегралчлагддаг процессууд**

Тодорхойлолт:  $d$  зэрэгт интегралчлагддаг процесс гэж  $d$

$$\Delta^2 y_t = \Delta(y_t - y_{t-1}) = y_t - 2y_{t-1} + y_{t-2} \quad [4]$$

Суурин бөгөөд урвуутай байх ёстой. Энд анхааруулахад хоёрдох ялгавар буюу  $\Delta^2 y_t = y_t - 2y_{t-1} + y_{t-2}$ -ийг хоёр үеийн ялгавар болох  $\Delta_2 = y_t - y_{t-2}$ -той хольж болохгүй. Ихэнх ялгаварт суурин эдийн засгийн болон санхүүгийн хугацаан цуваа  $I(1)$  процесс байх хандлагатай байдаг тул бид ч мөн энэхүү процесс дээр төвлөрнө. Нэгж

удаа ялгавар авсны дараа суурин (зарим тохиолдолд “тогтвортой” эсвэл “стационар” гэх нь бий) бөгөөд урвуутай болдог процессыг хэлнэ. Ийм процессыг  $y_t = I(d)$  гэж тэмдэглэдэг. Жишээ нь, хэрвээ  $y_t = I(2)$  бол  $y_t$  болон  $\Delta y_t = y_t - y_{t-1}$  нь суурин бус. Харин хоёрдох ялгавар буюу  $\Delta^2 y_t$  нь

язгуурын шалгуурыг ихэнхдээ Дики-Фуллерын шалгуур гэдэг бөгөөд, анх Давид Дики (David Dickey) болон Вейн Фуллер (Wayne Fuller) гэдэг статистикчид санал болгосон байдаг. Дики-Фуллерийн  $AR(1)$  загварын хувьд санал болгосон нийтдээ гурван шалгуур регресс байх ба эдгээр гурав нь дараах хэлбэртэй:

$$I. \quad \Delta y_t = \alpha y_{t-1} + \varepsilon_t \quad [5]$$

$$II. \quad \Delta y_t = \alpha y_{t-1} + \delta + \varepsilon_t \quad [6]$$

$$III. \quad \Delta y_t = \alpha y_{t-1} + \delta + \gamma t + \varepsilon_t \quad [7]$$

Эдгээр гурван хувилбарын хувьд тэг таамаглал нь процесс  $I(1)$  буюу  $H_0: \alpha = 0$ , харин эсрэг таамаглал нь хувьсагч нэг бол  $I(0)$ , эсвэл чигтэй суурин буюу  $H_A: \alpha < 0$  гэж тодорхойлогдож байна. Мэдээж эдгээр гурван хувилбараас хамгийн ерөнхий нь III бөгөөд нөгөө хоёр нь

онцгой тохиолдол болно. Өргөтгөсөн Дики-Фуллерын давуу тал нь  $AR(n)$  эрэмбийн суурин байдлыг шалгах үед хэрэглэгдэх бөгөөд дики-фуллер регрессийн детерминист бүрэлдэхүүн хэсэг ямар байхаас шалтгаалан асимптот шийдвэрийн утгууд ялгаатай байна.

Хүснэгт 3. Өргөтгөсөн Дики-Фуллерын шалгуур (ADF)

Хувьсагч	ADF хувилбар I, II, III			ADF тестийн нэгж язгууртай гэсэн тэг таамаглал үнэн байх магадлал	Ялгаварын зэрэг
	None	Intercept	Trend & Intercept		
MT	+			0.0007***	I(1)
IM			+	0.0248**	I(1)
PAID		+		0.0357**	I(0)
PREC		+		0.0000***	I(1)
DTA		+		0.0000***	I(1)
LNTA			+	0.0000***	I(1)
GPR		+		0.0005***	I(0)
OPE		+		0.0148**	I(0)

Тэмдэглэл: \*\*, \*\*\* тэмдэглэгээ нь харгалзан 5%, 1%-ийн ач холбогдлын түвшинд нэгж язгууртай буюу суурин бус байна гэсэн  $H_0$  таамаглалыг няцааж байгааг үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, 5% болон 1%-ийн ач холбогдлын зэрэг дэх  $t(\hat{\alpha})$ -ын асимптот шийдвэрлэх утгуудад хүрэлцээтэй байна.

Нэгж язгуурын шалгуурын үр дүнгээс харахад Paid (Дансны өглөг/Ашиглалтын зардал), Gpr (Борлуулалтын хэмжээ), Ope (Цэвэр ашиг) зэрэг хувьсагчид тухайн түвшинд суурин буюу I(0) процесс болж тэг таамаглал 5 болон 1 хувийн ач холбогдлын түвшинд няцаагдаж байна. Харин бусад хувьсагчдын хувьд I(1) процесс болж тэг таамаглалуудыг 1 хувийн ач холбогдлын түвшинд няцаасан байна.

Энэхүү шалгуурыг явуулснаар үнэлгээг хамгийн бага квадратын аргаар үнэлэх боломжтойг харуулж байгаа юм. Одоо бид үл хамааран хувьсагчид өөр хооронд мультиколлинеар шинж чанар байгаа эсэхийг олж тогтоохын тулд судалгаа шинжилгээнд хамгийн түгээмэл хэрэглэдэг Пирсоний корреляцийн матрицыг байгуулан хэт өндөр хамааралтай хувьсагчдыг загварын үнэлгээнээс хасагдуулах болно.

Хүснэгт 4. Хувьсагчдын корреляцийн матриц

	D(MT)	D(IM)	PAID	D(PREC)	D(DTA)	D(LNTA)	GPR	OPE
D(MT)	100.00%	-26.24%	-10.62%	22.25%	-32.88%	56.45%	-0.38%	10.30%
D(IM)	-26.24%	100.00%	-2.38%	-58.69%	38.70%	-28.47%	25.92%	25.75%
PAID	-10.62%	-2.38%	100.00%	6.54%	-3.73%	-7.44%	-30.41%	-0.80%
D(PREC)	22.25%	-58.69%	6.54%	100.00%	-58.35%	58.42%	-74.63%	-6.62%
D(DTA)	-32.88%	38.70%	-3.73%	-58.35%	100.00%	-82.86%	44.56%	22.96%
D(LNTA)	56.45%	-28.47%	-7.44%	58.42%	-82.86%	100.00%	-56.47%	-2.14%
GPR	-0.38%	25.92%	-30.41%	-74.63%	44.56%	-56.47%	100.00%	8.97%
OPE	10.30%	25.75%	-0.80%	-6.62%	22.96%	-2.14%	8.97%	100.00%

Корреляцийн матрицаас харахад DDTA (Актив/Пассив) нь DLNTA (Нийт хөрөнгийн логарифм)-тай (-0.8286) хүчтэй сөрөг хамааралтай байна. Шугаман регрессийн сонгодог загварын нөхцөл ёсоор үл хамааран хувьсагчид өөр хоорондоо өндөр корреляцитай байж болохгүй ба дээрх үр дүнгээс үзэхэд нийт активын хэмжээ өндөр корреляцитай байгаа тул загварын үнэлгээнд оруулж тооцохгүй болохыг харуулж байна. Харин бусад хувьсагчдын хувьд харьцангуй хамаарлын хүч сул байна.

Бид судалгааны энэ хэсэг хүртэл хувьсагчдын хоёрдугаар эрэмбийн суурин байдлыг нэгж язгуурын ADF тестээр, мультиколлинеар шинж чанар байгаа эсэхийг Пирсоний корреляцийн шинжилгээгээр тус тус судалж тогтоолоо. Одоо дээрх тооцооллууд дээр үндэслэн “Говь” хувьцаат компанийн борлуулалт болон цэвэр ашгийн түвшинд нөлөөлж буй санхүүгийн болон санхүүгийн бус хүчин зүйлсийн нөлөөллийг ЕХБКА-аар үнэлье.

## Хүснэгт 5. ЕХБКА-ын үнэлгээний үр дүн

Хувьсагчид	GPR			OPE		
	Coefficient	t-Statistic	Prob.	Coefficient	t-Statistic	Prob.
COVID	-4.1457	-0.2015	0.8448	-42.2467	-6.7203	0.0001***
D(MT)	227.5954	1.2027	0.2598	18.8855	0.4392	0.6709
D(IM)	-1451.3900	-1.8740	0.0937*	42.3749	0.1707	0.8682
PAID	-0.0066	-3.1017	0.0127**	-0.0008	-2.1770	0.0575*
D(PREC)	-354.8461	-3.2447	0.0101**	18.3071	0.5535	0.5934
D(DTA)	9.3780	0.4325	0.6756	12.8475	2.2856	0.0481**
C	76.7137	4.9895	0.0007***	8.5460	3.0236	0.0144**
R-квадрат	0.682795			0.891643		
Засварласан R	0.471325			0.819405		
F статистик	3.228804			12.34317		
Тэмдэглэл: *, **, *** тэмдэглэгээ нь харгалзан 10%, 5%, 1%-ийн итгэх түвшинд тус хувьсагчид хамааран хувьсагчид нөлөөтэй болохыг илэрхийлнэ.						

Хүснэгт 5-ын үр дүнгээс Монгол Улсын ноос, ноолуурын салбарт голлох байр суурийг эзлэх “Говь” хувьцаат компанийн цэвэр ашгийн түвшин болон борлуулалтын хэмжээ нь санхүүгийн тайлангийн бусад дансдууд болон Ковид 19 цар тахлын нөлөөллөөс ихээхэн хамааралтай байгааг илэрхийлж байна. Тодруулбал, Цэвэр ашгийн тэгшитгэлд ковид-19 цар тахлын нөлөөлөл цэвэр ашгийн хэмжээг 42 тэрбум төгрөгөөр, Дансны өглөг болон ашиглалтын зардлын харьцаа 0.0008 тэрбум төгрөгөөр бууруулж байгаа бол, санхүүгийн хөшүүрэг буюу актив болон пассивын харьцаа 12.8 тэрбум төгрөгөөр цэвэр ашгийг өсгөж байна.

Харин бараа материалын эргэлт, “Говь” ХК-ий МУ-ын дотоодын зах зээлд эзлэх хувь, дансны авлага болон борлуулалтын харьцаа зэрэг хувьсагчид үнэлгээнд ач холбогдолгүй гарчээ. Дээрх үнэлгээнд “Говь” хувьцаат компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлс хүлээгдэж буй таамаглалтай нийцтэй, статистик ач холбогдолтой гарч гол үр дүнг харуулав. Одоо дээрх үнэлгээг хамгийн сайн шугаман гажилтгүй үнэлэгч болсон эсэхийг олж тогтоохын тулд оношилгооны шалгууруудаар тестлэх болно.



### Хүснэгт 6. Оношилгооны шалгууруудын үр дүн

Тестүүд	Тооцоологдсон утгууд	Хи-Квадрат	Магадлал	Тайлбар
Breusch-Godfrey Serial Correlation LM Test		0.5741	0.3094	Цуврал автокорреляцигүй
Normality			0.8436	Нормаль тархалттай
Heteroskedasticity Test: ARCH		0.9355	0.9294	Нөхцөлт Хетероскедастикгүй
Durbin-Watson stat	1.958743			Үлдэгдэл автокорреляцигүй

OLS загвараар үнэлэгдсэн коэффициентууд нь хамгийн сайн шугаман гажилтгүй үнэлэгч (BLUE) буюу шугаман регрессийн сонгодог загварын нөхцөлүүдийг хангаж байгаа эсэхийг шалгахад диагностик тестүүдийн бүх тооцоолол эерэг үр дүнг үзүүлж байна.

## 1. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дэлхийд ноолуур бэлтгэн нийлүүлэлтээр хоёрдугаар байранд ордог Монгол Улсын салбарын тэргүүлэх үйлдвэр нь “Говь” хувьцаат компани юм. Тус компанийн үйл ажиллагаа, тогтвортой байдлаас 181 мянган малчин өрхийн болон 2,300 орчим ажилчдын орлого хамаарна. 2019 оны жилийн эцсээр 2,612 ажилчинтай байсан тус үйлдвэр цар тахлын улмаас 2020 оны 4 дүгээр сард 250 ажилтнаа цомхотгосон байна. Үүнийгээ тус компани 2020 оны эхний улиралд Монгол Улсад айлчлах байсан жуулчид огт ирээгүй, цагаан сар тэмдэглээгүй

зэргээс нийт борлуулалтынхаа 64.2 хувийг хийдэг дотоод зах зээл зогсонги байдалд орсон, гадаадын худалдан авагчид ч гэсэн захиалгуудаа цуцалж байгаагаар тайлбарласан байна.

2019 оны тайлангаас харвал тус компани 210 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 34.4 тэрбум төгрөгийн татварыг улсад төлж, 2.4 тэрбумын ашигтай ажилласан байна. Монгол Улсын нийт иргэдийн амьдралд нөлөөгөө үзүүлэх үндэсний үйлдвэрлэгчийн талаар сайтар судалж, хүндрэлтэй асуудлуудад бодит шийдэл олох шаардлага үүсээд байна.

Судалгааны үр дүнгээс харахад, ковид 19 цар тахал нь 42 тэрбум төгрөгөөр, дансны өглөг болон ашиглалтын зардлын харьцаа нь 0.0008 тэрбум төгрөгөөр цэвэр ашгийн хэмжээг тус тус бууруулж байгаа бол, санхүүгийн хөшүүрэг буюу актив болон пассивын харьцаа 12.8 тэрбум төгрөгөөр цэвэр ашгийг өсгөж байна. Харин бараа материалын эргэлт, “Говь” ХК-ийн

дотоодын зах зээлд эзлэх хувь, дансны авлага болон борлуулалтын харьцаа зэрэг хувьсагчид үнэлгээний ач холбогдолгүй гарчээ.

Дээрх бүхнээс харахад ковид 19 цар тахлын тархалтыг бууруулах,

иргэдийн өдөр тутмын амьдралыг хэвийн горимд оруулахын тулд вакцины 3 дугаар тунг хийж, дархлаажуулан дотоодын эдийн засгийг бүрэн нээх нь компанийн ашигт ажиллагаанд хамгийн том нөлөөллийг үзүүлнэ.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. УСГ. (2021, 10 02). Үндэсний Статистикын Газар. Retrieved from [www.1212.mn](http://www.1212.mn)
2. Говь ХК. (2021, 10 01). Говь ХК. Retrieved from [www.gobi.mn](http://www.gobi.mn)
3. Gresa, P. (2021). Retrieved from Cashmere Specialist World: <https://www.cashmerespecialist.com/>
4. Shānyángróng, G. (2009). Berkshire Publishing Group LLC. Retrieved from <http://www.berkshirepublishing.com/>
5. Carol Kerven Odessa Centre Ltd., and Kyrgyz Sheep and Goat Breeders Association. (2007). Report on the first Asian conference on cashmere., (p. 3). Bishkek, Kyrgyzstan.
6. Thomas, A. (2021). The Effect of Covid 19 on China’s Cashmere business. Erdos, China.
7. UN Mongolia. (2020). “Cashmere Sector Recovery from Covid 19 – Building Forward Better” workshop. Ulaanbaatar, Mongolia: UNDP.
8. ADB. (2015). Value-Added Cashmere Prouction and Export Project. Ulaanbaatar, Mongolia: Asian Development Bank.
9. WIPO. (2021). Protecting Tradition and Revitalizing a National Brand. Geneva, Switzerland: World Intellectual Propoerty Organization.
10. МННХ. (2020). Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээл дээр Монгол брэндийг бий болгох бизнес төсөл. Улаанбаатар, Монгол Улс: Монголын Ноос Ноолуурын Холбоо.

*Article info: Mandakh Research, 2021, Vol.06, BUS 602*

## **IDENTIFYING THE CRITICAL BUSINESS MODEL ELEMENTS FOR MONGOLIA HORSE-RIDING TOURISM WITH FUZZY DELPHI METHOD**

Erdenebat Tuvshinjargal<sup>1, a\*</sup>, Kong-Ting Yeh<sup>2, b</sup>, Cheng-Nan Kang<sup>3, c</sup>

<sup>1</sup> College of Management, National Taiwan Sport University, Taiwan

<sup>2</sup> Professor and Doctor, Department of Recreation and Leisure Industry Management, College of Management, National Taiwan Sport University, Taiwan

<sup>3</sup> Professor and Program Director Masters in Sport Facility Management and Health Promotion, National Taiwan University, Taiwan

\*<sup>a</sup>tuvshoo1023@gmail.com, <sup>b</sup>tingpower@gmail.com, <sup>c</sup>ckang@ntu.edu.tw

### **Abstract**

*This study aims to identify the critical success business model (BM) elements for Mongolia horse-riding tourism and provide suggestions to the horse-riding tourism-related industry organizations, government, and academic researchers.*

*After carrying out 36 elements from literature, this study developed fuzzy-Delphi-based questionnaire to obtain the critical horse-riding tourism BM elements for Mongolia by seeking the opinions of 11 experts.*

*The result revealed that the list consisted of 28 critical elements in 6 criteria, including “Planning product strategy”, “Marketing strategy”, “Staff performance”, “Quality of horses”, “Risk management”, and “Trail riding”.*

*In order to promote horse-riding tourism, the assessment criteria developed in this research could be provide as a reference for the tourism operators and researchers who participate in the horse-riding tourism in Mongolia to improve their business and strategies in the future.*

**Keywords:** risk management, strategy, tourism industry, trail riding, staff performance

## 1. INTRODUCTION

### 1.1 Background

Because the awareness of sports benefits worldwide is increasing, people are willing to join sports than before. This demand helps increasing the outputs of sports industries sport tourism is included. Many sport tourism agencies from different nations/regions provide various sport-touring services to share this market, including Mongolia.

One of the uniqueness related to Mongolia sport tourism is horse-riding, a major of tourism products advertised and offering related to horses in Mongolia. The horses outnumber the population, ranked 6th in the world in terms of horses the number of horses with 4.2 million (National Statistics Office of Mongolia, 2017), Mongolia has considerable potential, particularly in varied environmental features and culture for develop the horse-riding tourism.

The horse industry is thriving and occupies a large share of the tourism market and has a significant economic impact on local communities (Helgadóttir, 2006; Helgadóttir & Sigurðardóttir, 2008). There is no specific research on horse-riding tourism, service quality and the importance of this sector. Very few existing research to touch upon lightly about Mongolian horse based tourism such as: cultural landscape attraction in Mongolia tourism (Buckley et al., 2008), structure of the equestrian tourism sector (Ollenburg, 2005),

relating to archaeology evidence for horse pastoralism (Taylor, 2015), tour operator business perspectives (Shircliff, 2018), the importance of cultural identities (Gantumur, 2020).

Currently, Mongolia's tourism promoters move into running tourism business by default (Gantumur, 2020); in this respect, academic research pointed out this sector's business needs to reveal more apparent paths to an analysis of their service quality (Sigurðardóttir & Helgadóttir, 2015; Buchmann, 2014). According to Osterwalder (2007), the critical elements required to build and clearly define the BM are customer segments, value proposition, distribution channels, customers' relationship, revenue streams, key resources and key activities.

However, there is few research for the Mongolia sport tourism promoters to refer to when it comes to horse-riding tourism dealing this business to improve the quality of service and strategy in objective information. Therefore, this study aims to identify critical BM elements for the Mongolia horse-riding tourism, and suggestions to the sector for its development and contribute for Mongolian further academic research.

The research question of this study is what are the critical business model elements that need to be implemented for Mongolia horse-riding tourism?

## 2. LITERATURE REVIEW

### 2.1 BM

The BM explains how to create value and deliver it to consumers. As Osterwalder et.al (2005) defines, the BM represents how a business conducts sales and purchases of goods/services for profit. In addition, the BM represents the basic logic and strategic choice of creating and own value in a value chain (Shafer et al., 2005).

According to Teece (2018) mentioned the successful BMs designs as follows: (1) Designing a good business depends on the same art and intuition as science and analysis. (2) Designing a BM requires an in-depth knowledge of customer needs and the technological and organizational resources that can meet those needs. (3) BMs require an understanding of current BMs operating in the market. Most new BMs involve hybridization. (4) The elements of the BM need to be coherent and coherent to reinforce each other. (5) Strategic analysis should be linked to business modeling. Strategy guides the design of a business model and, to some extent, constitutes it. (6) The business model must be combined with strategies and assets that are difficult to imitate. Imitations will happen sooner or later, and pioneers must be quick learners. (7) Identifying customer segments for attention is critical to understanding and implementing the BM. (8) In the case of lateral markets, it is crucial to start early and plant laterally

effectively. (9) The ability to re-engineer a good BM is an essential component of solid dynamic skills. (10) It is always difficult to introduce a new BM in an existing organization, and a separate organizational unit may be required.

Literature on the BM in sport tourism, Peric et al. (2016) has recently proposed an innovative BM for sustainable sport tourism where 27 different elements are placed within four broader categories that make up the core of the BM (value proposition, key resources, key processes, and value capture). The first category is called value proposition, which explains what benefits (products/services and experiences) an organization provides and to whom it provides them. Key resources are assets required to deliver the value proposition to the targeted customer. The purpose of key processes is to leverage and transform resources within value creation and delivery. Value capture is a function that aims to generate value for the organization, which, in most cases, takes the form of a profit.

### 2.2 Current situation horse-riding tourism in Mongolia

Currently, the number of horses is more than the human population in Mongolia. Mongolia has 4.2 million horses (National Statistics Office of Mongolia, 2019), it is hard to find research revealed the demand for customer services of horse-riding tourism in Mongolia.

Previous studies focused either on genetic analysis of domestic and the wild horse or the general background of the Mongolia tourism development, and only few noted the horse-riding tourism in Mongolia (Fijn, 2017; Matsuzawa, 2019), cultural landscape attraction in Mongolian tourism (Buckley et al., 2008), archaeological evidence for horse pastoralism (Taylor, 2015) tour operator business perspectives (Shircliff, 2018), and importance of cultural identities (Gantumur, 2020). Many companies carry out horse-riding tourism, and horses are an important part of Mongolian adventurers' interests and destination image (Buckley et al., 2008). Either way, all the options offer unique opportunities to connect with nature, animals, and different communities and ethnic groups (Shircliff, 2018).

Buckley et al. (2008) analyzed five primary data sources to test marketing, surveys, product design, perceptions, commoditization, and tourist satisfaction in the Mongolian cultural landscape. The study concluded that the key touring attractions of Mongolia should be grass-land, nomads, horses, and ger(yurt). Shircliff (2018) interviewed employees from 15 companies to understand how Mongolian culture is perceived and adapted from a business perspective. The result shows that Mongolia tour companies are lack of standardized service protocol, making individual companies responsible for tourist

activity and government support for and human recourse.

Following the route of Emperor Genghis Khan, the tour operator offers small-group tours with a local English-speaking guide. Besides, the travelers are accompanied by horsemen native to the area, who still maintain a very close relationship with their horses (Tugjamba et al., 2021).

The most accessible places for horse-riding adventure are the Terej National Park and the Khovsgol Nuur lake (D'Anieri, 2018). In addition to the tour operators, some Mongolian families live around the park and provide their horses for rent. Before launching into a riding, one must take classes on the handling of a Mongolian horse, a short, robust, and semi-wild breed, and remember that one must always ride on the left this is how they are trained.

### **2.3 Horse-riding tourism in worldwide**

From 1990's general lifestyle changes fueled demand for rural tourism, it was the neotrophilia, lost connection with rural space, and search for authenticity that spurred renewed demand for holidays in rural areas. Increased interest in horses and horse-riding in Europe/worldwide reflects the growing demand for equestrian tourism (Tomljenović et al., 2018). Horse tourism can be viewed as part of several sub-sectors of the tourism spectrum, including nature-based or

outdoor tourism, adventure tourism, rural tourism, sports tourism, tradition, and heritage tourism, and event tourism (Ollenburg, 2005; Vaugeois, 2014; Evans et al., 2015).

Equestrian/horse-riding tourism is commonly defined as adventure tourism (Buckley et al., 2008; Pomfret, 2006). As Buchhman (2014) defined horse tourists as tourists who at some stage or other during their holiday used the horse as a model of transportation, and to whom riding is an important part of this holiday, with the minimum of one overnight stay away from home.

In many countries, the horse is currently a tourist attraction and is an integral part of national identity and image (Beeton, 2001; Helgadóttir & Sigurðardóttir, 2020; Pickel-Chevalier, 2015; Schmudde, 2015). Horses-based activities have been used as destination branding for tourism in countries like America (Kline et al., 2015) and Australia (Ollenburg, 2005), France (Pickel-Chevalier, 2015), Hungary (Obadovics & Kulcsar, 2015), Ireland and Iceland (Buchmann, 2014; Helgadóttir & Sigurðardóttir, 2020), Mongolia (Buckley et al., 2008) and Turkey (Belber & Erdoğan, 2019), Spain (Castejon & Rodríguez, 2012) and Finland (Tienhaara et al., 2017).

As Iceland, horse-riding tourism is developing for several decades as an important sector, and these researchers contributed to horse-riding tourism research (Helgadóttir & Daspher, 2016; Helgadóttir & Sigurðardóttir, 2018; Schmudde, 2015; Sigurðardóttir

& Helgadóttir, 2015). Horse-riding tourism is based on heritage and keeping a traditional culture of horses' daily use (Helgadóttir, 2006), and horses are famous and image and promote Iceland tourism (Helgadóttir & Dashper, 2016; Schmudde, 2015; Sigurðardóttir, 2018).

The academic interest in the horse-related industry and especially horse-riding tourism has increased and extended into many disciplines last three decades. All these studies recognize countries that have developed horse-riding tourism as an essential sector and make a significant contribution to the economic and labor development of rural areas.

#### **2.4 Critical services of satisfaction in horse-riding tourism**

The importance of service factors in horse-riding tourism as early research in Kentucky, America by Blackwell et al. (2006) determined the travel cost approach to analyze individual trail visitation behavior. The study found the distance to the trail site, various trail characteristics, such as trail length, and authenticity to increase the visits. The study recommended that the trail system is at least 15 miles in length, ensuring that loop trails are available, placing trails near water sources, marking trails, providing full-service camping facilities near trailheads back-country camping, and offering nice sights on the riding trails.



Sigurðardóttir and Helgadóttir (2015) evaluated those important five factors (each factor has elements): staff performance, horses, riding trails, and gear and facilities in customer satisfaction. The research found that the most important factor is staff performance and service attitude; secondly, riding trails and horse quality. The study suggested increasing knowledge by degrees of employees essential in equestrian tourism to ensure quality and customer satisfaction. That marketing strategy factor needs to be in further research for developing equestrian tourism. The main task of marketing or promoting a business is to capture individuals' attention and market goods or services in a targeted manner. The goal is always to increase the distribution, the turnover, or the market share (Sidali et al., 2013). Moreover, Sigurðardóttir and Steinthorsson (2018) determined the importance of rural micro cluster development in horse tourism. The study found that important concerning factors were knowledge of horses and services to develop equine tourism in Northwest Iceland.

In recent research by Belber and Erdoğan (2019) evaluated the service quality of domestic and foreign tourists total of 323 who participated in equestrian trekking in the Turkey, Nevşehir area. The average international visitors' responses were negative insurance services and staff's instruction for horse-riding in a foreign language. They suggest staff should improve language knowledge

necessary to equine tourism quality. It is also important to the tradition of horse breeding, quality of horses, and professional staff skilled in riding and horses (Pickel-Chevalier, 2015). Studies on sport tourism tourists worldwide have shown that safety and risk management are the essential key factors to customer decision-making (Chen & Funk, 2010; Peric et al., 2018; Sigurðardóttir & Helgadóttir, 2015). Horse-riding tourism consists of soft adventure tourism characteristics, reduced risk, and excitement, challenge, and stimulation, and induces preparation and anticipation (Page et al., 2005). Safety for riders and horses should be guaranteed, especially if the visitors are children (Buchmann, 2014; Sigurðardóttir & Helgadóttir, 2015), same results by Peric et al. (2016), showed that safety issues are the elements of the BM in sport tourism customer value, service quality, and safety are high on their plan.

To conclude from previous literature, important factors of customer satisfaction in horse-riding tourism business can be drawn to critical 6 factors, including planning product strategy, marketing strategy, staff performance, quality of horses, risk management, and trail riding. Besides, from the international point of view, there is not much research on horse-riding tourism as well, but it is gratifying that there have been several studies in the last 2 decades.



### 3. METHOD

This study uses the Fuzzy Delphi Method (FDM) to reach the experts' consensus of critical BM elements for Mongolian horse-riding tourism. Before designing the questionnaire, the researchers gathered the evaluation criteria from horse-riding tourism relevant literature review. The main databases were prospected from PubMed, Elsevier, Google Scholar, Research Gate. The literature search terms used were in English, Chinese, and Mongolian language.

#### 3.1 Fuzzy Delphi Method

This study uses the Fuzzy Delphi Method (FDM) to reach the experts' consensus of critical BM elements for Mongolian horse-riding tourism. Ishikawa et al., (1993) proposed the FDM and it was derived from the traditional Delphi technique and fuzzy set theory. The FDM has been widely applied to construct key performance appraisal indicators in domain applications such as the service industry and sustainable ecotourism (Zhang et al., 2021).

However, Chen (2001) modified Ishikawa et al. (1993) after the method proposed to “triangular fuzzy number” to represent the consensus of the knowledge achieve convergence analysis results lies closer to the opinions of experts. Fuzzy Delphi Double trigonometric concepts to integrate experts' opinions and proposed FDM as a verification tool;

its application and detailed implementation steps are as follows (Jeng, 2001; Kang et al., 2017; Zhang et al., 2021):

First step: After all of the factors that may include considerations, compiled fuzzy expert Delphi questionnaire, finding an expert group composed of experts in related fields, and then ask the experts within each group of experts to give a range of possible values for each factor. This range of values of the “minimum” on behalf of the expert assessment of the project to quantify the fraction of “the most conservative of cognitive value ( $C$ )”; this interval value of “maximum” represents the expert assessment of the project the fraction of “the most optimistic cognitive value ( $O$ )”, the higher the score the more important of the project, said.

Second step: For each factor  $i$ , all the experts were given the statistics, “ the most conservative value cognition” and “ the most optimistic cognitive value” and will be excluded extreme values fall in “ two standard deviations” other than. They were then not excluded from the calculation of the remaining “ the most conservative value perception” of minimum  $C_L^i$ , geometric mean  $C_M^i$  and maximum  $C_U^i$ , and “ the most optimistic cognitive value” of the minimum  $O_L^i$ , the geometric mean  $O_M^i$  and maximum  $O_U^i$ . Minimum use Microsoft Office Excel software to establish the factors of “the most conservative value cognition” and “the most optimistic cognitive

value” in the geometric mean and maximum.

Third step: The second steps were established by the calculating each factor  $i$  “the most conservative value perception” fuzzy triangular numbers  $C^i = (C_L^i, C_M^i, C_U^i)$  “the most optimistic cognitive value” triangular fuzzy

number with  $O^i = (O_L^i, O_M^i, O_U^i)$ . (shown in Figure 1).

Fourth step: The gray zone assay to the views of the expert group of the group of the test is to reach a consensus, and determine the following three ways:




Figure 1. Triangular fuzzy numbers (Source from Kang et al., 2017; Zhang et al., 2021)

1. No gray areas exist, if  $(C_U^i \leq O_L^i)$  that is non overlapping triangular fuzzy numbers representing the various experts and scholars have consensus segment interval values. This means that for the assessment project  $i$ , the most conservative of all the expert knowledge of the value reached

consensus. Similarly, for the assessment project  $i$ , the most optimistic of cognitive value of all the experts have also reached a consensus. Therefore, to make this assessment project  $i$  "consensus importance value" is equal to the arithmetic mean  $G^i, C_M^i$  and  $O_M^i$ , the arithmetic formula:

$$G_i = (C_U^i + O_M^i)/2 \tag{1}$$

2. There are gray area exist, but little difference between the views of experts if  $(C_U^i > O_L^i)$ , that there are two overlapping triangular fuzzy numbers and fuzzy relationship between the

gray zone  $Z^i = C_U^i - O_L^i$ , less than the experts would assess the scope of the project zone optimistic perception and conservative cognition is the geometric mean of  $M^i = O_M^i - C_M^i$ , the value of each

interval represents the views of experts, although blurring sector, but given the extreme value of expert advice, and not too much difference with the views of other experts, it did not result in differences of opinion diverge.

Therefore, make this item  $i$  ask consensus importance of value  $G^i$ , equal to double the number of triangular fuzzy gray area of fuzzy relations, conduct intersection (min) operation resulting fuzzy set.

$$F^i(x_j) = \left\{ \int_x \{\min[C^i(x_j)O^i(x_j)]\} dx \right\} \quad (2)$$

$$G^i = \{x_j | \max \mu_{Fi}(x_j)\} \quad (3)$$

3. There are gray areas exist, but the big difference between the views of experts if ( $C_U^i > O_L^i$ ), that there are two overlapping triangular fuzzy numbers and fuzzy relationship between gray zone  $Z^i = C_U^i - O_L^i$ , more than the experts would assess the scope of project zone optimistic perception and conservative cognition is the geometric mean of the  $M^i = O_M^i - C_M^i$ , said the expert opinions interval value, resulting in no consensus fuzzy segments, namely extreme values give expert advice, and the views of other experts difference is too large, leading to differences of opinion diverge. Therefore, it must be less than the geometric mean of these convergence assessment project optimistic perception and conservative cognition, providing expert reference and repeat steps 1 through 4, the next survey, to assess the project until all have reached convergence, and to calculate the consensus importance of value.

### 3.2 Questionnaire

6	Блокчейн мэдлэг, түүний ашиглалт		.793		6	Сэтгэл хөдлөлөө удирдах, ёс зүйтэй байдал	.511	.633	
7	Кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг		.751		7	Тодорхойгүй байдалд дасан зохицох чадвар	.557	.619	
8	Хиймэл оюун ухааны ашиглах чадвар		.697		8	Дижитал технологи ашиглах чадвар		.800	
9	Дижитал технологи ашиглах чадвар		.682		9	Хиймэл оюун ухааны ашиглах чадвар		.831	
10	Гадаад хэлний мэдлэг		.677		10	Том өгөгдөл дээр дүн шинжилгээ хийх чадвар		.757	
11	Том өгөгдөл дээр дүн шинжилгээ хийх чадвар		.638	.515	11	Кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг		.815	
12	Хууль эрх зүйн мэдлэг			.764	12	Үүлэн тооцоололын мэдлэг		.715	
13	Татварын талаарх мэдлэг			.762	13	Блокчейн мэдлэг, түүний ашиглалт		.626	
14	Олон улсын стандартын мэдлэг	.394	.475	.498	14	Олон улсын стандартын мэдлэг		.838	
Total		4.332	4.323	2.767	Total		4.580	5.020	
% of Variance		25.481	25.432	16.275	% of Variance		32.713	35.857	
Cumulative %		25.481	50.913	67.188	Cumulative %		32.713	68.569	
KMO=.874 Bartlett's Test of Sphericity=1239.327(.000)					KMO=.877 Bartlett's Test of Sphericity=492.435(.000)				

Даяарчлалын эринд бий болж байгаа нягтлан бодогчийн шаардлагатай ур чадваруудыг тодорхойлсон судалгаанууд нэлээдгүй хийгдэж байгаа ба энэхүү судалгаандаа манай улсын хувьд 1) нягтлан бодох бүртгэлийн салбарт ажиллаж буй мэргэжилтэнгүүдийн өөрсдийн ур чадварыг, 2) ажил олгогч болон удирдах албан тушаалтнаас нягтлан бодогчдын ур чадварыг үнэлсэн асуулгын судалгааг ашиглан фактор хайх шинжилгээ хийсэн. Нягтлан бодогчдоос шаардаж буй эрэлттэй 14 төрлийн ур чадваруудаар 111 нягтлан бодогч нараас өөрсдийн ур чадварыг, 45 ажил олгогч болон удирдлагын түвшний менежерүүдээс тухайн компанид ажиллаж буй нягтлан бодогч нарын ур чадварыг үнэлүүлж, фактор хайх шинжилгээг хийж, үр дүнг хүснэгт 1 харуулав. Ур чадваруудыг харилцан хамааралтай байдлаар нь цөөн тооны факторт нэгтгэх замаар хүчин зүйлийн шинжилгээг хийж, өгөгдөл нийцтэй буюу тохирох эсэхийг нь Kaiser Meyer Olkin тестээр, бүлэг хувьсагч бүрийн хувьд хамаарлыг Bartlett's test of sphericity тестээр, хүчин зүйлийн шинжилгээг их вариациаас бага вариаци руу эрэмбэлэх (Principal components) аргыг ашигласан. Хүснэгт 1-ээс харахад нягтлан бодогчдын ур чадвараа үнэлсэн асуулгад Kaiser Meyer Olkin тест 0.874 ( $p < .000$ ), удирдлагууд нягтлан бодогчдын ур чадварыг үнэлсэн асуулгад Kaiser Meyer Olkin тест 0.877 ( $p < .000$ ), байна. Факторын ачааллын утгаар

хувьсагчдын хамаарлыг хэмжихэд учир дутагдалтай учир хүчин зүйлийн шинжилгээний төгсгөлд фактор эргүүлэлтээр (Varimax Orthogonal Rotation) хувьсагчдыг тодорхой ангилж, асуулга тус бүрт 14 үзүүлэлтийг шалгуур хангасан 3 бүлэг хүчин зүйлд хуваасан. Нягтлан бодох бүртгэлийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдээс авсан асуулгад хүчин зүйл 1 буюу зөөлөн ур чадвар нь 25.5%, хүчин зүйл 2 буюу технологийн ур чадвар нь 25.4%, хүчин зүйл 3 буюу бусад мэдлэг нь 16.3% буюу нийт ур чадварын үзүүлэлтийн 67.2%-ийг нь тайлбарлаж байна. Ажил олгогч болон удирдах албан тушаалтнаас нягтлан бодогчдын ур чадварыг үнэлүүлсэн асуулга нь нягтлан бодогчдоос авсан асуулгаас ялгаатай 2 бүлэгт ангилагдсан. Зөөлөн ур чадвар 32.7%, технологийн ур чадвар 35.9% буюу нийт ур чадварын үзүүлэлтийн 68.6% -ийг тайлбарлаж байна. Ажил олгогч нарын хувьд нягтлан бодогч нарын ур чадварыг үнэлэхдээ мэргэжлийн мэдлэг өндөр байхыг шаардахгүй байна. Өөрөөр хэлбэл тухайн ажлын байрандаа өөрийн хариуцсан ажлаа л хийж чадаж байвал мэргэжлийн хувьд хангалттай гэж үзэж байна.

Факторын эргүүлэлт нь тухайн асуумжийн ачаалал өндөр байх тусам хүчин зүйлийн хэмжээсдээ хүчтэй эерэг хамааралтай ба фактор ачааллын хувьсагч нь 0.4-өөс их бол ач холбогдолтой, 0.5-аас дээш бол чухал ач холбогдолтой гэж үзнэ.

Мөн шинжилгээг хийхдээ давхар ачаалал үүсгэсэн 2 хувьсагчдийг хассан. Олон улсын стандартын мэдлэг нь 2 асуулгад ижил давхар ачаалал үүсгэн байгаа нь уг ур чадварыг 2 асуулгад хариулагчид

өөр өөрөөр ойлголт төрүүлсэнг харуулж байна. Ур чадвар бүрийн фактор ачааллын утга нь 0.569-0.838 хооронд байгаа нь хүчин зүйлс нь хүчин зүйлийн хэмжээсд хүчтэй эерэг хамааралтай байна.

### Хүснэгт 2. Найдвартай байдлын шинжилгээ

	<b>n</b>	<b>Найдвартай байдал</b>
Нягтлан бодогчдийн үнэлсэн ур чадвар	14	.927
Ажил олгогчийн үнэлсэн ур чадвар	14	.950

Судалгааны найдвартай байдлыг шалгасан үр дүнг хүснэгт 2-д харуулав. Нягтлан бодогчийн ур чадварын үнэлгээг илэрхийлэх үзүүлэлтүүд нь хувьсагчаа хэрхэн илэрхийлснийг харуулах Кронбахын альфа коэффициент нь нягтлан бодогчдоос авсан асуулганд 0.927, ажил олгогч болон удирдах албан тушаалтнаас авсан асуулганд 0.950 гарсан нь тухайн хувьсагч,

түүний доторх дэд үзүүлэлтүүд нь нийцтэй байгааг илэрхийлж байна.


Нягтлан бодогч мэргэжилтэнг бэлтгэж буй өнөөгийн хөтөлбөрт тусгагдсан мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх 23 хичээлд нийт 205 ур чадвар тусгагдснаас СТОУС, Аудит, Дунд шатны нягтлан бодох бүртгэл хичээлүүдийн ур чадварын давхцал хамгийн их байна.

### Хүснэгт 3. Ур чадварын харьцуулалт

<b>Ур чадвар</b>	<b>1-р курс</b>	<b>2-р курс</b>	<b>3-р курс</b>	<b>4-р курс</b>
Зөөлөн ур чадвар	23.01%	2.78%	28.15%	46.06%
Технологи ашиглах чадвар	25.00%	20.83%	33.33%	20.83%
Бусад ур чадвар /мэргэжлийн мэдлэг олгох ур чадвар/	0.00%	5.56%	46.67%	47.78%

Судалгаагаар тодорхойлогдсон ур чадвар нь нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд курс тус бүрээр хэрхэн тусгагдсан байдлыг хүснэгт 3-т харуулав. Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн өөрийн

үнэлгээний тайлан дахь зөөлөн ур чадварыг 1, 2, 3-р курсэд, технологи ашиглах ур чадварыг бүх курсэд, мэргэжлийн мэдлэг олгох ур чадварыг 3, 4-р курсэд илүү олгож байна.




Зураг 7. Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр олгох ур чадвар

Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт тусгагдсан мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрт тусгагдсан ур чадварыг зураг 7-д харуулав. Орчин үед нэн шаардлагатай байгаа блокчейн, дижитал технологи, кибер аюулгүй байдлын талаарх гүнзгийрүүлсэн мэдлэгийг төгсөх курсэд тодорхой хэмжээгээр оруулах шаардлагатай байна. Харин ажил олгогч нарын шаардаж буй зөөлөн ур чадварууд нь бүх курс, тэр дундаа төгсөх

курсийн хөтөлбөрт хангалттай тусгагдсан байна.

Нягтлан бодогчийн ажлын байранд тавигдаж буй шаардлагад судалгаагаар тодорхойлогдсон ур чадвар хэрхэн тусгагдаж байгааг тодруулах зорилгоор ажлын зарын сайт болох <https://www.zangia.mn/>-д 2021.09.15-10.15 хооронд тавигдсан нягтлан бодогч ажилд авах зарыг шүүж, судалгаанд давхардалгүй тоогоор 105 байгууллагын тавьсан зарын мэдээлэлд контент анализ хийсэн.




Зураг 8. Ажил олгогчоос нягтлан бодогч ажилд авахад шаардагдах чадвар

Ажил олгогчоос нягтлан бодогч ажилд авахад шаардагдах чадварын жагсаалтыг зураг 8-д харуулав. Судалгаанаас үзэхэд нягтлан бодогч нь ямар салбарт ажиллах эсэхээс үл хамааран ажлын байранд тавигдах ур чадварын шаардлага нь ижил байна. Нийт ажлын зард тавигдаж буй шаардлагад сэтгэл хөдлөлөө удирдах, ёс зүйтэй байдал 75.2 хувь, дижитал технологи ашиглах чадвар 69.5 хувь, харилцааны өндөр ур чадвар 66.7 хувь, асуудал шийдвэрлэх чадвар 58.1 хувь байгаагаас харахад нягтлан бодогч анх ажилд ороход мэргэжлийн ур чадвараас илүүтэй зөөлөн ур чадвар маш чухал байна. Харин хиймэл оюун ухаан ашиглах чадвар, кибер

аюулгүй байдлын талаарх мэдлэг, блокчейн мэдлэг, түүний ашиглалт зэрэг ур чадварууд нь ажлын байранд тавигдах шаардлагад тусгагдаагүй байгаа нь тухайн нягтлан бодогч ажлын байранд очсон хойноо эзэмших чадвар байж болох талтай юм.

Ажил олгогчдын зүгээс танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнуудын ур чадварыг дүгнэсэн байдлын үнэлгээг Мандах их сургууль нь жил бүр авдаг бөгөөд сүүлийн 2 жил цар тахалтай холбоотойгоор энэ судалгааг аваагүй болно. Тиймээс энэхүү судалгаанд 2019 оны судалгааны үр дүнг ашигласан болно.





Зураг 9. Дадлага хийсэн оюутнуудын ур чадварыг үнэлсэн байдал

Ажил олгогчид танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнуудын ур чадварыг үнэлсэн үнэлгээний үр дүнг зураг 9 харуулж байна. Судалгаанаас харахад оюутнуудын мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байдал болон бусад ур чадварууд харьцангуй сайн гэж үнэлэгдсэн бөгөөд харин мэргэжлийн чиглэлийн хуулийн мэдлэгийг илүү сайн судлах, нийгмийн өөрчлөлтөнд дасан зохицох чадвар, харицлагатай байх чадвар болон шинээр бий болж буй ур чадваруудыг хурдан эзэмшихэд нь илүү анхаарах хэрэгтэй байгааг дурдсан байна.

## 1. ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн IY хувьсгалын үед олон шинэ ур чадваруудын хэрэгцээ бий болж, түүнийг эзэмших шаардлага нягтлан бодогчдод тулгарч байна. Энэхүү судалгааны зорилго нь ирээдүйд нягтлан бодогчдоос шаардагдах ур чадварыг тодорхойлж, нягтлан бодогчдын ур чадварын түвшний өнөөгийн байдал нь нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөртэй нийцтэй байгаа эсэхийг үнэлэхэд оршино. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

1. Системт тойм шинжилгээнд хамрагдсан судалгаанд нягтлан бодогчдод шаардлагатай 17 ур чадварыг тодорхойлсон байна. Дээрх ур чадваруудаас хамгийн

- олон давтагдаж буй нь хиймэл оюун ухааныг ашиглах чадвар, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх чадвар нь нягтлан бодогчдод хамгийн өндөр хэрэгцээтэй гэж тодорхойлсон. Дэлхийн эдийн засгийн форумоос 2025 онд хамгийн эрэлт хэрэгцээтэй байх 10 ур чадвар нь бидний судалгааны үр дүнтэй ижил байна.
2. Хиймэл оюун ухааны нөлөөлөл нь нягтлан бодогчдод эзэмшвэл зохих зөөлөн болон технологийн ур чадвар үүсч буйг библиометрийн анализ харагдаж байна.
  3. Нягтлан бодогчдод шаардлагатай ур чадваруудыг үнэлсэн үнэлгээ нь 1) зөөлөн ур чадвар, 2) технологийн ур чадвар, 3) бусад ур чадвар гэж 3 бүлэгт ангилагдсан ба ажил олгогчид нягтлан бодогчдоос технологийн ур чадвар болох дижитал технологи ашиглах, хиймэл оюун ухаан ашиглах, их өгөгдөл дээр ажиллах, кибер аюулгүй байдлын болон үүлэн технологийн талаархи мэдлэг гэх мэт шинээр бий болж буй ур чадваруудыг илүүд үзэж байна. Харин нягтлан бодогчид асуудал шийдвэрлэх чадвар, харилцааны ур чадвар, тодорхойгүй байдалд дасан зохицох чадвар, сэтгэл хөдлөлөө удирдах ёс зүйтэй байх чадвартай байх зэрэг зөөлөн ур чадварууд өөрсдөд нь илүү байх шаардлагатай гэж үзэж байна.
  4. Нягтлан бодогч мэргэжилтэнг бэлтгэдэг хөтөлбөрт нийт 205 ур чадвар тусгагдсанаас 49.8% нь мэргэжлийн мэдлэг олгох ур чадвар, 25.3% нь зөөлөн ур чадвар, 24.9% нь орчин үед шаардагдаж буй техник, технологитой холбоотой ур чадвар байна. Цаашид хөтөлбөрт сайжруулалтыг хийхдээ орчин үед шаардагдаж буй ур чадварыг илүү нарийвчилсан байдлаар тусгах шаардлагатай байна.
  5. Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрөөр олгож буй ур чадвар нь курс тус бүрээр нь харахад 1 болон 2-р курсэд технологи ашиглах чадвар, 3 болон 4-р курсэд мэргэжлийн мэдлэг олгох чадварыг оюутнуудад илүү олгож байгаа нь хөтөлбөрт сайжруулалтыг хийхдээ технологи ашиглах ур чадвар болон зөөлөн ур чадварыг хичээл бүрийн онцлогт тохируулан жигд олгох шаардалагатайг харуулж байна.
  6. Нягтлан бодогч мэргэжлийн ажлын байранд тавигдах шаардлага нь аль салбарт ажиллахаас үл хамааран сэтгэл хөдлөлөө удирдах, ёс зүйтэй байдал 75.2%, дижитал технологи ашиглах чадвар 69.5%, харилцааны өндөр ур чадвар 66.7%, асуудал шийдвэрлэх чадвар 58.1% байгаа нь бидний санал асуулгын судалгааны үр дүнтэй тохирч байна. Харин хиймэл оюун ухааны ашиглах чадвар,

кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, блокчейн мэдлэг, түүний ашиглалт зэрэг ур чадварууд нь нягтлан бодогчдыг ажилд авахад шаардлагагүй бөгөөд харин нягтлан бодогчоор ажиллах үед зайлшгүй шаардлагатай ур чадвар байгаа нь харагдаж байна.

7. Ажил олгогчдын зүгээс танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнуудын ур чадварыг дүгнэсэн байдлыг үнэлсэн судалгаанаас мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байдал маш сайн, гэхдээ мэргэжлийн чиглэлийн хуулийн мэдлэгийг илүү сайн судлуулах, нийгмийн өөрчлөлтөнд дасан зохицох чадвар, харицлагатай байх чадвар болон шинээр бий болж буй ур чадваруудыг

хурдан эзэмшихэд нь илүү анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Энэхүү судалгааны ажлыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт дараах чиглэлийг тусгах боломжтой гэж санал болгож байна. Үүнд:

1. Хичээлийн хөтөлбөрийн хөгжүүлэлт хийхдээ оюутнуудад олгох ур чадвар хандлагыг курс тус бүрээр тодорхой харьцаатай оруулах
2. Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийг боловсролын олон улсын стандарттай нийцүүлж сайжруулах
3. Үр дүнд суурилсан боловсрол олгох хөтөлбөрийг сайжруулах
4. Чадамжийг үнэлэх систем нэвтрүүлэх

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Crookes, L., & Conway, E. (2018). Technology challenges in accounting and finance. In *Contemporary issues in accounting* (pp. 61-83): Springer.
2. Dewi, L. G. K., Dewi, N. A. W. T., & Herawati, N. T. (2020). Young Accountant's Skills on 4.0: Ready or Not? Paper presented at the 5th International Conference on Tourism, Economics, Accounting, Management and Social Science (TEAMS 2020).
3. Hood, T. (2020). 7 Skills Every Accountant Needs in the Age of Automation
4. Kruskopf, S., Lobbas, C., Meinander, H., Söderling, K., Martikainen, M., Lehner, O. J. A. J. o. F., & Perspectives, R. (2020). Digital accounting and the human factor: theory and practice.
5. Malinga, S. Blockchain technology: an examination of use-cases in the accounting profession.
6. Stancheva-Todorova, E. (2019). The Knowledge and Skills Profile of Accountant 4.0. Paper presented at the 11th International Conference

- “Digital Transformation of the Economy and Society: Shaping the Future”, Prilep, North Macedonia.
7. Stancheva-Todorova, E. J. I. (2019). are accounting educators ready to embrace the challenges of industry 4.0. 4(6), 309-312.
  8. Hood, T. (2020). 7 Skills Every Accountant Needs in the Age of Automation
  9. Энх-Амгалан, Л. (2017). *Өдрийн сонин*.
  10. Сангийн яам – Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл-Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмж судалгааны тайлан (2021 )

Article info: Mandakh Research, 2021, Vol.06, BUS 604

## ФЕЙСБҮҮК ХЭРЭГЛЭГЧДИЙГ ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛЖ СЕГМЕНТЧЛЭХ НЬ

(“Z” үеийнхний хүрээнд)

Б.Сайнжаргал<sup>1a</sup>, М.Жанузах<sup>2b</sup>

<sup>1,2</sup>Мандах Их сургууль, Инженер-Эдийн Засгийн сургууль,  
Эдийн засаг бизнесийн тэнхим

<sup>a</sup>[sainjargal@mandakh.edu.mn](mailto:sainjargal@mandakh.edu.mn), <sup>b</sup>[januzakh@mandakh.edu.mn](mailto:januzakh@mandakh.edu.mn)

### Хураангуй

Өргөн хэрэглээний социал суваг болох “фэйсбүүк”-ийг хэрэглэгчид ямар зорилгоор ашиглаж буйг тодруулахын тулд тэдний хэрэгцээнд үндэслэн сегментчлэх оролдлого хийсэн болно. Судалгаанд “фэйсбүүк” хэрэглэгчдээс санамсаргүй байдлаар “Z” үеийнхний 419 төлөөллийг онлайн хэлбэрээр түүвэр болгон оролцуулж, үр дүнг SPSS програм дээр боловсруулахдаа фактор шинжилгээгээр хувьсах хэмжигдэхүүнийг (variables) үнэлж, кластер шинжилгээгээр объектуудын ялгаатай байдлаар сегмент үүсгэн, сегмент хоорондын ялгааг хи-кв шинжүүрээр хэмжиж, үр дүнг тодорхойлсон болно.

**Түлхүүр үг:** сегментчлэл, сэтгэл зүй, социал харилцаа, социал суваг

## ОРШИЛ

Орчин цагт хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэрэгцээний салшгүй нэг хэсэг нь сошиал харилцаа тэр дундаа “фэйсбүүк” болсон билээ. Монгол улсын хувьд “фэйсбүүк” хэрэглэгчдийн тоо 2,7 саяд хүрсэн ба өнөөдөр насанд хүрсэн иргэдийн 68% нь буюу 2,2 сая нь уг платформыг хэрэглэдэг гэх албан бус тоог ЦЕГ-аас мэдээлсэн байдаг. Уг сошиал сувгийг хүмүүс чөлөөт цагаа өнгөрөөх, бусадтай харилцах, нийгэмд өөрийгөө танилуулах зэрэг зорилгоор түгээмэл ашигладаг гэсэн таамаглалыг дэвшүүлж энэхүү судалгааг хийхээр зорьсон юм. Уг таамаглалыг шалгахын тулд сошиал суваг хэрэглэгчдийг хэрэгцээ дээр нь үндэслэн сегментчлэх нь зүйтэй гэж үзсэн. Зах зээлийн сегментчлэл гэдэг нь аливаа бүтээгдэхүүнд хандах хэрэглэгчдийн харилцан адилгүй хариу үйлдлүүдэд үндэслэн ижил төстэй шинжээр нь бүлэглэн улмаар хэд хэдэн жижиг зах зээл болгон хуваах тухай ойлголт (R.Smith, 1956) мөн “зах зээлийг тодорхой хэсэг болгон хуваах” маркетингийн суурь үйл явц (A.Garolina Tynan, 1987) гэж судлаачид тодорхойлдог. Зах зээлийг сегментчлэн оновчтой сегментүүдийг тодорхойлсноор маркетингийн менежерүүд үр дүнтэй шийдвэр гаргахад ихээхэн дөхөм болдог. Тэгвэл уг үйл явц нь шат дараалласан системтэй алхам

бөгөөд зах зээлийг сегментчлэх, сегментийг үнэлэх, сонгох гэсэн 3 үндсэн хэсгээс бүрддэг хэдий ч судлаач Roger Best (1990)-ийн боловсруулсан сегментчлэлийн долоон үе шат бүхий алхам нь хэрэглэгчдийн хэрэгцээнд үндэслэсэн бөгөөд нэг сегмент нь нөгөөгөөс хүн ам зүйн эсвэл хэрэглэгчийн зан төлөвийн хувьд ямар ялгаа байгааг онцолсон (Sulekha, 2011) бол судлаач Myers (1996) болон Charles W.Lamb, Carl McDaniel (2003) нар нь маркетингийн иж бүрдлийг хэрхэн боловсруулан төлөвлөх асуудлыг багтаасан сегментчлэлийн зургаан үе шаттай алхамыг санал (H.Myers, 1996) болгож өөр өөрийн өнцгөөс тайлбарласан байдаг. Гэхдээ тэд сегментчлэлийн эхний алхам болох тухайн зах зээлийн сегментийг тодорхойлох үндсэн үзүүлэлт буюу хувьсах хэмжигдэхүүнүүдийг сонгох явдал нь илүү чухал гэдэг дээр санал нэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдийн ямар ижил шинж чанараар бүлэглэх талаарх асуудал юм. Тийм ч учраас судлаач Котлер, Келлер нарын зах зээлийг хүн ам зүй, газар зүй, сэтгэл зүй, зан төлөв гэсэн үзүүлэлтээр сегментчлэх үзэл баримтлалыг илүү дэмждэг. Гэсэн хэдий ч үүнийг анх системтэйгээр ангилсан судлаачид бол Wind, Frank болон Massy(1972) нар бөгөөд тэд сегментчлэлийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар дэлгэрэнгүй ангилж бүлэглэсэн (Frank, 1972) байдаг.

*Хүснэгт 1. Сегментчлэлийн үндсэн үзүүлэлт, Wind, Frank болон Massy (1972)*

	Ерөнхий үзүүлэлт	Бүтээгдэхүүний онцлог
Мэдэгдэхүйц (Observable)	- Соёл - Хүн ам зүй - Газар зүй - Нийгэм-Эдийн засаг	- Брэндийн үнэнч байдал - Хэрэглэгчийн үнэнч байдал - Хэрэглэгчийн нөхцөл байдал - Хэрэглээний давтамж
Үл мэдэгдэхүйц (Unobservable)	- Амьдралын хэв маяг - Зан төлөв - Сэтгэл зүй - Үнэ цэнэ	- Хандлага - Ойлголт - Танин мэдэхүй - Эрхэмлэх байдал

Эх сурвалж: Michel Wedel & Wagner A. Kamakura, 2000, Second edition, *Market Segmentation Conceptual and Methodological Foundation*. Kluwer Academic Publishers, Boston Dordrecht London, 7 p.

Дээрх үзүүлэлтийн ямар шинж чанарыг сонгосноос хамаарч өгөгдлийг бүлэглэх статистик арга зүйг сонгодог. Энэ удаагийн судалгаанд “фэйсбүүк” хэрэглэгчдийг хэрэгцээн дээр үндэслэн сегментчлэхээр сонгосон тул энэ хэмжигдэхүүн нь сэтгэл зүйн сегментчлэлийн нэг хэсэг болох юм.

“Сэтгэл зүйн үйл явц түүнийг нарийн тодорхойлоход төвөгтэй” (R.Ziff, 1971) төдийгүй “Сэтгэл зүй нь хэрэглэгчдийг сэтгэл зүйн тодорхой хэмжээс дээр байрлуулах тоон оролдлого юм” (D.Welss, 1975) гэж дүгнэсэн байдаг. Энэхүү сэтгэл зүйн сегментчлэл нь *хувь хүний зан төлөв, итгэл, үнэ цэнэ, амьдралын хэв маяг* зэрэг хүчин зүйлсийг харгалзан зах зээлийг сегментчилдэг үзүүлэлт. Судлаач Daniel Yenkelovich (1964) сэтгэл судлалын ойлголтуудыг “Зах зээлийн сегментчлэлийн шинэ шалгуур” болгох саналыг анхлан дэвшүүлсэн цагаас эхлэн хэрэглэгчдийг *нас, хүйс,*

*боловсролын түвшин, орлого* зэрэг хүн ам зүйн уламжлалт шинж чанаруудаар сегментчлэх нь хангалттай бус гэж судлаачид үзэх болсон. Тиймээс *сонирхол, үнэ цэнэ, эрхэмлэн дээдлэх зүйлс* зэрэг нь хэрэглэгчдийн худалдан авалтад илүү хүчтэй нөлөөлдөг (Goyat, 2011) хэмээн дүгнэж эдгээр хэмжигдэхүүнээр зах зээлийг сегментчлэх оролдлого хийж эхэлсэн билээ. Мөн 1960 –аад оны судалгааны бүтээлүүдээс үзвэл Harrison L. Grathwohl, Edward L. Grubb(1967) нар хувь хүний зан төлөв тэр дундаа сэтгэл зүйн үндсэн ойлголтуудыг анх ашигласан (Edward L. Grubb, 1967) бөгөөд үүнээс хойш олон судлаачид сэтгэл зүйн үзүүлэлтүүдээс *хандлага, итгэл, үр нөлөө, танин мэдэхүйн, хэрэгцээ* зэрэг ойлголтуудад тулгуурлан зах зээлийг сегментчлэх оролдлого хийж (H. Onur Bodur, 2000) байжээ.

Харин 1990 оны судлаачдын *бүтээлээс харвал* Piirto (1991) сэтгэл зүйн сегментчлэл бол зах зээлийг

хэрэглэгчийн хандлага, үзэл бодол, итгэл үнэмшил, хувь хүний зан чанар болон амьдралын хэв маягт нь үндэслэн тус тусад нь бүлэглэх үйл явц (Matthew, 2010), мөн Gunter, Furnham(1992) нар үнэ цэнэ, хандлага, амьдралын хэв маяг болон сонирхол зэрэг хүчин зүйлсийг багтаадаг (Gunter, 1992), Weinstein(1994) амьдралын хэв маяг эсвэл хандлагад тулгуурлаж сегментчлэх үйл явц (Weinstein, 2006) хэмээн илэрхийлсэн байна. Зарим судлаачид сэтгэл зүйн сегментчлэл бол амьдралын хэв маягийг хэмжих үйл явц хэмээн тодорхойлсон (Demby 1994) бол амьдралын хэв маяг нь хэрэглэгчийн зан төлөвийг тодорхойлох үндсэн хүчин зүйл (Narang, 2009) мөн гэж үзсэн бөгөөд Kotler нь (1997) хувь хүний шинж чанар болон амьдралын хэв маяг дээр үндэслэн хэрэглэгчийг ялгаатай бүлгүүдэд хувааж, ангилал нь сэтгэл зүйн сегментчлэл (Lin, 2002) гэж тус тус илэрхийлсэн байдаг. Харин Pearce, Morrison&Rutledge (1998) нар сэтгэл зүйн сегментчлэл бол зах зээлийг амьдралын хэв маяг болон хувь хүний зан чанар дээр үндэслэн бүлэглэдэг ба энэ нь хэрэглэгчдийн сонирхол, хэрэгцээ, хандлага, итгэл үнэмшил, үзэл баримтлал болоод үнэ цэнээр бүлэглэдэг арга юм (Mohamed, 2005) гэж тодорхойлсон.

Ерөнхийд нь дүгнэвэл, сэтгэл зүйн сегментчлэл нь ихэвчлэн хэрэглэгчдийн амьдралын хэв маяг дээр үндэслэж зорилтот зах зээлийг

тодорхойлдог бөгөөд үүнийг тодорхойлсон олон загвар судалгаанууд байдгаас бидний сайн мэдэх нь AIO, LOV, RVS, VALS зэрэг юм. Харин нөгөө урсгал нь хэрэглэгчийн ойлгоц, зан чанар, сэдэл, хэрэгцээ зэрэг хувь хүний сэтгэл зүйн онцлогт тулгуурлан ижил төсөөтэй байдлаар сегментчилдэг байна. Сэдэл, хандлага, ойлгоц нь хэрэглэгчийн худалдан авах шийдвэр гаргалтанд нөлөөлж буй чухал ач холбогдолтой гэдгийг судлаачид тодорхойлсон байдаг. (Wahyuni, 2008; Akbar,2010;Utami, 2010). Бизнесийн бүхий л салбарт сэдэл бол хэрэглэгчийн худалдан авах үйл явцын хамгийн чухал үүрэг гүйцэтгэгч болдог. Улмаар сэдэл нь сэтгэл ханамж, тааламжтай байдлыг эрэлхийлэх хүчтэй нөлөөлөл болохуйц хувь хүний хэрэгцээнээс үүсэлтэй. (Kotler & Amstrong, 2011, p. 147). Өөрөөр хэлбэл сэдэл нь хэрэгцээнээс хамаарч бий болдог. Харин хэрэгцээ нь хүмүүсийг үйлдэл хийлгэх, улмаар сэтгэл ханамжийг бий болгох хэрэгцээгээ хангахад хүргэдэг байна. Иймд судлаач Schiffman & Wisenblit (2015) нарын “Хэрэглэгчийн худалдан авах шийдвэртэй холбоотойгоор хэрэглэгчийн сэтгэлзүйн хүчин зүйл болох хүсэл, сэдэл, ойлгоц, хандлага зэрэг нь хэрэглэгчийн худалдан авах шийдвэрт ихээхэн нөлөөлдөг гол шийдвэрлэгч” гэж тодорхойлсон (Gunawan, 2015) үндэслэлийн дагуу энэхүү судалгаанд “фэйсбүүк” хэрэглэгчдийг “сэдэл”-ийн



“хэрэгцээ” хэмээх хувьсах хэмжигдэхүүнээр бүлэглэх боломжтой эсэх талаар судлахаар зорьсон юм.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Зах зээлийн сегментчлэлийн шалгуурыг системтэй судалсан эрдэмтэд бол Wind, Frank, Massy нар юм. Харин орчин үед онолын хүрээнд түгээмэл хэрэглэж буй ангиллыг Kotler, Armstrong, Saunders, & Wong нар дэвшүүлсэн бөгөөд сегментчлэлд хамгийн өргөн ашиглагддаг нь *хүн ам зүй, газар зүй, сэтгэл зүй болон зан төлөвийн* шалгуурууд юм. Ихэнхдээ зах зээлийн сегментчлэлд хүн ам зүйн хүчин зүйлс ялангуяа насны ангилалыг бусад хүчин зүйлтэй харьцуулан авч үздэг. Хүн амыг

насаар нь сегментчлэхдээ “нэгэн үеийнхэн” гэдэг ойлголтыг түгээмэл ашигладаг болсон. Тухайлбал, судлаач Oblinger and Oblinger нарын 2005 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнд 1995 оноос хойш, судлаач Reeves and Oh нарын 2008 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнд 2001 оноос хойш төрсөн бол “Z” үеийнхэн гэж тодорхойлно гэсэн байдаг.

2020 оны жилийн эцсээр Монгол улсын хүн амын тоо 3,357,542, эндээс насны бүлгээр авч үзэхэд эх олонлог болох 18-24 насны иргэдийн тоо 325,895<sup>1</sup> буюу нийт хүн амын 9,7 хувийг эзлэж байна. Улмаар эх олонлогт тулгуурлан түүврийн зохистой хэмжээг доорх аргачлалын дагуу тооцсон болно.

*Түүврийн хэмжээг тооцох аргачлал*<sup>2</sup>

$$S_s = \frac{z^2 * p * (1-p)}{c^2} = \frac{1.96^2 * 0.097 * (1-0.097)}{0.03^2} = 373.8$$

Түүврийн хэмжээг 95 хувийн итгэх түвшинд, алдааны магадлал 3 хувь байхаар тооцоход хамгийн багадаа 374 түүвэр олонлог байхаар тодорхойлогдсон болно. Улмаар энэхүү судалгааны ажлын хүрээнд судлаач Wei Shao, Mitchell Ross, Debra Grace (2015) нарын Marketing Intelligence & Planning сэтгүүлд

нийтлүүлсэн "Developing a motivation-based segmentation typology of Facebook users" өгүүллэгт ашигласан асуулга загварыг туршсан болно. Уг асуулга нь фэйсбүүк хэрэглэгчдийг харилцаа холбоо, чөлөөт цаг, байр суурь илэрхийлэх байдал болон мэдээлэл хайх гэсэн үндсэн 4

<sup>1</sup> [http://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_0300\\_071V3&Group\\_select\\_all=0&GroupSingleSelect=\\_10404\\_10405\\_10501\\_10502\\_10503\\_10504\\_10505&Sex\\_select\\_all=0&S](http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect=_10404_10405_10501_10502_10503_10504_10505&Sex_select_all=0&S)

*exSingleSelect=\_1&YearY\_select\_all=0&YearYSingleSelect=\_2020&viewtype=table*

<sup>2</sup> <https://www.surveysystem.com/sample-size-formula.htm>

сегментэд бүлэглэх 13 асуултаас бүрддэг болно.

Асуулгын судалгаагаар сэтгэл зүйн хувьсах хэмжигдэхүүнийг оновчтой илэрхийлсэн эсэхийг шалгадаг арга нь фактор шинжилгээ юм. *Фактор шинжилгээ* нь олон тооны хувьсах хэмжигдэхүүнүүдийн хоорондын харилцан хамаарлыг үзүүлдэг ба ерөнхий суурь хэмжээсүүдийн нөхцөл дэх хувьсагчуудыг тайлбарладаг (Mitchel, 1994). Олон хэмжээст статистикийн техник шинжилгээний тухайн арга нь судалж буй багц өгөгдлүүдийн доторх бүтцийг тодорхойлдог онцлогтой (W.Stewart, 1981) бөгөөд өгөгдлийг багасгах зорилготой. PCA арга нь хувьсах хэмжигдэхүүнүүдийг жигнэсэн дундаж утгаар нэгтгэж бүлэг үүсгэдэг бол EFA нь бүлгээс гаргах буюу тодорхой бус бүтэц эсвэл анзаарагдаагүй моделиудыг загварчилдаг солигддог техник юм. Өөрөөр хэлбэл PCA нь тохирох асуулгуудыг оновчтой бүлэгт байршуулдаг бол EFA нь хүчин зүйлийг илэрхийлэх асуулгыг бий болгодог. Хэрэглэгчдээс авсан асуулга өгөгдлийг ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгцээн

дээр үндэслэн сегментчлэл хийхдээ кластер шинжилгээг ашигласан.

Кластер шинжилгээ (W.Steward, 1981) нь хэрэглэгчдийг ижил шинж чанараар нь бүлэглэдэг шинжилгээ бөгөөд үндсэндээ 3 аргаас бүрддэг. Үүнд:

1. Шаталсан кластер
2. К-дунджын арга
3. Хоёр алхамт арга

Эдгээр аргын онцлог ялгаатай байдал нь шаталсан арга нь хэрэглэгчийг нэг л бүлэгт оруулж сегмент үүсгэдэг бол нөгөө хоёр арга нь нэг хэрэглэгчийг хэд хэдэн сегментэд хуваарьлаж болдог. Тэгвэл судлаач дээрх 3 аргаас алийг нь хэрэглэж зах зээлийг сегментчлэх вэ? гэдэг шийдвэр гаргахдаа хамгийн их сегмент үүсгэж буй арга зүйг харьцуулж шинжилсэний үндсэн дээр сонгосон болно.

Шаталсан кластерийн арга нь кластер хэмжигдэхүүнд ижил болон ижил бусаар нь объектуудыг бүлэглэхдээ хоорондын зайг харгалзан үздэг бөгөөд хамгийн ойр байгаа объектуудыг нэг бүлэгт оруулахыг Euclidean зай (шулуун шугам)-д хамаардаг. Уг зайг тооцохдоо дараах томъёогоор тооцоолно.

$$d_{Euclidean(B,C)} = \sqrt{(X_B - X_C)^2 + (Y_B - Y_C)^2}$$

Энэ арга нь шаталсан agglomerative кластерийн үйл явцын дагуу дээрээс доош буюу бүх

объектуудыг ижил шинж чанараар нь ялган хуваах замаар сегмент үүсгэдэг бол мөн доороос дээш

буюу объектуудыг ижил шинж чанараар нь бүлэглэн нийлүүлж, нэг бүлэгт багтаах замаар сегмент үүсгэдэг хоёр ялгаатай аргачлалтай. Ингэж сегмент үүсгэхдээ хавтгайн геометр дээрх объектуудын

хоорондын зайгаар нь хамааруулж бүлэг үүсгэдэг.

K-дунджийн арга нь кластер дахь хазайлтыг бага байлгах аргаар өгөгдлийг хуваадаг. Үндсэн томъёо нь дараах байдалтай<sup>3</sup> байна.

$$\sum_{i=1}^n \sum_{j=1}^k W_{ij} \|X_i - X_j\|^2$$

n = Өгөгдлийн цэгүүдийн тоо

k = Кластеруудын тоо

w<sub>ij</sub> = n×k 0-1 матриц

x<sub>i</sub> = i-өгөгдлийн цэгийн байршил

c<sub>j</sub> = j-р кластерын төв

N<sub>j</sub> = c<sub>j</sub> кластерт хамаарах өгөгдлийн цэгүүдийн тоо

K дундажын үйл явц нь урьдчилан тогтоосон тооны давталтад хүрэх эсвэл нэгтгэх хүртэл дахин давтана.

2 алхамт кластер нь хоёр үе шаттай арга дээр үндэслэсэн алгоритм бөгөөд эхний үе шат нь K дундаж алгоритмтай ижил байдлаар явагдаж, үр дүнд нь объектуудыг дарааллуулан нэг төрлийн кластерийн хэлбэрт оруулж, шаталсан agglomerative кластерийн үйл явцыг өөрчилдөг. Хоёр дахь үе шат дээрх үйл явц нь кластерийн тоог сонгох замаар категорийн болон үргэлжилсэн хувьсагчуудыг автоматаар бүлэглэдэг.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судлаачид нэгэн цаг үед амьдарч байсан хүмүүсийг амьдралын хэв маяг, тухайн үеийн нийгэм орчны хүчин зүйлээр нь хамааруулан насны үечлэлээр нь бүлэглэн хувааж судалгаанд хамруулдаг. Бид энэ удаагийн судалгаандаа “Z” үеийнхний төлөөлөл бүхий 419 түүврийг хамруулсан. Судалгааны үр дүнг SPSS 21 программ дээр боловсруулсан ба фактор бүрийн хувьд хангалттай хэмжээний хувьсагч хамрагдаж чадсан эсэхийг харуулдаг үзүүлэлт түүвэр эх олонлогоо төлөөлж буй байдал нь 85%-тай байна. Судалгааны асуулгын найдвартай байдлыг

<sup>3</sup> O.A. Mohamed Jafar and R. Sivakumar, (2014) “Distance Based Hybrid Approach for Cluster Analysis Using Variants of K-means and Evolutionary Algorithm”, Research

Journal of Applied Sciences, Engineering and Technology 8(11): 1355-1362, DOI:10.19026/rjaset.8.1107

шалгах буюу хэрэглэгчээс авсан тодруулах судалгааны хариултыг 1-5 бүхий хэмжигдэхүүнээр үнэлүүлэх байдлаар авч, уг хэмжигдэхүүний найдвартай байдлыг үнэлгээ Кронбахын альфа -

г тооцоход 0.908 гарсан нь судалгааны асуулгын хэмжүүр зөв, найдвартай бөгөөд үр дүн ач холбогдолтой болохыг тодорхойлж байна.

### Хүснэгт 2. Түүвэр эх олонлогоо төлөөлж буй байдал

Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.850
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	1492.783
	df	45
	Sig.	.000

### Хүснэгт 3. Өөрийн хүчин зүйлүүдэд хуваагдсан байдал

Total Variance Explained				
Component	Initial Eigenvalues			Rotation Sums of Squared Loadings <sup>a</sup>
	Total	% of Variance	Cumulative %	Total
1	3.468	43.344	43.344	2.999
2	1.176	14.705	58.049	2.337
3	1.083	13.536	71.585	1.991
4	.685	8.560	80.145	
5	.537	6.707	86.852	
6	.444	5.549	92.401	
7	.355	4.437	96.839	
8	.253	3.161	100.000	

Фактор шинжилгээний CFA шинжилгээний нийт үзүүлэлтийн 1.06 утгад харгалзах утга болох 3 факторт хуваагдах боломжтой гэдэг үр дүн гарсан. Энэ нь тухайн хэмжигдэхүүнийг өөрөөр нь факторт хуваасан үр дүн юм. 3 факторт хуваагдсан хүчин зүйлс нь нийт 8 хүчин зүйлийг 71.5%-тай төлөөлж байна. Мөн Cross Loading


утгыг 0.6-гаар авч хүчин зүйлсийг хамаарах факторт оруулсан болно. Улмаар судалгааны асуулга нь үндсэн 4 хүчин зүйлс бүхий 13 асуулттай байсан хэдий ч статистикийн харилцан хамаарлын техник болох фактор шинжилгээний үр дүнд зарим нэг хувьсах хэмжигдэхүүн нь хасагдаж дараах үр дүн гарсан болно.

*Хүснэгт 4. Фактор шинжилгээний үр дүн*

<b>Pattern Matrix<sup>a</sup></b>					
Cronbach's Alpha .808	Cronbach's alpha	Factor loadings	Mean	Std. Deviation	Cronbach's alpha if item deleted
Чөлөөт цаг өнгөрөөх	0.86				
q2.2 Миний хувьд “фэйсбүүк” ашиглах нь чөлөөт цагаа сонирхолтой өнгөрүүлэхэд тустай байдаг.		0.914	2.3437	1.13081	0.769
q2.3 “фэйсбүүк” хэрэглэснээр миний чөлөөт цаг зугаатай өнгөрдөг.		0.887	2.5943	1.13978	0.763
q2.1 Чөлөөт цагаараа хөгжилдөхөд “фэйсбүүк” ашиглах нь хамгийн тохиромжтой байдаг		0.838	2.778	1.13276	0.77
Харилцаа холбоо	0.652				
q1.2 Би ихэвчлэн “фэйсбүүк”ээр дамжуулан олны танил хүмүүстэй харилцах, тэдний талаар мэдээлэл авдаг.		0.848	3.1599	1.21424	0.799
q1.1 Би “фэйсбүүк”ээр дамжуулан мэдэхгүй зүйлсээ асууж бусдаас дэмжлэг туслалцаа авдаг.		0.776	3.8807	0.98072	0.802
q1.3 Би өдөр тутам “фэйсбүүк” хэрэглэснээр нийгмийн нэг хэсэг гэдгээ мэддэг.		0.602	3.1241	1.15285	0.785
Мэдээлэл хайх	0.717				
q4.1 Би ихэвчлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрэгцээт мэдээллийг “фэйсбүүк”ээс авдаг.		0.873	3.4368	1.00605	0.801
q4.2 Брэнд бүтээгдэхүүний талаар мэдээллийг “фэйсбүүк”ээр дамжуулан авах боломжтой байдаг.		0.871	3.5227	1.05872	0.798
Extraction Method: Principal Component Analysis. Rotation Method: Promax with Kaiser Normalization.					

Фактор шинжилгээний үр дүнд 0,6-ээс дээш үнэлгээтэй хувьсагчдыг үлдээж, түүнээс бага үнэлгээтэй үзүүлэлтийг хасаж “чөлөөт цаг өнгөрөөх” хувьсагчийг 3 асуулгаар, “харилцаа холбоо” хувьсагчийг 3 асуулгаар, “мэдээлэл хайх” хувьсагчийг 2 асуулгаар илэрхийлэх нь үр дүнтэй байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдээс авсан асуулга судалгааны үр дүнд дээрх

асуулгууд нь тухайн бүлэг дэх хувьсах хэмжигдэхүүнийг төлөөлж чадаж байна гэсэн үг юм. Нийт асуулгаас хасагдсан 5 асуулт нь судалгаанд оролцогчдын үнэлгээгээр хувьсах хэмжигдэхүүнийг төлөөлж чадахгүй байна. Хүснэгт 3-ийн фактор шинжилгээний үр дүнд үндэслэн кластер шинжилгээ хийхэд дараах сегментүүд үүссэн.



Зураг 1. Судалгааны үр дүнд үүссэн сегментүүд

18-24 насны “Z” үеийхний хувьд 35.3% нь “фэйсбүүк”-ийг харилцаа холбоо буюу бусадтай харилцах зорилгоор, 51.3% нь чөлөөт цагаа өнгөрөөх, 45,3% нь аливаа нэг мэдээллийг хайж ашиглах зорилгоор ихэвчлэн хэрэглэдэг байна. Хоёр алхамт кластер шинжилгээний хувьд харилцаа холбоон дээр 3 сегмент, чөлөөт цаг дээр 2 сегмент, мэдээлэл хайх дээр 2 сегмент үүссэн. Эдгээр үүссэн сегментүүдийн хувьд судалгаанд оролцогчид өндөр, дунд, бага гэсэн үнэлгээ өгч, ялгаатай байдлыг бий болгосон. Сегмент бүрийн ач

холбогдлыг үнэлж үзэхэд 0,5-аас их үр дүн гарсан нь уг үүссэн сегментүүд нь статистик тооцооллын хувьд ач холбогдолтой гарсан.

Уг сегментүүдийг хоорондоо ялгаагүй гэсэн “0” таамаглалыг хикв тестийн шинжүүрээр шалгаж үзэхэд ялгаатай байдал үүсгэж байгааг шалгахад  $\text{sig} = .000$  буюу 0.05 ач холбогдлын түвшинд няцаагдаж дараах үр дүн гарсан. Өөрөөр хэлбэл тухайн сегментүүд нь хоорондоо ялгаатай байдлыг бий болгож байна.

Хүснэгт 5. Сегментүүдийн харьцуулсан байдал

Харилцаа холбоо			Чөлөөт цаг		Нийт
			бага	өндөр	
Сегмент 3. бага	Мэдээлэл хайх	бага	60.9%	8.0%	69.0%
		өндөр	20.7%	10.3%	31.0%
Сегмент 2. дунд		бага	30.4%	25.5%	56.0%
		өндөр	17.9%	26.1%	44.0%
Сегмент 1. өндөр		бага	16.9%	27.7%	44.6%
		өндөр	12.8%	42.6%	55.4%

Дээрх хүснэгтэд ялгаатай 12 сегмент үүссэн хэдий ч “Фэйсбүүк”-

ийн үндсэн хэрэглээ болох харилцаа холбоо гэсэн хувьсах хэмжигдэхүүн

дээр үндэслэн сегмент хоорондын ялгаатай байдлыг тодорхойлсон нь дараах байдалтай байна.

Сегмент 1. Бусадтай харилцах, өөрийгөө нийгмийн нэг хэсэг гэдгийг мэдрэх зорилгоор “фэйсбүүк”-ийг хэрэглэдэг хэрэглэгчдийн 42,6% нь бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл хайх гэж ашигладаг төдийгүй чөлөөт цагаараа ихэвчлэн хэрэглэдэг.

Сегмент 2. “фэйсбүүк”-ийг бусадтай харилцах нийгмийн хэрэгсэл болгохоос илүү, мэдээлэл авах, чөлөөт цагаа өнгөрөөх зорилгоор хэрэглэдэг хэрэглэгчид 26,1%-ийг эзэлж байна.

Сегмент 3. Харин судалгаанд оролцогчдын 10,3% нь олон танил хүмүүсийг дагадаггүй, бусдаас мэдээлэл авахыг хүсдэггүй хирнээ, бараа бүтээгдэхүүний талаар мэдээлэл хайж, чөлөөт цагаа өнгөрөөх гэж “фэйсбүүк”-ийг ашигладаг.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь 18-24 насны Фэйсбүүк-ийн хэрэглэгчдийн хувьд хэрэгцээ нь сегментчлэлийн “сэдэл” үзүүлэлтийн үндэс суурь хэмжигдэхүүн байж болох юм

гэдгийг батлан харуулахаас гадна судалгааны үр дүнд “сэдэл” нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх сегментчлэлийн үнэ цэнэтэй тодорхойлогч гэдгийг харууллаа. Иймд уг хэмжигдэхүүнээр цаашид судалгаагаа өргөжүүлэн бусад насны сегментийн фэйсбүүк хэрэглэгчдээс тодруулан авах боломжтой юм. Мөн судалгаанд хамрагдсан “Z” үеийнхний Фэйсбүүк-ийн хэрэглээ, оролцоонд хандах хандлага, зан үйлийн талаарх нөхцөл байдлыг нэгтгэн 12 ялгаатай сегмент үүсгэсэн бөгөөд сегмент 1 дэх хэрэглэгчдийг харахад олон нийтийн сүлжээг бусадтай харилцах, мэдээлэл хайх, чөлөөт цагаа өнгөрүүлэх зорилгоор ашигладаг бол бусад сегментүүдийн хувьд харьцангуй бага үзүүлэлтийг сонгосон байгаа нь фэйсбүүкийг өөр зорилгоор хэрэглэдэг байх талтай юм. Иймд уг судалгааг илүү дэлгэрэнгүй асуулгаар судлах хэрэгтэй гэж үзэж байна. Гэхдээ нийт хэрэглэгчдийн 45,3% нь олон нийтийн сүлжээг мэдээлэл хайх зорилгоор хэрэглэдэг гэсэн тул социал хэрэглэгчдэд хүргэх мэдээллийн өгөгдлийг боловсруулахдаа мэдээлэл хайх хэрэгцээн дээр нь үндэслэвэл илүү үр дүнтэй байх боломжтой юм.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. A.Garolina Tynan, J. D. (1987). “Market Segmentation”. Journal of Marketing Management, 301-335.
2. D.Welss, W. (1975). “Psychographics; A critical Review”. Journal of Marketing Research, 196-213.

3. Edward L. Grubb, H. L. (1967). Consumer Self-Concept, Symbolism and Market Behavior: A Theoretical Approach. . Journal of Marketing, 22-27.
4. Frank, W. M. (1972). "Market Segmentation" . Englewood Cliffs, New Jersey: Prentice-Hall Inc.
5. Goyat, S. (2011). The basis of market segmentation: A critical review of literature. European Journal of Business and Management, 45-54.
6. Gunawan, S. (2015). "The Impact of Motivation, Perception and Attitude toward Consumer Purchasing Decision: A Study Case of Surabaya and Jakarta Society on Carl's Junior". iBuss Management , 154-163.
7. Gunter, B. a. (1992). Consumer Profiles: An Introduction to Psychographics. London: Routledge.
8. H. Onur Bodur, D. B. (2000). Belief, Affect, and Attitude: Alternative Models of the Determinants of Attitude. Journal of Consumer Psychology , 17-28.
9. H.Myers, J. (1996). "Segmentation and Positioning for Strategic Marketing Decisions", 1st edition.
10. Lin, C.-F. (2002). "Segmenting customer brand preference: demographic or psychographic". Journal of Product & Brand Management, 249-268.
11. Matthew, G. (2010). "Psychographic Segmentation of the Self-employed: An Exploratory Study". New England Journal of Entrepreneurship , 47-56.
12. Mitchel, V.-W. (1994). How to Identify Psychographic Segments: Part 1. Marketing Intelligence and Planning, 4-10.
13. Mohamed, B. (2005). "The Psychographic Analysis of Malaysian Domestic Travellers". Research Gate , 790-799.
14. Narang, R. (2009). "Psychographic segmentation of youth in the evolving Indian retail market". The International Review of Retail, Distribution and Consumer Research, 535-556.
15. R.Smith, W. (1956). Product Differentiation and Market Segmentation as Alternative Marketing Strategies. The Journal of Marketing, 3-8.
16. R.Ziff. (1971). "Psychographic for Market Segmentation". Journal of Advertising Research.
17. Sulekha, G. (2011). The basis of market segmentation: a critical review of literature . European Journal of Business and Management, 45-54.
18. W.Steward, D. (1981). The Application and Misapplication of Factor Analysis in Marketing Research. Journal of Marketing Research, 51-62.
19. W.Stewart, D. (1981). The Application and Misapplication of Factor Analysis Marketing Research. Journal of Marketing Research, 51-62.
20. Weinstein, A. (2006). "A strategic framework for defining and segmenting markets". Journal of Strategic Marketing 14 , 115-127.



Article info: Mandakh Research, 2021, Vol.06, BUS 605

## СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮРИЙН МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИД ХИЙСЭН СУДАЛГАА

Ш. Болор<sup>1a</sup>, Б.Оюунтунгалаг<sup>2b</sup>

<sup>1</sup> Бизнесийн Ахисан Түвшний Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

<sup>1</sup> Ph.D, дэд профессор, Бизнесийн Ахисан Түвшний Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

<sup>a</sup> oyuntungalag@must.edu.mn, <sup>b</sup> bolor0910@gmail.com

### Хураангуй

Монголын жижиглэн худалдааны салбарт гадны тоглогчид ихээр орж ирэн өрсөлдөөн улам ширүүсэж байгаа өнөөгийн нөхцөлд үйл ажиллагааны стратегиа өөрчлөн, цаг үетэйгээ хөл нийлэн, хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг соргог мэдрэхийг зах зээлийн орчин нь өөрөө биднээс нь шаардаж байна. Маркетингийн стратеги нь бизнес эрхлэгч байгууллагын хувьд ч хамгийн чухал зүйлийн нэг бөгөөд, тухайн байгууллагын үйл ажиллагааг бүхий л хүрээнд тодорхойлж улмаар стратегийн зорилгоо тодорхойлсны үр дүнд маркетингийн үйл ажиллагааны чиглэлээ олж байгууллага цаашидын хөгжлийнхөө үр дүнг бий болгодог байна. Уг судалгааны гол зорилго нь маркетинг стратегийн ач холбогдол бизнесийн байгууллагад ямар үр дүнтэй талаар судлах зорилготой. Байгууллагын стратегийн зорилтод уялдсан маркетингийн төлөвлөлтийг судлах зорилготой юм. Байгууллагын стратегийн зорилтууд удирдлагын арга барил байгууллагын үйл ажиллагааны байдлаас шалтгаалан өөр өөр байдаг. Маркетингийн зорилт нь нэн түрүүнд оновчтой бөгөөд судалгаа шинжилгээнд суурилсан, тухайн зорилтод хүрэх боломжтой байх ёстой. Стратегийн зорилтыг тодорхойлохын тулд нэн түрүүнд компанийн орчны судалгаа шинжилгээ, СВОТ шинжилгээ, маркетингийн орчны судалгаа хийсэн ба үр дүнгээр цаашид анхаарах чиглэлийг нэгтгэн дүгнэлт болгон оруулсан болно.

**Түлхүүр үг:** маркетинг, стратеги, хэрэглэгч, төлөвлөлт

## ОРШИЛ

Монгол улсын зах зээлд цар тахлын үед од болсон салбар бол хүнсний худалдааны салбар байсан билээ. Ямар ч үед үйл ажиллагаа нь хэвийн явагдаж, үйл ажиллагааг нь зогсоох боломжгүй, өнгөц харахад амархан хялбар, ашигтай мэт харагддаг салбар болж олон бизнес эрхлэгчдийн анхаарлын төвд яах аргагүй орсон салбар юм. Тиймээс том жижиг тоглогчид энэ салбарт төрөн гарсаар байгаа салбар билээ. Онолын хувьд маркетингийн стратегийг хэрхэн төлөвлөдгийг судлах, практикийн хувьд байгууллагын үйл ажиллагааг хэрхэн сайжруулах хэрхэн үр дүн бүхий маркетинг стратегийн төлөвлөгөөг бий болгохыг судлах тодорхой үр дүнд хүрэх шаардлага үүсэж байгаа нь уг сэдвийг сонгохын гол үндэслэл юм. Сэдвийг судлахын гол зорилго нь маркетингийн стратеги нь онолын хувьд хэрхэн тодорхойлогдсон. Практикт байгууллага хэрхэн ашигладаг талаар бүрэн дүүрэн судлах бөгөөд анализ буюу шинжилгээний арга, ажиглалтын арга, нэгтгэн дүгнэх арга, тоон судалгааны арга зэргийг тус тус ашиглан судалгаа мэдээлэлд үндэслэв. Уг судалгааны ажлыг хийснээрээ маркетингийн стратегийн төлөвлөгөөний тулгамдсан асуудлыг олж илрүүлэх өнөөгийн байдлыг сайжруулах арга замыг төлөвлөлтөд тусгахаараа практик ач холбогдолтой бөгөөд оновчтой төлөвлөлт хийснээрээ

байгууллагын үйл ажиллагаа илүү сайжрах ач холбогдолтой юм.

## ОНОЛЫН ТОЙМ СУДАЛГАА

### Маркетинг стратегийн ойлголт, үзэл баримтлал

Маркетингийн стратеги нь 1980-д оноос хойш эрдэм шинжилгээ судалгааны хүрээнд судлагдаж байна. Маркетингийн ном зохиолд олон янзын үзэл санааг илэрхийлсэн маркетингийн ойлголтуудыг тодорхойлсон байна. Эдгээр тодорхойлолтууд нь нийгэм эдийн засгийн хөгжил болон маркетингийн хөгжлөөс шалтгаалан хувьсан өөрчлөгдсөөр иржээ.

Маркетингийн стратегийн зорилго нь борлуулалтын өсөлт, ашгийн өсөлт, зах зээлд эзлэх хувь хэмжээний өсөлт, өөрийн зах зээлд манлайлах явдал байдаг. Эдгээр зорилгууд нь ерөнхийдөө компанийн эрхэм зорилго ба бизнесийн стратегийн зорилгуудтай нийцэж байх ёстой. Мөн маркетингийн стратеги нь компанийн маркетингийн үйл ажиллагаануудын үндсэн суурь нь бөгөөд компанийн ерөнхий стратегийн хүрээнд боловсруулдаг. Маркетингийн стратеги нь компанийн үйл ажиллагааны хүрээ, зах зээлд компанийн эзлэх байр суурь, мөн түүний хүчин чармайлтаар тодорхойлогддог.

Стратегийн тухай дараах тодорхойлолтууд байдаг. Үүнд:

- Маркетингийн стратеги гэдэг нь урт хугацаагаар үнэ цэнийг олж эзэмших болон бидний хэрхэн сонголт хийхийг зохион байгуулах талаарх цогц ойлголт юм. Baker, Michael
- “Байгууллагын өөрийн эрхэм зорилгодоо хүрэхийн тулд зорилгуудыг хангах бүх талыг хамарсан иж бүрэн урт хугацааны төлөвлөгөө”, “Зорилгын нэгдэл, байгууллагын боломж, ажилчдын сонирхолд нийцэх тодорхой хөтөлбөрийг боловсруулах ба удирдахыг стратегийн удирдлага. Г.Батхүрэл
- Стратеги нь ерөнхий зорилгод хүрэх үйл ажиллагаа буюу нөөцийг бүрдүүлэх хөтөлбөр. Ц.Цолмон.
- Маркетингийн стратеги нь бизнесийг хүмүүст хүргэх, бизнесийн үйлчилгээг үзүүлдэг бүтээгдэхүүн, үйлчлүүлэгч болгох бизнесийн ерөнхий төлөвлөгөө юм. Investopedia

Өдгөө бизнесийн гадаад орчин нэн хурдан өөрчлөгдөж байна. Энэхүү бодит шаардлага зөвхөн стратегийн удирдлагаар дамжин хэрэгждэгийг зах зээл хөгжсөн орнуудын туршлага нэгэнт нотолж байгаа юм.

Стратегийн удирдлага бүх байгууллагад адилхан байх учиргүй ч түүнийг боловсруулж хэрэгжүүлэх нийтлэг гол

зарчмуудыг менежментийн ухаанд тодорхойлсон байна. Стратегийн удирдлага гэдэг нь байгууллагын үндэс суурь болсон хүний чадавхад тулгуурлан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг баримжаалан явуулдаг хийгээд хүрээллийнхээ талаас буй болсон дуудлагад нийцсэн, өрсөлдөгчөөсөө илүү давуу байдлыг хангасан өөрчлөлтийг цаг алдахгүй хийж, уян хатан зохицуулдаг, энэ бүгд нийлээд тухайн байгууллага урт удаан хугацаанд оршин тогтнож тавьсан зорилгодоо хүрэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр юм.

### **Маркетинг стратегийн хөгжил**

Стратеги менежмент анх 1950-1960-аад онуудад нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу судалгааны шинэ салбар болон гарч ирсэн түүхтэй. 1950-иад оноос өмнөх судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд нь энэхүү салбар ухааны хөгжилд мэдээж багагүй хувь нэмэр оруулсан нь ойлгомжтой, гэвч 1950-иад он гарсны дараа зарим эрдэмтэн судлаачид энэ салбарын судалгааг нэлээд цэгцтэй гаргаж ирснээр бие даасан салбар ухаан болж төлөвшсөн гэж үздэг байна. Тэдгээр эрдэмтдээс дурдвал: Альфред Д.Чандлер (Alfred Chandler), Филип Сельзник (Philip Selznick), Игорь Энсоф (Igor Ansoff), Питэр Дракер (Peter Drucker) нар юм. Алфред Чандлер анхлан менежментийн бүхий л асуудлыг стратегийн хүрээнд нэгтгэж авч үзэх нь чухал ач холбогдолтой болохыг онцолж

байсан бөгөөд үүнээс өмнө менежментийн чиг үүргүүдийг тус тусад нь бараг нэгтгэн авч үздэггүй байсан. Өөрөөр хэлбэл, бизнесийн байгууллагын менежментийн өөр чиг үүрэг бүхий нэгж хэсгүүдийг холбох зорилго бүхий нэгж хоорондын асуудал хариуцсан менежерүүд ажилладаг байжээ. Мөн Чандлер байгууллагын ирээдүйн талаар урт хугацааны бодлоготой байх нь тун чухал хэмээн онцолж байсан. Тэрбээр мөн 1962 онд гаргасан өөрийн «Strategy and Structure» хэмээх алдарт бүтээлдээ байгууллагын нэгж хэсгүүдийн үйл ажиллагааг нэгтгэсэн стратеги нь байгууллагын бүтэц болон чиглэлийг тодорхойлох, мөн төвлөрч ажиллахад гол үүрэг гүйцэтгэхийг тэмдэглэсэн байдаг. Үүнийг тэрбээр маш товчооноор бүтэц нь стратегиа дагадаг гэж тайлбарласан. Чандлерийн үзэл санаанд тулгуурлан Игор Энсоф стратеги менежментийн салбарт шинэ үзэл санаа, ойлголт нэвтрүүлсэн юм. Түүний дэвшүүлсэн санаа, боловсруулсан олон үзэл баримтлал өнөөг хүртэл ач холбогдлоо алдалгүй улам баяжиж, өдий хүртэл ашиглагдсаар ирснээс гадна стратеги менежментийн гарамгай эрдэмтдийн боловсруулсан үзэл баримтлал, үзэл санааны эхлэлийг тавьж өгсөн байдаг. Стратегийн удирдлагын үүсэл хөгжлийн талаар Хофер дөрвөн загварын (paradigm shift) шилжилт буйг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Явцуу бодлогын загвар. Энэ нь 1930-аад оны үед жижиг үйлдвэрлэгчдийн явцуу зах зээлд, хязгаарлагдмал цөөн тооны хэрэглэгчдэд ганц бүтээгдэхүүн нийлүүлдэг үеийн загвар юм.
2. Төлөвлөгөөт бодлого томъёолол нь бизнес өргөжихийн хирээр орчны огцом өөрчлөлттэй хамт функционал хүрээний бодлого шаардлагатай болж гарч ирсэн.

Стратегийн загвар мөн л дээрээс улбаатай бөгөөд бизнес, орчин хоёрын харилцан хамаарлыг тодорхойлох хэрэгцээний улмаас бий болсон. Стратегийн удирдлагын загвар 1980- аад оноос гарч ирсэн бөгөөд бизнесийн байгууллагуудын стратегийн хандлага ба аргууд, удирдлагын нийгмийн хариуцлага гэсэн хоёр ерөнхий хүрээнд чиглэгддэг. Стратегийн удирдлагын процесс:

Менежментийн тухай 200 гаруй тодорхойлолт байдаг гэдэг шиг стратеги удирдлагын мөн олон талаас нь тодорхойлсон олон янзын тодорхойлолт байдаг тэднээс судлаач Глук стратегийн удирдлага нь байгууллагын зорилгод хүргэх үр дүнтэй стратегийг хөгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааны цогц нэгдэл гэж оновчтой товчоор илэрхийлжээ.

## **Маркетингийн бодлого стратегийг амжилттай явуулах нь**

Хүн төрөлхтний нээсэн, нийгэм, эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг олон шинжлэх ухааны нэг нь маркетингийн шинжлэх ухаан.

Маркетингийн шинжлэх ухааныг бизнес эрхэлдэг хэн бүхэн бизнесээ өргөжүүлэх, зах зээлд эзлэх байр суурь, нэр хүндээ нэмэгдүүлэх, улмаар зах зээлд оршин тогтнох арга ухаан болгон хөгжүүлсээр байна.

Маркетингийн шинжлэх ухаан нь товчхондоо “Бизнесийн хувьд - хэрэглэгчдэд үнэт чанар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хүргэх, тэдэнтэй харилцан ашигтай, тогтвортой харилцах үйл явц .” гэж үздэг. Үнэт чанар нь бүтээгдэхүүний болон хэрэглэгчийн үнэт чанараас бүрдэнэ. Бүтээгдэхүүний үнэт чанарыг хэрэглэгчдэд хүргэх, хэрэглэгчийн үнэт чанар болгон хувиргах нь өнөөгийн бизнесийн мөн чанар гэж болно.

Нөгөө талаас маркетингийн ухаан хөгжин тэлсээр, улс орон бүр, байгууллага, компани бүр өөр өөрийн өнгө аясаар хөгжүүлсээр байна.

Маркетингийн шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэгчдийн нэг доктор Филип Котлер бизнесийн байгууллагууд маркетингийн дараах үндсэн үзэл баримтлалын

хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн хандлагатай гэж үздэг. Үүнд :

1. Үйлдвэрлэлийн үзэл баримтлал
2. Бүтээгдэхүүний үзэл баримтлал
3. Борлуулалтын үзэл баримтлал
4. Маркетингийн үзэл баримтлал
5. Цогц (holistic) маркетингийн үзэл баримтлал

Юу хийж чаддагаа үйлдвэрлэж, хүний хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, борлуулалтад анхаардаг үе өнгөрч, хэн ямар хэрэгцээтэй, тэр нь ямар үнэ цэнэтэй, энэхүү үнэ цэнэ нь тухайн байгууллага, компанийн бизнесийн ертөнцөд тогтвортой, хэдэн үеэрээ дуурсаж орших эсэхийг шийддэг цаг үе ирээд байна.

Байгууллага, компани нь бизнесийн хөгжил, загвараа урт, дунд, богино хугацаагаар, корпорац, компани, бизнесийн нэгж, хэлтэс, нэгж бүрээр боловсруулан төлөвлөдөг. Байгууллага, компанийн удирдлагын гол анхаарал хандуулдаг, төлөвлөлтийн чухал хэсэг нь компани, бүтээгдэхүүн, үйлчилгээний давуу тал, ялгарах шинжийг зах зээлд таниулах, хоногшуулах зорилго бүхий маркетингийн бодлого, стратегийн төлөвлөлт байдаг. Маркетингийн төлөвлөлтийн хүрээнд компанийн эрхэм болон хэтийн зорилго, зорилтууд томъёологдон эдгээрийг хэрэгжүүлэх бодлого, стратегийн шийдлүүд тодорхойлогдон маркетингийн төлөвлөгөө,

хөтөлбөрөөр дамжин зах зээлд маркетингийн үйл ажиллагаа болон хэрэгждэг.

Стратегиа тодорхойлохын тулд макро, микро орчин, нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ, бизнесийн багцын шинжилгээ гэх мэт олон судалгаа шинжилгээ хийж зорилго, зорилтоо гаргаж ирдэг үүнээс сүлжээ дэлгүүрийн хувьд хамгийн чухал нь микро орчинд хамаарах хэрэглэгч гэж хэн бэ гэдгийг нэлээн чухалчилж авч үзэн хэрэглэгчийн зан төлөв гэж юу болох, сэтгэл ханамжтай яаж холбогдож байгааг авч үзэв.

Дэлгүүрийн хувьд байршил чухал ч гэсэн нэгэнт байршилаа олоод тогтсон дэлгүүрийн асуудал нь ороод ирсэн хэрэглэгчийг хэрхэн яаж бараа бүтээгдэхүүн худалдан авахад нөлөөлөх вэ, борлуулалтаа хэрхэн өсгөх вэ гэдэгт анхаарна.

Хэрэглэгчийн онцлог шинж, сэтгэл зүй, худалдан авалтын зан төлвийг судлан худалдан авалт хийх шийдвэр гаргах хүртэл бид нөлөөлөх нь стратегийн зорилтын бас нэгэн хэсэг мөн.

## 1. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Уг судалгааны хүрээнд дараах таамаглалыг дэвшүүлж байна.

1. Үр дүнтэй стратеги төлөвлөлт хийхийн тулд тухайн зах зээл, хэрэглэгчийг бүрэн судалсан байх шаардлагатай.
2. Стратегит нөлөөлөх чухал зүйл нь хэрэглэгчийн зан төлөв, хэрэглэгчийн сэтгэл ханамж мөн

Сансар сүлжээ дэлгүүрийн стратегийг Портерийн 5 хүчин зүйлийн шинжилгээгээр судалж

### Хүснэгт 1. Сансар сүлжээ дэлгүүрийн 5 хүчин зүйлийн шинжилгээ

	Үзүүлэлт	Шинжилгээ
Компани (Company)	Компанийн зорилго	Бүрэн тодорхой ойлгомжтой бус, ерөнхий хийсвэр тодорхойлсон
	Бүтээгдэхүүний чиг хандлага	Сансар сүлжээ дэлгүүрийн энэ тасаг онцгой гэсэн тодорхой чиглэл, ялгарал байхгүй.
	Зах зээлийн хэлбэрүүд	Төгс өрсөлдөөнт зах зээл буюу, олон тоглогчтой, бүтээгдэхүүний шинж чанар ерөнхийдөө ижил, үнийн өрсөлдөөн бага, тухайн зах зээл рүү нэвтрэн ороход хялбар
	Технологи ба дадлага туршлага	25 жилийн дадлага туршлагатай, үйл ажиллагаандаа ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн. Технологийн хувьд өөртөө үйлчлэх касс машин нэвтрүүлсэн.
Хамтрагч түнш (Colbrate)	Нийлүүлэгч	1300+ харилцагчийн 24000 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн

Хэрэглэгчид	Зах зээлийн сегмент	Хөдөө орон нутагруу тэлж байгаа, Улаанбаатар хотын 18 салбарын 50 хувь нь хотын захад голдуу байршилтай, сегментийн хувьд дунд болон дундаас доогур орлогтой хэрэглэгчид, эмэгтэй 18-45 насныхан өрхийн худалдан авалтыг голчлон хийдэг.
	Хэрэглэгчдийн хайж байгаа үнэ цэн	Барааны сонголт сайтай, бүтээгдэхүүний чанар дунд, дэлгүүрийн орчин сайн
	Хэрэглэгчийн суваг	1-рт Сошиал медиа суваг, 2-рт ТВ суваг, 3-рт дэлгүүр доторх хэвлэлийг чухалчилж үзсэн /хүснэгт 1/
	Худалдан авагчийн хүсэлт	дэлгүүрийн байршил нэмэх, тохилог цэврийн өрөө,
	Хэрэглэгчийн шийдвэр гаргалт	Дундаж үнэтэй гэж тодорхойлсон /асуулга 8/
Өрсөлдөгчид	Өрсөлдөөний өнөөгийн байдал, ирээдүйн хандлага	Гадны сүлжээ дэлгүүрүүд олноор байгуулагдаж байна.
	Өрсөлдөөний төлөв	Удирдах шинэ арга барилууд орж ирж байгаа учир өөрчлөлттэй хөл нийлүүлэн алхах шаардлагатай
	Өрсөлдөөний гол асуудал /бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, байршил, зах зээлд эзлэх байр суурь/	Өөрийн оруулж ирдэг бараа багатай учир зөвхөн сансараас л авах боломжтой бараа гэсэн ялгарал багатай, оруулж ирдэг бараа байдаг ч хэрэглэгч мэддэггүй
	Өрсөлдөгчийн давуу болон сул талууд	Гадны сүлжээ дэлгүүрүүд орж ирж байгаатай холбогдон үйлчилгээний соёл, орчин хоцрогдолтой болж ирж байгаа
Байгууллагын бизнесийн орчны нөхцөл байдал, уур амьсгал	Бодлого зохицуулалтын орчин	Дотоод худалдааг зохицуулах ямар ч бодлого байхгүй, зэх зээлийнхээ жамаар явж байгаа. Энэ салбарт гадаадын өрсөлдөөнөөс хязгаарласан бодлого байхгүй.
	Эдийн засгийн орчин	Улаанбаатар хотын хэмжээнд 7000 гаруй худалдааны газрууд ажиллаж байна.
	Нийгэм соёлын орчин	Гадны сүлжээ дэлгүүрүүд нэмэгдсэнтэй холбогдон үйлчилгээний соёл нэвтэрч, нийгэм үйлчлүүлэх соёлыг илүүд үзэж, сайхан орчин, тохилог орчинг илүү чухалчлан үздэг болсон.
	Технологийн орчин	Шинэ технологи, инноваци хурдацтай нэвтэрч байгаа. Төлбөр төлөх олон төрлийн арга хэрэгслүүд нэвтэрч, онлайн худалдаа зонхилж, хөнгөлөлт урамшуулал хүртэл утасны аппликэйшн рүү шилжиж байна.



Сансар сүлжээ дэлгүүрийн сүүлийн жилд хийсэн маркетингийн үйл ажиллагаа буюу голлон хийсэн худалдаа идэвхжүүлэлтийн талаар болон, компаний зах зээлд эзлэж

байгаа байр суурийн судлагааг ТОП-100 аж ахуйн нэгжид орсон өрсөлдөгч компаниудтай харьцуулсан судалгаа хийв.

*Хүснэгт 2. Топ 100 аж ахуйн нэгжийн жагсаалт үзүүлэлт тус бүрийн эрэмбээр 2019*

Names	2019					
	Ерөнхий эрэмбэ	Борлуулалтын орлого	Татварын орлогын хэмжээ	Даатгуулагчийн тоо	Ашгийн хэмжээ	Хөрөнгийн эрэмбэ
Номин	16	19	78	6	67	81
И-март	52	57	58	36	55	50
Миний	83	78	94	42	83	89
Сансар	87	77	89	52	57	77

ТОП 100 ААН-ийг эрэмбэлэхдээ Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны мэдээ, тайлан, тоон үзүүлэлтэд тулгуурлан

ААН-ийн тухайн жилийн орлого, улсын төсөвт оруулсан татвар, нийгмийн даатгал төлсөн ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ гэсэн үндсэн үзүүлэлтийг чухалчилдаг.

*Хүснэгт 3. Топ 100 аж ахуйн нэгжийн жагсаалт үзүүлэлт тус бүрийн эрэмбээр 2020*

Names	2020					
	Ерөнхий эрэмбэ	Борлуулалтын орлого	Татварын орлогын хэмжээ	Даатгуулагчийн тоо	Ашгийн хэмжээ	Хөрөнгийн эрэмбэ
Номин	14	16	98	7	67	83
И-март	40	42	49	28	73	52
Миний	77	81	87	41	78	90
Сансар	78	78	94	46	84	81



Монгол Улсын 2020 оны ТОП-100 ААН-ийг үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл худалдаа, үйлчилгээний салбарын 28 компани орсноос 4 нь сүлжээ дэлгүүр байна. Ерөнхий эрэмбээр авч үзвэл Номин 2 шат, И-март 12 шат, Миний дэлгүүр 6 шат, Сансар 9 шатаар ахисан нь ерөнхий өсөлт нь И-мартын дараа орж байна.

МУ-ын хүн ам 2021 оны байдлаар 3,357,542. Үүнээс 1,499,140 хүн нь УБ хотод амьдарч байна. УБ хотод байгаа хүмүүсийн тодорхой хувь нь манай хэрэглэгч юм. Сансар сүлжээ дэлгүүр нь ихэвчлэн хотын захын дүүргүүдэд байрладаг.

*Хүснэгт 4. Сансар сүлжээ дэлгүүрийн микро орчны нэгтгэл*

Микро орчны хүрээнд	Компаний өмнөх болон одоогийн маркетингийн үйл ажиллагаад үнэлэж дүгнэх	4P	
	Бүтээгдэхүүн / Product	Францаас болон бусад улсаас өөрийн оруулж ирдэг барааг таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх тал дээр ажиллах,	7 хоног тутам Шинэ бүтээгдэхүүний хэрэглэх, ашиг тусыг танилцуулах бүтээгдэхүүн, контентоо бүтээлчээр, сонирхолтойгоор тасралтгүй хөгжүүлэх
	Үнэ	Өнгөрсөн хугацаанд үнийн хувьд 2 дугаарт орж үнэтэй гэсэн масс зах зээлд үнэлэгдсэн байна. Энэ ойлголтыг өөрчлөх бодлого баримтлах.	Илүү олон үнийн бодлого бий болгох
	Хувиарлалт	20 салбартай, хөдөө орон нутагт 2 салбар нээсэн, Тээвэр ложистикийн албыг өргөжүүлсэн	Салбар дэлгүүр нэмэх
	Идэвхижүүлэлт	Сошиал медиаг илүү түлхүү ашиглаж фото зураг авалт болон дизайнерын бүтээлч контентууд ашиглаж байгаа	Илүү далайцтай компаниг ажил явуулах, сошиал идэвхижүүлэлтийг нэмэх, цар тахалтай холбоотой ТВ үзэлт ихэссэн учир ТВ сувгаар рекламаа явуулах

	Өрсөлдөгч	Шинэ бүтээгдэхүүнүүд оруулж ирэн, сансарт л байдаг бараагаар татах стратеги баримталж байна.	
Макро орчны хүрээнд	Хүн ам зүйн хүчин зүйлс	Сансар	
	Эдийн засгийн хүчин зүйлс	Хил хааж үнийн өсөлттэй холбоотойгоор худалдан авалт бага болсон, барааны хомсдол их гарч байгаа ч сагсны дундаж худалдан авалт өмнөх онуудаас өссөн, борлуулалт мөн өссөн үзүүлэлттэй байна.	Үнийн дүнгийн хувьд боломжийн байх бүтээгдэхүүн судалгаа тасралтгүй хийх, хэрэглэгчээс бүтээгдэхүүний чанар, хүртээмж, төрөлжүүлэлтийн судалгааг тогтмол хийх
	Шинжлэх ухаан технологийн хүчин зүйлс	Хэрэглэгчид онлайн худалдан авалт түлхүү хийдэг болсонтой холбогдуулан онлайн борлуулалтын сувгаа тэлэх, онлайн борлуулалтад зориулсан бүтээгдэхүүний контентыг сайжруулах, хүргэлтийг хурдан болгох, төлбөр тооцооны асуудлыг түргэн шийддэг болох	Өөрсдийн онлайн худалдааны сайттай болох, бусад онлайн худалдааны платформуудтай хамтран ажиллах
	Улс төрийн хүчин зүйлс	Цар тахалтай холбоотой ажлын цагийн хуваарийн зохицуулалт төрөөс гаргаж байгаа, төрөөс хөнгөлөлт, халамж ихтэйгээс ажил хийх хүний тоо багассанаар ажиллах хүч буурсан	Дэлгүүр дээрх ажилтны цалин хөлс нэмэгдсэн, ажлын уялдаа холбоо, ачааллыг тэгш хувиарлах, ажилтны сэтгэл ханамжийн судалгааг бодитой хийж, дүгнэх
	Соёлын хүчин зүйлс	Монгол үндэсний хэв шинжитэй, дотоодын бараа бүтээгдэхүүнийг сонгох, хэрэглэсэн хүмүүсийн ханлага сайн байгаа	Монголд үйлдвэрлэсэн барааны тасгаа өргөжүүлэн, шинэчлэх, өөрсдөө өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэх боломжийг эрэлхийлэх
	Экологийн хүчин зүйлс	Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан, боловсруулдаг газарт нийлүүлдэг	Гялгар торны хэрэглээг эко тор хэрэглэх хандлага руу аажим шилжүүлэх, хэрэглэх соёлыг хэргэлэгчдэд суулгаж, өөрийн брэнд эко торны төрлийг нэмэгдүүлж олон төрөлтэй болгох

Сансар сүлжээ дэлгүүрийн 2019-2020 онд хийсэн маркетингийн голлох үйл ажиллагаануудын туршлагаудыг судлан авч үзье.

#### Хүснэгт 5. Сансар супер маркетингийн туршлага

1	SMART PAYMENT	Бүх төрлийн төлбөрийн хэрэгслүүдийг пос-д байршуулах
2	SMART PROMOTION	Ухаалаг хэрэглээг ашигласан худалдан авагч бүрт ухаалаг машин бэлэглэе
3	SMART COUPON	Долоо хоног бүрийн өндөр борлуулалттай үед купон тараах
4	SMART SUPERMARKET	Зөвлөх мэдээллийн дэлгэц, хэрэглэгчийн хонх, өөртөө үйлчлэх касс.

#### “Үнэнч, тогтмол хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх”

Баярын саруудад зориулсан идэвхжүүлэлтээр орлого өсгөх

Сүлжээ дэлгүүрийн борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хангах, сагсны дундаж дүн болон биллийн урсгал нэмэгдүүлэх зорилгоор үндсэн 6 төрлийн урамшуулалт худалдаа зохион байгуулагдах төлөвлөгөөтэй байсан ба хямдралын гудамжны өөрчлөлттэй холбоотой 5 төрлийн буюу

1. Сар шинийн нэгдсэн худалдаа
2. Хүүхдийн баярын нэгдсэн худалдаа
3. Наадмын урамшуулалт худалдаа
4. Хичээлийн шинэ жилийн худалдаа
5. Шинэ жилийн урамшуулалт худалдаа зохион байгуулагдсан байна.

Амжилттай маркетингийн хэрэгжүүлэн зорилгодоо хүрэхийн тулд сугалаат худалдааг явуулсан. Сугалаат худалдааны зорилго: Алтан жолоо трейд ХХК нь харилцагч байгууллагуудтайгаа хамтран “Хямдралын гудамж” хөтөлбөрийг 2018 оны 07 дугаар сараас эхлэн амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан барааг хамгийн хямд үнээр хэрэглэгчдэд хүргэх, маркетингийн сурталчилгаагаар дамжуулж бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчдад таниулах, хэрэглэгчийн сэтгэл ханамж болон борлуулалтын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилготой.

Идэвхжүүлэлтийн хамрах хүрээ:

- ✓ Бүх салбараар
- ✓ Хугацаа: 2019/11 – Present (Хямдралын Гудамж №3)

Хийгдсэн ажлын жагсаалт:

- 14 дэлгүүрийн хамгийн өндөр урсгал бүхий тасагт

- нэг бүтэн босоо тавиурт байрших
- Компанийн фэйсбүүк хуудсаар тогтмол бүүст хийх
  - Промошин ажиллуулж, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах боломж

Хэрэглэгчдэд хямдралын гудамж онцгой, сонирхолтой байдлаа алдаж

байгаа. Хямдралын гудамжинд орж буй бүтээгдэхүүнүүд нь тухайн үеийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байх магадлалтай. Мөн хямдралын гудамжны идэвхжүүлэлт хангалттай явагдаагүй улмаас хэрэглэгч таниулалт сайн хийгээгүй байх магадлалтай.

### Хүснэгт 6. Хямдралын хэлбэрүүд

	Хямдралын хувь	Үнийн санал
1	0-4% SALE	2,000,000₮
2	5-14% SALE	1,500,000₮
3	15%-дээш SALE	1,200,000₮

### “Хүүхдийн баяр”

Сугалаат худалдааны зорилго: Хүүхдийн баярын бэлгийн худалдан авалтыг нэмэгдүүлэх, баяры үеэрх худалдан авалтыг нэмэгдүүлэх.

Идэвхжүүлэлтийн хамрах хүрээ:

- ✓ Бүх салбараар
- ✓ Хугацаа: 2020/07/06 - 2020/07/31

Худалдааны аргачлал: Хүүхдийн баярын үеэр ямар нэгэн хямдрал урамшуулал зарлаагүй, зөвхөн байгаа бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилготой хийсэн.

Сансар супермаркет нь маш олон төрлийн маркетинг идэвхжүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд ажилчдаа ч мөн идэвхжүүлдэг.

Магадгүй ажилчдад чиглэсэн бодлого явуулдаг нь тэдний чадварлаг үнэнч ажилчдаар маркетингийн амжилттай бодлого явуулахын нэг давуу тал амжилтанд хүрэх үндэс байж болох юм.


### Жилийн эхний хагас жилд хийгдсэн ажлууд

- Social хөгжүүлэлт -social орчинд идэвхтэй байж, FB дээр дагагчдийн тоог ихэсгэх, постын engagement, reach-г нэмэгдүүлэх
- Хөтөлбөр идэвхжүүлэлт - хэрэглэгчид рүү чиглэсэн ялгаатай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, худалдан авалтыг дэмжих, хэрэглэгчдээ урамшуулах

- Шинэ салбарын нээлт-Сансар 38, Сансар 8, Сансар 16 салбарын нээлт
- Маркетингийн судалгаа-Хэрэглэгч, өрсөлдөгчийн судалгаа
- Шинэ бараа нэвтрүүлэлт- Sansar fresh & Sansar foods
- Брендинг-Компанийн брендийг сайжруулах, үнэ цэнэтэй болгох
- Хэрэглэгч, олон нийттэй харилцах-Хэрэглэгчидтэй

тогтмол холбогдож ажиллах ( утсаар болон online)

2022 он гэхэд дэлхий даяар нийт и-мэйл хэрэглэгчдийн тоо 4.3 тэрбумд хүрнэ гэсэн таамаглал бий. Өөрөөр хэлбэл дэлхийн нийт хүн амын талтай тэнцэх тооны и-мэйл хэрэглэгч бий болох нь ээ. Мөн дээр нь и-мэйл маркетинг бусад дижитал маркетингийн аргачлалуудтай харьцуулахад хамгийн үр дүнтэй нь гэж судалгаанд хамрагдсан маркетерүүдийн 54% нь хариулсныг доорх графикаас харж болно.



Эх сурвалж: [www.omnicoreagency.com](http://www.omnicoreagency.com)

### Зураг 1. Маркетингийн сувгуудын үр дүнгийн харицуулалт

Цаашид сансар супер маркет нь дижитал маркетингийн бодлогыг баримтлан ажиллах нь илүү үр дүнтэй гэж дүгнэж байна.

### Салбарын судалгаа:

Хүснэгт 7. Сүлжээ дэлгүүрийн сүүлийн нэг жилийн борлуулалтын байдал

№	Нэр	Нийт борлуулалт	Хүнс	Хүнс бус	Улаанбаатар	Салбарын тоо	Сүлжээ дэлгүүр эзлэх хувь
1	Номин	365,685	70,607	95,078	303,519	45	44.3%
3	И-март	120,442	98,762	21,680	120,442	3	14.6%

5	Оргил	125,285	111,504	13,781	114,009	12	15.2%
2	Сансар	83,700	74,493	9,207	83,700	20	10.1%
4	Миний	76,929	68,467	8,462	76,929	19	9.3%
6	EFES	25,000	22,250	2,750	25,000	5	3.0%
7	Good price	28,000	24,920	3,080	28,000	4	3.4%
		<b>825,041</b>	<b>671,003</b>	<b>154,038</b>	<b>751,599</b>		100.0%

Салбарын тоог зах зээлд эзлэх хувьтай харицуулахад борлуулалтын орлогод салбарын тоо хамааралгүй болох нь И-мартын үзүүлэлтээс харагдаж байна. Сансар, Миний дэлгүүр хоёр үзүүлэлт болон салбарын тоогоор ойролцоо байгаа нь салбарын байршилүүд ижил хотын захруу төвлөрсөн байдаг ба дундаж түвшний хэрэглэгчдийн сонгон үйлчлүүлдэг дэлгүүр гэж харагдаж байна. Сагсарыг Оргилтой харьцуулахад Оргил салбарын тоогоор бага ч гэлээ салбаруудын байршлын давуу талтай гэдэг нь харагдаж байна.

Хүнсний болон хүнс бус барааны борлуулалтыг Номин, И-март, Оргил гурвын үзүүлэлтээр харахад Оргил, И-март хүнсний барааны борлуулалт сайтай, Номин хүнс бус барааны борлуулалт өндөр үзүүлэлттэй байгаа нь тухайн барааны төрөлжилт, сонголт сайн гэж дүгнэж болохоор байна.

### **Сүлжээ дэлгүүрүүдийн худалдан авагчдын сэтгэл ханамжийн судалгаа**

Энэхүү хэсэгт судалгааны ямар арга зүй ашиглан судалгааг хийж гүйцэтгэсэн болон түүнийг ямар хугацаанд хийж гүйцэтгэсэн талаар дурдах бөгөөд судалгааны онцлог давуу тал судалгаанд хамрагдсан объектын талаар тодорхой дурдагдана.

#### **Судалгааны дизайн**

*Судалгааны ажлын зорилго:* Монгол хэрэглэгчдийн олон нийтийн сүлжээнд тулгуурласан цахим худалдааны хэрэглэгчийн зан төлөв судлах зорилготой.

*Судалгааны арга зүй:* Энэхүү судалгааг 2020 оны 3 сараас 2020 оны 4 сар хүртэлх хугацаанд олон нийтийн сүлжээ (facebook), анкетын арга буюу Google forms болон хоёрдогч өгөгдөл ашиглан цуглуулж үнэлэлт дүгнэлт гаргасан. Санал асуулгын судалгаа нь 5 хүчин зүйлс хамарсан 27 асуулгаас бүрдэнэ.

Судалгааны түүврийн хэмжээ 399,9 байсан бөгөөд нийт судалгаанд 365 түүвэр цуглуулсны 19 нь бүх асуулгад бүрэн

хариулаагүй байсан учир хасагдаж нийт 346 бүрэн хариулт бүхий асуулгын түүврийг амжилттайгаар

хүлээн авч анализ дүгнэлт гаргасан болно.

$$n = \frac{N}{1 + N(0.05)^2} = \frac{116,101}{1 + 116,101(0.05)^2} = \frac{116,101}{290,255} = 399.9$$

#### Хүснэгт 8. Судалгааны дизайн

Судалгааны нэгж хүрээ	Улаанбаатар хот, сүлжээ дэлгүүрүүдийн дагагчид
Өгөгдөл цуглуулах арга	Асуулгын арга
Онолын үндэслэл	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

#### Асуулгын найдвартай байдлыг шалгах тест

Кронбах альфа нь асуулгын найдвартай байдлыг тооцоолоход ашиглагддаг аргачлал бөгөөд судлаач Нунналигийн (Nunnally, 1967) санал

болгосноор Кронбах альфа нь 0.7 – оос дээш байвал найдвартай нь батлагддаг. Тус судалгаанд асуулгын найдвартай байдлыг шалгахын тооцохын тулд Кронбах альфа аргачлалыг ашигласан бөгөөд SPSS программыг ашигласан болно.

#### Хүснэгт 9. Кронбах альфа тайлбар

Зөвшөөрөгдөх түвшин	Харгалзах утга
$\alpha \geq 0.9$	Маш сайн
$0.7 \leq \alpha < 0.9$	Сайн
$0.6 \leq \alpha < 0.7$	Хүлээн зөвшөөрнө
$0.5 \leq \alpha < 0.6$	Муу
$\alpha < 0.5$	Хүлээн зөвшөөрөхгүй

Судалгааны 8-р асуулт нь бүтээгдэхүүний шинж байдлыг илтгэсэн 5 хэмжээст/шкалл/ бүхий 7

хувьсагч, 16-р асуулт нь хэрэглэгчийн худалдан авах үеийн үйл явцыг үнэлэхийн тулд мөн 5

хэмжээст /шкалл/ 8 хувьсагчийг оруулсан. Эдгээр бүх хувьсагчуудын хувьд найдвартай байдлыг дараах байдлаар шалгасан.

1. Бүтээгдэхүүний шинж чанарыг илтгэсэн 8-р асуултын найдвартай байдал шалгасан.

*Хүснэгт 10. 8-р асуултын найдвартай байдал*

Кронбах альфа	Кронбах альфа Based on Standardized Items	N of Items
.610	.610	7

Найдвартай байдал 0.6-аас дээш гарсан учир 8-р асуултыг цаашид ашиглах боломжтой.

2. Хэрэглэгчийн худалдан авах үеийн үйл явцыг илтгэсэн 16-р асуултын найдвартай байдал шалгасан

*Хүснэгт 11. 16-р асуултын найдвартай байдал*

Кронбах альфа	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.948	.948	8

Найдвартай байдал 0,9-ээс дээш буюу маш сайн гарсан учир 16-р асуултыг цаашид ашиглах боломжтой.

Судалгааны нийт асуултуудын хувьд найдвартай байдлыг шалгасан.

*Хүснэгт 12. Нийт асуултуудын хувьд найдвартай байдал.*

Кронбах альфа	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.698	.728	41


Найдвартай байдал 0,6-аас дээш гарсан учир асуултуудыг цаашид ашиглах боломжтой болж байна.

**Демографик судалгаа**

Энэ оны судалгаагаар судалгаанд оролцогчдын 92,4% нь эмэгтэй, 7,5% нь эрэгтэй байна. Насны бүлгээс харвал хамгийн их хувийг 25-34 насныхан 48%, 18-24

насныхан 26%, 35-44 насныхан 26% эзэлж байгааг харахад өрхийн гол худалдан авагч нь эмэгтэйчүүд, насны хувьд дунд насныхан байгааг илэрхийлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад тухайн хоёр оны судалгааг нийлүүлсэн үзүүлэлт буюу **18-44 насны эмэгтэйчүүд** гол худалдан авагч гэдэг нь харагдаж байна.





Зураг 2. Хэрэглэгчийн наны ангилал /зөвхөн эмэгтэй/


### Орлогын үзүүлэлт:

Хэрэглэгчдийн нэг удаагийн худалдан авалтын хэмжээг харахад 2017 онд 72% нь 5001-30000 төгрөгийн худалдан авалтыг хийдэг байсан бол 2018 онд **10001-50000** төгрөгийн худалдан авалтыг **70-аад** хувь нь хийдэг болсон байна. Мөн бусад үзүүлэлтийг 2017 онтой харьцуулан харахад **30001-50000** төгрөгийн худалдан авалтын хэмжээ 2%-иар, 50001 болон түүнээс дээш үнийн дүнтэй худалдан авалт хийх хэмжээ 3.4%-иар тус тус өссөн байна.

2019 оны судалгаагаар 15,001-30,000, 50,000-с дээш төгрөгийн худалдан авалт **66 хувийг**, 5001-


15,000 төгрөгийн худалдан авалт 24 хувийг, 5000 хүртэлх төгрөгийн худалдан авалт 10 хувийг эзэлж байсан байна.

Энэ онд 30000-60000 төгрөгийн худалдан авалт 35,3%, 60000-100000 төгрөгийн худалдан авалт 25,4 хувь, 15,001-30,000 төгрөгийн худалдан авалт 20,9%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд **15000-100000** төгрөгийн сагсны дундаж худалдан авалт **81,6 хувийг** эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад сагсны дундаж худалдан авалт тогтмол өсч байгаа ба өмнөх оныхоос **15,6%-ийн өсөлт** харагдаж байна.



Зураг 3. Хэрэглэгчийн нэг удаагийн худалдан авалтын дүн


Энэ орлогын төвшингийн болох нь харагдаж байна. Энэ нь үзүүлэлт нь худалдан авагчдын дийлэнх хувь нь дундаж болон дундажаас доогуур орлогтой өрхүүд салбарын байршилын нөлөөлөлтэйг илтгэж байна.



Зураг 4. Өрхийн орлогын төвшин

Авсан бараа бүтээгдэхүүнээ боож баглах хэсэгтэй байх үнэгүй интернэттэй байх, гэсэн үйлчилгээнүүд давуу санал авсан бөгөөд утас цэнэглэх, ариун цэврийн өрөөтэй байх, зэрэг үйлчилгээнүүд нэвтрүүлэх нь мөн хэрэглэгч татах

нэг арга хэрэгсэл гэж ойлгож байна. Хүүхэд хуурайлах өрөө, хүүхэд саатуулах хэсэг мөн байгаасай гэж хүссэн нь дийлэнх худалдан авагчид гэрийн эзэгтэй гэдэг нь харагдаж байна.



Зураг 5. Хэрэглэгчдийн нэмэлтээр байлгахыг хүссэн үйлчилгээ

*Хүснэгт 13. Судалгаанд оролцогчдын түлхүү худалдан авдаг бүтээгдэхүүн*

		Сүлжээ дэлгүүрээс ямар бүтээгдэхүүн түлхүү худалдан авдаг вэ?			
		бусад	гоо сайхан	өргөн хэрэглээний бараа	хүнс
Таны хүйс	эрэгтэй	54	23	15	15
	эмэгтэй	65	87	26	21
Нийт		119	110	41	36

Тус судалгаанд гол зарагддаг бараа нь гоо сайхны бараа байгаа бөгөөд дийлэнх нь буюу 87 эмэгтэй худалдан авагчид байгаа нь харагдаж байна. Харин эрэгтэй хэрэглэгчдийн түлхүү худалдан авдаг бараа бүтээгдэхүүн нь хүнс, бусад бараа бүтээгдэхүүн байна. Эмэгтэйчүүд сүлжээ дэлгүүрээс хүнс, бусад бараа бүтээгдэхүүн авдагч гоо сайхны барааг мөн түлхүү худалдан авдаг нь харагдаж байна. Гоо сайхны бараанд шампунь, саван, тос зэрэг орж байгаа болно. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүний төрөлжилтийг сайжруулах шаардлагатай гэж харагдаж байна.

### 3. ДҮГНЭЛТ

Маркетинг стратеги нь төрийн болон хувийн хэвшилд байнгын голлох үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хамгийн чухал асуудлын нэг юм. Эрдэмтэн судлаачид маркетинг стратегийг маш олон талаас нь судалж тодорхойлсон бөгөөд байгууллагын үйл ажиллагааны

голлох цөм бөгөөд тухайн маркетингийн төлөвлөгөөг стратегийн зорилтоо биелүүлэхийн тулд төлөвлөн ажилладаг. Судалгааны үр дүнд гадаадын 3 брэндийн маркетингийн амжилтад хүрсэн түүхийг судлан монгол улсын хэмжээнд Сансар сүлжээ дэлгүүрийн судалгаа хийв.

Худалдааны байгууллага тэр дундаа сүлжээ дэлгүүрийн хувьд хамгийн гол баримтлах зүйл нь маркетинг гэдэгтэй санал нэг байна. Учир нь сүлжээ дэлгүүр нь зах зээлд өрсөлдөгч ихтэй бөгөөд хэн илүү маркетинг сайтай байна тэр дэлгүүр худалдан авагчдаа өөртөө илүү татах боломжтой гэж үзэж байна. Судалгааг байгууллагын орчны шинжилгээ, захзээлийн шинжилгээ болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн шинжилгээ гэсэн хэд хэдэн шинжилгээ судалгааны үр дүнг нэгтгэж үзхэд зах зээлд хэдийнээ байр сууриа олсон маркетингийн үйл ажиллагаа нь жигдэрсэн нь харагдаж байна.

Макро, микро орчны судалгааны үр дүнгээс бүтээгдэхүүн рүү чиглэсэн хэрэглээг таниулсан

бүтээлч сурталчилгааг тасралтгүй хөгжүүлэх, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, шинэ салбар нээх, үнийн хувьд боломжийн байх судалгаа тасралтгүй тогтмол хийвэл боломжтой харагдаж байна.

Гадны улс орнууд хэрэглэгчиддээ чиглэсэн бодлого баримталдаг бол Монгол улсын хувьд мөн Сансар сүлжээ дэлгүүр баяр ёслол тэмдэглэлт өдрүүдээр маркетингийн үйл ажиллагаагаа идэвхтэй хэрэгжүүлдэг бөгөөд тэр нь хамгийн их үр дүнд хүрдэг байна. Энэ нь маркетингийн идэвхжүүлэлт рүү чиглэсэн маркетингийн чиглэлтэй

болох нь харагдаж байна. Харин гадны компанууд байнгын маркетингийн бодлогыг баримтлан зөвхөн нэг чиглэлд хандуулах бус маркетингийн 7Пи-г бүхэлд нь тэнцвэртэй анхаардгаараа ялгаатай юм. Тиймээс бид маркетингийн зөв бодлогыг баримтлан байнгын шинэ хандлагыг судлан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах төлөвлөлт хийн мөн байнгын үйлчлүүлэгчээ алдалгүй шинэ хэрэглэгчийг бий болгохын тулд маркетингаа төлөвлөх нь илүү амжилтад хүрэх боломжтой юм.

## АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Ф.Котлер. (2014). Маркетингийн менежмент.
2. Ц.Баатартогтох. (2010). Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй.
3. Erez Shmueli, Baruch Barzel, Rami Puzis” 3rd International Winter School and Conference on Network Science” 2017
4. Э.Гүргэмжав. (2013). Хэрэглэгчийн зан төлөв.
5. Я.Отгонсүрэн. (2010). Маркетингийн удирдлага.
6. Д.Баярмаа. (2012). Маркетинг
7. Бат.Б (хян), 2010, МУИС-ийн ЭЗСургууль, Магистр, докторын сургалтын гарын авлага, Улаанбаатар, х.199-206.
8. Баярмаа.Д, 2007, Маркетинг, Мөнхийн үсэг ХХК, Улаанбаатар.
9. Бүрэн.Н, Ядамсүрэн.Ж, 1986, Зах зээл судлал, Улаанбаатар.
10. Гаалийн Ерөнхий Газар, 2011, Гадаад худалдааны гаалийн статистик мэдээ.
11. Дэвид Огилви, 2010, Рекламны сэтгэл зүй, Мишигдорж.Б, Энх-Эрдэнэ.Г (орч), Улаанбаатар, Оюуны гүүр хэвлэлийн газар.
12. МҮХАҮТанхим, 2006, Маркетингийн их бүрэн гарын авлага, Улаанбаатар

*Article info: Mandakh Research, 2021, Vol.06, HUM 601*

## **ШИЛИЙН ГОЛ АЙМГИЙН МОНГОЛЧУУДЫН ГЭР БҮЛИЙН ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗӨРӨӨТ ШИНЖИЙН ТУХАЙ СУДАЛГАА**

Ө.Тэргэл

PhD student, School of Mongolian Studies of Inner  
Mongolia University, China.

### **Abstract**

*Тус судалгаа нь нийгмийн хэл шинжлэлийн хээрийн судалгааны арга зүй болон онолд суурилж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр монголын өөртөө засах орны Шилийн гол аймгийн таван газар орны мэдээлэгчээр анкет бөглүүлэх ба мэдээлэгчтэй ярилцлага хийх зэрэг социологийн судалгааны арга зүйг ашиглаж, монголчуудын гэр бүлийн хэлний хэрэглээтэй хамаатай баримт, хэрэглэгдэхүүнийг цуглуулжээ. Цуглуулсан баримтыг SPSS тоо бүртгэлийн програмаар боловсруулж, судалгаанд оролцогч гэр бүл хоорондоо ямар хэлээр ярилцаж байгаа ба хэл хэрэглээний нь мэдээлэгчдийн нас, ажил, амьдарч буй газар ба суурьшлын хэлбэр зэрэг нийгмийн хүчин зүйлийн талаар зөрөөтэй байгаа эсэхийг тодруулан гаргасан болно.*

**Түлхүүр үг:** Гэр бүл (family), хэлний хэрэглээ (languages use), монгол хэл (Mongolian Language), хятад хэл (Chinese Language), Зөрөө (Difference)

## ОРШИЛ

Хэлний хэрэглээний тухай эрдэмтэд адил бус өнцөгөөс өөр өөр тайлбар хийсэн байдаг. Чомский (Chomsky, N) бүтээлч өөрчлөлтийн хэл шинжлэлийн (Transformational generative linguistic) онолын үүднээс хэлний хэрэглээ гэдэг нь хүний хэлний мэдлэгийг амьдрал дунд ашиглаж хэрэглэхийг зааж байгаа юм гэж тодорхойлж, хувь хүний хэлний чадвар нь хэлний хэрэглээнд нөлөөлнө гэж үзсэн байдаг. Лийч (Leech, G) хэлний прагматик ухааны (Language Pragmatics) үүднээс, хэлний хэрэглээ нь үг ба өгүүлбэр зэрэг хэлний илтгэх хэлбэр ба хувь хүний хэрэглээний хоорондох харьцааг судалдаг гэж үзэж, хэлний хэрэглээ нь ярилцаж буй этгээдийн соёл боловсрол ба танин мэдэх зэрэгтэй холбоотой гэж үзсэн байна. Ли Юймин (Li Yuming): “хэлийг ашиглаж, хэрэглэх нийгмийн болон хувийн бүхий үйл ажиллагааг” хэлний амьдрал (Language life or Language situation)” гэж нэрлэж болно, ярих, бичих, нэрлэх, ном унших, радио сонсох, зар сурталчилгаа хийх, хэл заах гэх мэтийн бүх зүйл нь хэлний амьдралын ангилалд хамрагдана” гэжээ. Тус судалгаан дахь “хэлний хэрэглээ” нь микро хэлний амьдралын судалгаанд хамрагдаж, голдуу хүмүүсийн гэр бүлийн хэлний орчинд энгийн цагт гэр бүлийн гишүүнтэй ямар хэлийг сонгон яриж байгаа буюу ямар хэлийг ашиглаж хэрэглэж байгааг заадаг.

Гэр бүлийн орчин бол хүний хэл сурах хамгийн анхны орчин болдог мөртлөө хүний хэлний хөгжилд чухал үйлдэл үзүүлдэг. Гэр бүлийн дотоодод ямар хэлийг сонгон ярих нь ердөө тухайн гэр бүл, ураг овог гэх мэт бүлгийн эсвэл хувь хүний өөрийн сонголт гэдэг нь тодорхой. Улмаар тэр нь хувь хүний хэлний чадвартай ч шууд холбогдож байдаг. Гэр бүл дотроо хүмүүс ямар хэлийг сонгон ярьж байгаагаар хэлний хөгжлийн хандлагыг ойлгож бас болох юм. Өвөр монголчуудын гэр бүлийн хэлний хэрэглээний тухай, судлаач Алтанбулаг гэр бүлийн хэлний бодлогын онолд суурилж, Өвөр Монгол гэр бүлийн хэлний хэрэглээнд судалгаа хийсний дүнд эцэг эхийн боловсролын түвшин, нийгэм, аж ахуйн байр суурь зэрэг хүчин зүйл нь хүүхдийн хэлний сонголтыг нөлөөлж байх бөгөөд хотод суурьшилтай гэр бүлийн хэлний сонголт нь хятад хэл рүү хэлбийж байна гэсэн дүгнэлт гаргажээ. Түүнчлэн судлаач Цацрал эцэг эхийн ажлын орчин, гадаадын соёл, монгол хэлний байр суурь зэрэг хүчин зүйл нь Өвөр Монголчуудын гэр бүлийн хэлний сонголтыг нөлөөлж, монгол хэлний гэр бүлийн үе уламжлалд харшилж саад учруулж байна гэж үзэв.

Шилийн Гол аймгийн 13 хот, хошуу орноор монголчууд суурьшин амьдарч байдаг. Хот дүүрэгт суурьшиж байгаа монголчууд нь бусад үндэстэнтэй

холилдон суурьшсан дундаа төвлөрөн суурьшсан юм уу төвлөрөн суурьшсан дунд бусад үндэстэнтэй холилдон суурьшсан өвөрмөц онцлогтой байдаг. Хөдөө орон нутагт суурьшиж байгаа монголчууд нь ерөнхийдөө төвлөрөн суурьшсан онцлогтой байдаг. Шилийн Гол аймгийн монголчууд дотор монгол хэлээр ярьдаг нь 70 мянган хүн байж, монгол хэл ба хятад хэлээр бүр ярьж чаддаг нь 220 мянган хүнд хүрч<sup>4</sup>, бүх өөртөө засах орны хэмжээнд монгол хэлний хэрэглээгээр хамгийн сайн газрын нэг нь болдог билээ. Тус судалгаа нь Шилийн гол аймгийн монголчуудын гэр бүлийн хэл хэрэглээний байдлаар судалгааны агуулга болгон, судалгаанд оролцогчийн гэр бүлийн хэл хэрэглээний тухай баримтад суурилж, Шилийн гол аймгийн монголчуудын гэр бүлийн хэлний сонголт ба гэр бүлийн хэлний хэрэглээ нь судалгаанд оролцогчийн нас, ажил, амьдарч буй газар ба суурьшлын хэлбэр зэрэг нийгмийн хүчин зүйлийн талаар зөрөөтэй байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

## 1. ХЭЭРИЙН СУДАЛГАА БА СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

Нийгэм хэл шинжлэлийн судалгаа нь ердөө чанарын задлан шинжилгээ (qualitative analysis) ба хэмжээт шинжилгээ (quantitative analysis)-ний аргыг уялдуулсан байдаг. Гэвч аль аргаар судалгаа хийсэн ч судалгаанд оролцогч сонгох асуудалтай холбогддог. Учир нь бүх хүмүүсийг захаас нь нэг нэгээр сурвалжлан асуух боломжгүйгээс судалгаанд оролцогч сонгоход ердөө бөөнд сонгох, системтэй сонгох ба давхарга хувааж сонгох зэрэг арга хэлбэрийг хэрэглэдэг. Бид судалгаанд оролцогчийн нийтлэг шинж, төлөөлөх шинж ба шинжилгээ хийх боломж зэрэг хүчин зүйлийг бодож үзээд таван газрыг хээрийн судалгааны объект буюу цэгээр сонгов. Үүнд: Шилийн хот, Баруун Сөнөд хошуу, Зүүн Үзэмчин хошуу, Шулуун Хөх хошуу, Долон Нуур саянь<sup>5</sup> зэрэг болно. Энэ таван судалгааны цэгт дахин суурьшлын хэлбэрээр нь хот дүүрэг ба хөдөө орон нутгийн цэгийг ч тус тус сонгосон болно. Тодруулбал: Шилийн хотын хот дүүрэг ба Булган сум, Сөнид Баруун хошууны Сайхан-Тал Балгас ба Өргөн-Тал балгас, Зүүн Үзэмчин хошууны Улиастай балгас ба Самай сум, Шулуун Хөх хошууны Шант

<sup>4</sup> 锡林郭勒盟民族宗教局. 锡林郭勒盟民族宗教志[M]. 呼和浩特: 内蒙古文化出版社, 2012:6.

<sup>5</sup> Хятад засаг захиргааны нэгж бөгөөд монгол нийгэм соёлын хэлний орчин дахь “сум”-тай төсөөтэй нэгж юм.

балгас ба Сайн-Худаг сум, Долон Нуур саяний Долон Нуур балгас ба Да Хе Кү сянъ. Тус судалгаагаар дамжин 297 мэдээлэгчийн хэлний

хэрэглээний судалгааг хийсэн. Судалгаанд оролцогчдыг хүснэгт 1-т үзүүлье.

*Хүснэгт 1. Мэдээлэгчийн ерөнхий байдал*

	Төрөл	N	%		Төрөл	N	%	
Хүйс	Эрэгтэй	150	50.5	Соёл боловсрол	Бичиг үсэг үзээгүй	11	3.7	
	Эмэгтэй	147	49.5		Бүрэн дунд	97	32.7	
Нас	Залуу нас 15-34	143	48.2		Тусгай мэргэжил	41	13.8	
	Идэр нас 35-54	123	41.4		Их сургууль	119	40.1	
	Өтөл нас 55-80	31	10.4		Магистрант	23	7.7	
Ажил	Албан тушаалтан	148	49.8		Доктор	6	2.0	
	Багш	16	5.4	Суугаа Газар	Шилийн хот	57	19.2	
	Хөлсний ажилчин	12	4.1		Сөнид баруун хошуу	50	16.8	
	Сурагч	6	2.0		Зүүн үзэмчин хошуу	85	28.6	
	Малчин	96	32.3		Шулуун хөх хошуу	75	25.3	
	Тариачин	2	0.7		Долон нуур шиан	30	10.1	
	Үйлчилгээний ажилтан	3	1.0		Суурьшлын хэлбэр	Хот дүүрэг	154	51.9
	Хувиараа аж ахуй эрхлэгч	5	1.7	Хөдөө орон нутаг		143	48.1	
		Бусад ажилтай	5	1.7	нийт		297	100
		Ажилгүй	4	1.3				

Мэдээлэгчдийн ерөнхий байдлаас үзвэл, эрэгтэй эмэгтэйн тоо тэнцүүхэн, залуу нас ба идэр насны мэдээлэгч нь өтөл насныхаас харьцангуй олон, насаар хамгийн бага нь 19-н настай, хамгийн их нь

80-н настай байгаа юм. Хот дүүрэг ба хөдөө орон нутагт амьдардаг судалгаанд оролцогч 154 ба 143 хүн байх ба, их сургууль төгссөн судалгаанд оролцогч хамгийн олон, нийт 119 хүн (40.1%) байв. Албан



тушаалтан ба малчны эзлэх хувь хэмжээ нь өндөр бөгөөд бүх мэдээлэгчдийн 49.8% ба 32.3%-д хүрсэн байна.

## 2. ЭХ ХЭЛ БА ХЭЛ ЭЗЭМШИЛ

### 2.1 Эх хэл (Mother tongue)<sup>6</sup>


“Эх хэл гэдэг нь хүний төрсөн цагаас орчинд нь орж анхлан эзэмшиж, насан туршид хэрэглэж байгаа хэлийг хэлдэг”<sup>7</sup> “Ихэвчлэн гэртээ эзэмшсэн анхны хэлийг хэлдэг.”<sup>8</sup> Хос хэлний орчинд амьдардаг хүмүүс бас хос эх хэлтэй болдог. Судалгаанд оролцогчийн эх хэл нь монгол хэл болох нь 88.9%-тай, эх хэл нь хятад хэл болох нь 7.4%-тай, эх хэл нь монгол ба хятад хос хэл болох нь 3.7 %-тай байв.

(1) Насны зөрөөнөөс авч үзвэл, нас нь хэдий өндөр бол эх хэл нь монгол хэл болох боломж нь төдий зэргээр их, эх хэл нь монгол хэл байгаа судалгаанд оролцогч нь ахмад настнуудын 96.8%, идэр насныхны 91.1%, залуу насныхны 85.3%-т хүрэв. Нас нь хэдий бага бол хос эх хэлтэй болох боломж нь төдий их байна. Судалгаанд оролцогчдын залуу насныхны 6.3%, идэр насныхны 1.6%, өтөл насныхны 0%-тай байна. Эх хэл нь хятад хэл гэсэн судалгаанд оролцогчдын бүх насны хүмүүсийн дунд эзлэх хэм хэмжээгээр илэрхий зөрөөгүй, хувь хэмжээ залуу насныхны 8.4%, идэр насныхны 7.3%, өтөл насныхны 3.2% байв.

<sup>6</sup> Мөн төрөлх хэл(*native language*) гэж нэрлэдэг. Төрөлх хэл гэдэг нь тухайн хүний бага насандаа эзэмшсэн хэлийг хэлнэ. Энэ нь тухайн хүний гэр бүлд хэрэглэж байсан хэл юм уу тухайн улсынх нь хэл юм. Төрөлх хэл нь ихэвчлэн хүүхдүүдийн эзэмшсэн хамгийн анхны хэл мөн, гэхдээ бас үл хамаарах зүйл байдаг.

<sup>7</sup> Н. Нансалмаа. Нийгэм хэл шинжлэл. Улаанбаатар. МУИС Пресс, 2019: 54


<sup>8</sup> Jack C. Richards, John Platt, Heidi Platt. *Longman dictionary of language teaching & applied linguistics (English-Chinese)*, Beijing, foreign language teaching and research press: 298.



Зураг 1. Эх хэл эзэмшлийн насны зөрүү

(2) хот хөдөөгийн зөрөөнөөс нь авч үзвэл, эх хэл нь монгол хэл болох судалгаанд оролцогч нь хөдөө орон нутгийнхны 90.2%, хот дүүргийнхний 87.7%-тай байжээ. Харин хотод суугаа судалгаанд


оролцогчийн эх хэл нь хятад хэл болох хэм хэмжээ нь хөдөө орон нутгийнхаас их болж байна. Тодорхой хэлвэл хот дүүрэгт 9.7%, хөдөө орон нутагт 4.9% байна.



Зураг 2. Эх хэл эзэмшлийн хот хөдөөгийн зөрөө

(3) орон нутгийн зөрөөнөөс нь авч үзвэл, Шилийн хот, Баруун Сөнид хошуу, Зүүн Үзэмчин хошуу ба Шулуун Хөх хошууны байдал нь ерөнхийдөө адилхан, судалгаанд оролцогчдын эх хэл нь монгол хэл болдог нь дийлэнхийг эзэлж байгаа нь: Баруун Сөнид хошуу 98.0%, Шулуун Хөх хошуу 97.3%, Зүүн Үзэмчин хошуу 95.8%, Шилийн хот 94.7% байна. Долон Нуур саяний

мэдээлэгчийн дунд, эх хэл нь монгол хэл болох нь 33.3 %-тай байж, эх хэл нь хятад хэлтэй нь 66.7%-т хүрч байна. Бусад дөрвөн газрын мэдээлэгчийн дунд эх хэл нь хятад хэл болох хүний эзлэх хувь хэмжээ нь 0% ~1.8%-ийн хооронд байж, хос эх хэлтэй мэдээлэгчийн хувь хэмжээ 2.0%~ 3.5%-ийн хооронд байв.



Зураг 3. Эх хэл эзэмшлийн орон нутгийн зөрөө

## 2.2 Хэл эзэмшил (Language acquisition)

“Хэлний эзэмшил гэдэг нь хүний хэл сурах ба хэлний хөгжлийг зааж бий.”<sup>9</sup> Эх хэл буюу нэгдүгээр хэл сурахыг нэгдүгээр хэлний эзэмшил (First language acquisition), хоёрдугар хэл буюу гадаад хэл сурахыг хоёрдугар хэлний эзэмшил (Second language acquisition) гэдэг.

Судалгаанд оролцогчдын одоо нэгэнт эзэмшсэн хэлний тухай баримтаас үзэхэд, монгол хэлийг эзэмшсэн нь 272 хүнд хүрч, хятад хэлийг эзэмшсэн нь 249 хүнд хүрч, гадаад хэлийг<sup>10</sup> эзэмшсэн нь 29 хүн байна. Бүх судалгаанд хамрагдсан хүмүүсийн дотор, монгол хэл ба хятад хэлийг бүгдийн эзэмшсэн нь 197 хүн, монгол хэл, хятад хэл ба гадаад хэлийг бүгдийн эзэмшсэн нь 27 хүн, хятад хэл ба гадаад хэлийг

эзэмшсэн нь 2 хүн, ганц монгол хэлийг эзэмшсэн нь 48 хүн, ганц хятад хэлийг эзэмшсэн нь 23 хүн байгаа юм.

Монгол бичгийг эзэмшсэн нь 274 хүн байгаа бол, хятад бичгийг эзэмшсэн нь 227 хүн байх бөгөөд, гадаад бичгийг эзэмшсэн нь 46 хүн байна. Монгол ба хятад бичгийг бүгдийг эзэмшсэн нь 160 хүн байж, монгол, хятад, гадаад бичгийг бүгдийг эзэмшсэн нь 45 хүн, хятад бичиг ба гадаад бичгийг эзэмшсэн нь 1 хүн, ганц монгол бичгийг эзэмшсэн нь 69 хүн, ганц хятад бичгийг эзэмшсэн нь 21 хүн, бичиг эзэмшсэнгүй хүн 1 байв.

Монгол хэл ба хятад хэлний эзэмшсэн байдлаас үзэхэд, тухайн хэлийг эзэмшээд бичгийг нь сураагүй байдал байна. Хэлийг ярьж чадахгүй, харин бичгийг нь

<sup>9</sup> Jack C. Richards, John Platt, Heidi Platt. Longman dictionary of language teaching & applied linguistics (English-Chinese), Beijing, foreign language teaching and research press: 248.

<sup>10</sup> Тус судалгааны тоо бүртгэлийг хийхэд англи хэл, япон хэл ба испани хэл зэргийг “гадаад хэл” гэж нийлүүлэн бүртгэв.

эзэмшсэн жишээ ч бий. Ерөнхийдөө монгол хэл сурсан нь хамгийн их, дараа нь хятад хэл байна. Харин гадаад хэлийг эзэмшсэн хүн цөөн байна.

### Хүснэгт 2. Мэдээлэгчийн ерөнхий байдал

Төрөл	Хэл эзэмшил (N)	Бичиг эзэмшил (N)
Монгол	272	274
Хятад	249	227
Гадаад	29	46
Төрөл	Хэл эзэмшил (N)	Бичиг эзэмшил (N)
Монгол/Хятад	197	160
Монгол/Хятад/Гадаад	27	45
Хятад/Гадаад	2	1
Ганц монгол	48	69
Ганц хятад	23	21

### 3. ГЭР БҮЛИЙН ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ БАЙДАЛ

Тус хээрийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн өрхийн хүн амын тоо нь дунджаар 3.67 хүн бөгөөд ам бүлээр хамгийн олондоо 10 хүнд хүрч, хамгийн цөөндөө 1 хүнтэй байв. Гэр бүлийн бүрэлдүүнд ахмад үе, үе тэнгийхэн, доод үеийнхэн багтаж байна.

#### 1. Ахмад үеийнхэнтэй ярилцах хэл (1) Өвөө эмээтэйгээ ярилцах хэл

Судалгаанд оролцогч өвөө эмээтэйгээ ярилцахдаа монгол хэлээр ярьдаг нь 83.5%-тай, монгол хэл ба хятад хэлийг хольж ярьдаг нь 8.4%-тай, хятад хэлээр ярьдаг нь 6.4% -тай байв. Харин үгүй гэсэн тохиолдол 1.7 %-тай байсан.

1) Насны зөрөөнөөс үзвэл, судалгаанд оролцогч нь өвөө эмээтэйгээ монголоор ярьдаг нь өтөл насныхны 96.8%, идэр насныхны 84.6%, залуу насныхны 79.9%-д хүрч байна. Хятад хэлээр ярилцдаг нь идэр насны 7.3%, залуу нас 6.3%, өтөл нас 3.2%-ийг эзэлж байна. Монгол ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь залуу нас 10.5%, идэр нас 8.1%, өтөл нас 0%-ийн зөрөөтэй байна.

2) Ажил мэргэжлийн зөрөөнөөс нь авч үзвэл, монгол хэлээр ярьдаг судалгаанд оролцогч малчнынхны 100.0 %-т, албан тушаалтнынхны 79.3%-т, албан тушаалтан бус ажилтны 88.7%-т, тариачны 0%-т хүрч байна. Тариачин хүмүүс бүгд хятад хэлээр ярьдаг (100.0%) байна.

Монгол ба хятад хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь албан тушаалтан бус мэдээлэгчийн дунд хамгийн олон 13.4% байна.

3) хот хөдөөгийн зөрүүгээс авч үзвэл, хөдөө орон нутгийн хүмүүс монгол хэлээр илүү ярьдаг: хөдөө орон нутагт 90.2%, хот дүүрэгт 77.3% байна. Хятад хэлээр ярьдаг хүмүүс нь хот дүүргийнхний 7.8%-т, хөдөө орон нутгийнхны 4.9%-тай байна. Хот дүүрэгт суугаа мэдээлэгчийн дунд хоёр хэлийг хавсарган ярьдаг нь 12.3%-тай байв.

4) орон нутгийн зөрүүгээс үзвэл, монгол хэлээр ярьдаг мэдээлэгч нь: Баруун Сөнид хошуунд 96.0%, Шулуун хөх хошуунд 88.0%, Шилийн хотод 87.7%, Зүүн Үзэмчин хошуунд 87.1%, Долон нуур саянд 33.3%-ийг эзэлж байгаа юм. Долон нуур саяний хүмүүс 63.3% нь хятад хэлээр ярьдаг, бусад газар оронд хятадаар ярьдаг хүмүүс 0% байв. Хоёр хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь Зүүн Үзэмчин хошууны 11.8%, Шилийн хотын 8.8%, Шулуун Хөх хошууны 9.3%, Баруун Сөнид хошууны 4.0%, Долон нуур саяний 3.3%-т хүрч байна.

(2) Аав ээжтэйгээ ярилцах хэл

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ихэнх нь аав ээжтэйгээ ярилцахдаа монгол хэлээр ярьдаг. Монгол хэлээр ярьдаг нь 81.5%-тай, монгол хэл ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь 9.1%-тай, хятад хэлээр ярьдаг нь 6.4 %-тай байв.

1) насны зөрөөнөөс нь авч үзвэл, өтөл насны хүмүүс монголоор ярьдаг нь илүү бөгөөд өтөл нас 93.5%, идэр нас 83.7%, залуу нас 80.4%-тай байна. Залуучууд ба идэрчүүд дунд хятадаар ярьдаг хувь хэмжээ 6.3% ба 6.5%-тай ажээ. Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь залуу насныхны 11.9%, идэр насныхны 8.1%-тай байна.

2) ажил мэргэжлийн зөрөөнөөс нь авч үзвэл, малчин хүмүүсийн дунд монголоор ярьдаг нь хамгийн олон буюу малчин 100.0%, ажилтан 88.0%, албан тушаалтан 79.3%, сурагч 66.7%, тариачин 0% байна. Тариачин нараас хятадаар ярьдаг нь 100.0%-т хүрч, албан тушаалтан бус ажилтныхны 7.5%-тай, албан тушаалтныхны 4.9%-тай, монгол хэл ба хятад хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь сурагч ба албан тушаалтны дотор нилээд байна; сурагч 33.3% , албан тушаалтан 14.0% эзэлж байна.

3) хот хөдөөгийн зөрөөнөөс авч үзвэл, монгол хэлээр ярьдаг нь хөдөө орон нутагт 88.1%-тай байж, хот дүүрэгт 78.6%-т хүрэв. Хятад хэлээр ярьдаг нь хот дүүргийн хүмүүсийн 7.1%-т хүрч, хөдөө орон нутагт 4.9%-тай болов. Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь хот дүүрэгт нилээд байж , 14.2 %-тай болов.

(4) Орон нутгийн зөрөөнөөс авч үзвэл, Долон Нуур саянаас бусад газар орны хүмүүс монгол хэлээр ярьдаг. Баруун Сөнөд Хошуу 94.0%, Шулуун Хөх хошуунд 88.0%, Шилийн хотод 86.0%, Зүүн Үзэмчин

хошуунд 82.4%, Долон Нуур сянды 33.3%-ийг эзэлж байна. Долон Нуур сянгий мэдээлэгч хятад хэлээр ярьдаг нь 63.3%-тай бөгөөд бусад газар орны хятадаар ярьдаг хүмүүс 0% байна. Хоёр хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь бүх газар оронд 10% орчимд хүрч байна.

## 2.Үеийн хүмүүстэй ярилцах хэл

(1) ах, дүү, эгч ,охин, дүүтэйгээ ярилцах хэл

Судалгаанд оролцогч хүмүүс ах, дүү, эгч, охин, дүүтэйгээ ярилцахад монгол хэлээр ярьдаг нь 78.5%-тай, монгол хэл ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь 13.8%-тай байж, хятад хэлээр ярьдаг нь 6.4%-т хүрчээ.

1) насны зөрөөнөөс аюч үзвэл, монголоор ярьдаг нь өтөл насны мэдээлэгчийн 96.8%-д, идэр насныхны 82.9%-т, залуу насныхны 70.6%-т хүрч байгаа юм. Хятадаар ярьдаг нь идэр насныхны 7.3%, залуу насныхны 6.3%, өтөл насныхны 3.2%-т хүрэв. Хоёр хэлийг хавсаргаж ярьдаг нь залуучуудын дунд 20.3%-т хүрэв, идэр насныхны 9.4% -тай, өтөл насныхны 0% байв.

2) ажил мэргэжлийн зөрөөнөөс нь авч үзвэл, монгол хэлээр ярьдаг хүмүүс нь малчдын дунд хамгийн их 99.0%-т хүрэв, албан тушаалтан бус ажилтан 85.7% , албан тушаалтан 72.6%, сурагч 66.7%, тариачин 0% байв. Хятад хэлээр ярьдаг нь тариачин хүмүүсийн 100.0%-т хүрэв. Хоёр хэлийг

хавсарган ярьдаг нь сурагчийн дотор хамгийн их сурагчийн 33.3%, албан тушаалтны 20.7%, албан тушаалтан бус ажилтны 5.3%, малчдын 1.0%-тай байв.

3) хот хөдөөгийн зөрөөнөөс авч үзвэл, монголоор ярьдаг нь хөдөө орон нутгийн мэдээлэгчийн дунд 87.4%-тай, хот дүүргийн 70.1%-тай болсон байна. Хот дүүргийн мэдээлэгчийн дотор хоёр хэлээр ярьдаг нь нилээд их 20.8%-тай байж, хөдөө орон нутгийнхан 6.3%-тай харагдаж байна.

4) орон нутгийн зөрөөнөөс нь авч үзвэл Долон Нуур сянйас бусад газар орны хүмүүсийн ихэнх нь монголоор ярьдаг. Баруун Сөнид хошууны 90.0%, Шилийн хотын 84.2%, Шулуун Хөх хошууны 82.7%, Зүүн Үзэмчин хошууны 81.2 % байна. Энэ дөрвөн газар оронд судалгаанд хамрагдсан хүмүүсээс хоёр хэлийг хавсарган ярьдаг нь 10.0%~17.0%-тай байж, хятадаар ярьдаг нь 0% байв. Долон нуур сянгий хүмүүсийн дийлэнхи нь хятад хэлээр ярьдаг (63.3%), монголоор ярьдаг нь 30.0%-тай байна.

(2) Хань ижилтэгээ ярилцах хэл

Судалгаанд оролцогч нь хань ижилтэйгээ ярилцахад монголоор ярьдаг нь бүх хүмүүсийн 69.7%-т хүрч, монгол ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь 12.1%-тай, хятадаар ярьдаг нь 9.1%-тай болов. Харин үгүй гэх хариулсан нь 9.1%-тай болов.

1) насны зөрөөнөөс нь үзвэл, монголоор ярьдаг хүмүүс нь өтлөө насныхны 87.1%-т, идэр насныхны 77.2%-т, залуучуудынхны 69.4%-т хүрч байна. Хятад хэлээр ярьдаг нь идэр насны дунд хамгийн олон тоог эзэлж байна (8.9%). Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь залуучууд дунд олон байж, 16.1%-тай болов.

2) ажил мэргэжлийн зөрөөгөөс үзвэл, малчин хүмүүсийн дунд монголоор ярьдаг нь олон буюу 96.9%-тай байна. Албан тушаалтан бус ажилтныхны 81.2%-т, албан тушаалтныхны 60.4%-т хүрэв. Тариачин хүмүүсийн хятадаар ярьдаг(100.0%). Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь албан тушаалтны 20.2%, албан тушаалтан бус ажилтны 2.3%, малчныхны 1.0%-т хүрэв.

3) хот хөдөөгийн зөрөөнөөс нь авч үзвэл, хөдөө орон нутгийн хүмүүсийн дунд монголоор ярьдаг нь хамгийн олон, 83.2%-тай байв. Хот дүүргийн хүмүүсийнх бол 57.1% байжээ. Хоёр хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь хот дүүргийнхний 18.8%-т, хөдөө орон нутгийнхны 5.0%-т хүрэв. Хятадаар ярьдаг нь хот дүүргийнхний 12.3%, хөдөө орон нутгийнхны 5.6%-т хүрч байгаа юм.

4) орон нутгийн зөрөөнөөс авч үзвэл, Долон Нуур сяний мэдээлэгчийн дунд хятадаар ярьдаг нь 66.7%-тай, хоёр хэлийг хавсарган ярьдаг нь 12.0%-тай байв. Бусад газар орны мэдээлэгч нь монгол хэлээр ярьдаг нь олон байж, хувь хэмжээ нь

70.7%~ 86.0%-т хүрэв. Хятадаар ярьдаг нь 1.8%~2.7%-т хүрчээ. Хоёр хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь Зүүн Үзэмчин хошуунд хамгийн олон буюу 18.6%-тай байна.

### 3. Доод үетэйгээ ярилцах хэл

Доод үеийнхэнтэйгээ ярилцахдаа монгол хэлээр ярьдаг нь 74.1%-тай, монгол ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь 15.8%-тай, хятад хэлээр ярьдаг нь 7.4%-д хүрч байгаа юм. Ийм байдал үгүй харилсан нь 2.7%-тай байв.

(1) насны зөрөөнөөс авч үзвэл монголоор ярьдаг нь өтөл насныхны 96.8%-тай, идэр насныхны 75.6%-тай, залуу насныхны 67.8%-тай болов. Залуучуудын дунд хоёр хэлийг хавсарган ярьдаг хүмүүс нь хамгийн их буюу (19.5%) болж, идэр насныхны 15.5%-тай байв. Залуучууд ба идэрчүүдийн дунд хятад хэл ярьдаг нь хувь хэмжээ 7.7% ба 8.1%-д хүрч байгаа юм.

(2) ажил мэргэжлийн зөрөөнөөс авч үзвэл, монголоор ярьдаг нь малчдынхны 93.8%-тай, албан тушаалтан бус ажилтны 81.2%-тай, албан тушаалтныхны 68.3%-тай, сурагсадынхны 50.0%-тай, тариачныхны 0%-тай байна. Сурагч ба албан тушаалтан хүмүүсийн хоёр хэлийг хавсарган ярьдаг нь хувь хэмжээ 33.3% ба 22.0%-тай хүрэв. Тариачин хүмүүсийн 100.0% , сурагсадынхны 16.7%-тай нь хятадаар ярьдаг.


(3) хот хөдөөгийн зөрөө, монгол хэлээр ярьдаг нь хөдөө орон



нутгийн 81.1%, хот дүүрээгийн 67.5%-тай байна. Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь хот дүүргийн 19.4%, хөдөө орон нутгийн 11.9%-тай байна. Хятадаар ярьдаг нь хот дүүрэгт 5.6% , хөдөө орон нутагт 9.1%-тай байв.

(4) орон нутгийн зөрөөнөөс авч үзвэл монгол хэлээр ярьдаг нь Баруун Сөнид хошуу 86.0%, Зүүн Үзэмчин хошуу 78.8%, Шулуун Хөх

хошуу 78.7%, Шилийн хот 77.2%, Долон нуур сян 0%-тай байна. Хоёр хэлийг хавсарган ярьдаг нь Долон Нуур саний 26.6%, Зүүн Үзэмчин хошууны 20.0%, Шулуун Хөх хошууны 16.0%, Шилийн хотын 17.5%, Баруун Сөнид хошууны 14.0%-тай байна. Хятад хэлээр ярьдаг нь Долон Нуур саний судалгаанд оролцогчдын дунд хамгийн олон 66.7%-тай байв.



Зураг-4. Гэр бүлийн хэлний хэрэглээ

### ДУГНЭЛТ

Судалгаанд оролцогчдын эх хэл нь монгол хэл байх нь дийлэнх байж, судалгаанд хамрагдсан хүмүүсийн эх хэлний эзэмшил нь өтөл нас, идэр нас, залуу нас, хөдөө орон нутаг, хот дүүргийн дараалалтайгаар орон нутгийн зөрүүтэй байдал маш их байсан. монгол хэлийг эзэмшсэн хүний тоо хамгийн их, дараа нь хятад хэл эзэмшсэн хүмүүс орж байна. Шилийн Гол аймгийн гэр бүлийн

хэлний хэрэглээ гол нь монгол хэл болдог боловч, хэлний хэрэглээ нь насны зөрөө, орон нутгийн зөрөө, ажил мэргэжлийн зөрөө, хот хөдөөгийн байдлаараа зөрүүтэй байв.

#### 1. Насны зөрөө

Шилийн гол аймгийн монголчууд гэр бүл дотроо ахмад үеийнхэн (өвөг эмэг, аав ээж), үе сацуугийнхан (ах дүү эгч охин дүү,



хань ижил), доод үеийнхэнтэйгээ ярилцахад голдуу монгол хэлээр ярьж, монгол ба хятад хэлийг хавсарган ярьдаг нь дэд байрыг эзэлж, хятадаар ярьдаг нь цөөн тоог эзэлдэг байна. Ахмад үеийнхэн монгол хэлний чадвар сайн, харин хятад хэлний чадвар муу, эсвэл хятад хэлгүй зэргээс шалтгаалж, судалгаанд оролцогч ахмад үеийнхэнтэй ярилцахад монгол хэлээр сайн ярьдаг (83.5%~81.8%). Үе сацуу буюу доод үеийнхэнтэй ярилцах үед ярианы сэдэв нь нийгмийн халамжийн асуудал, кино, телевиз жүжиг ба од, хит дуу зэрэг сэдэвтэй холбогддог болохоор хятад хэлийг хавсаргаж ярьдаг байна (12.1%~15.8%). Хятадаар ярьдаг нь адил бус насны мэдээлэгчийн дунд эзлэх хувь хэмжээ нь илэрхий зөрөөгүй бөгөөд бүх насны мэдээлэгчийн дунд 6.4%~7.4%-т хүрч байна. Монгол үндэстэн өөр үндэстэнтэй ураглах хүчин зүйлийн нөлөөгөөр, хань ижилтэйгээ хятадаар ярих хэм хэмжээ өндөр байв. Гэвч ерөнхийд нь авч үзвэл, Шилийн гол аймгийн монголчууд гэр бүл дотроо монголоор ярих нь гол байрыг эзэлж, хятад хэлийг хавсарган ярих үзэгдэл нь залуучуудын дунд илүү оршиж байна.

## 2. Орон нутгийн зөрөө

Нөгөө талаар, гэр бүлийн хэлний хэрэглээ нь орон нутгийн зөрүү, ялгаатай байдлаараа голдуу Долон Нуур саянь ба бусад дөрвөн газар орны хооронд илэрч байна. Долон Нуур саяний монголчуудын

дийлэнхи нь хятад хэлээр ярих болсон байна (Долон Нуурын монголчуудын эх хэл нь хятад хэл болжээ). Энхүү зөрөөг үүсгэсэн гол шалтгаан нь үндэстний хүн амын тоо ба суурьшлын онцлог болно. Шилийн хотын байнгын хүн ам 272.6 мянга, монгол үндэстэн бүх хүн амын 35.8 %-г эзэлж байна. Сөнид баруун хошууны байнгын хүн ам 60.8 мянга, монгол үндэстэн бүх хүн амын 35.84 % эзэлнэ. Шулуун хөх хошууны байнгын хүн ам 84.2 мянга, монгол үндэстэн бүх хүн амын 38.89 %-тай байв. Зүүн үзэмчин хошууны байнгын хүн ам 60.8 мянга, бүх хүн амын 74.69% нь монгол үндэстэн юм. Энэ дөрвөн газрын монгол үндэстэний хүн ам цөөн бус, хөдөө орон нутгийн монголчууд төвлөрөн суурьшиж, хот дүүрээгийн монголчууд бусад үндэстэнтэй холилдож суурьшсан дундаа төвлөрсөн онцлогтой. Ийм учраас нийгэм нийт дундаа монгол хэлээр ярьдаг хэлний орчин бий бөгөөд энэ нь монголчуудын гэр бүлийн монгол хэлний хэрэглээд эерэх нөлөө дагуулж байдаг. Долон Нуур шяний байнгын хүн ам 105.4 мянга, монгол үндэстэн 6074, бүх хүн амын 5.4%-г эзэлж байна. Долон Нуурын монгол үндэстний хүн ам их цөөн, монголчууд нь тархан суурьшиж, бусад үндэстэй ургалсан хэмжээ өндөр ба монголоор хичээллэх сургууль үгүй учраас гэр бүлийн монгол хэлний хэрэглээ аанай байтугай, монгол хэлний эзэмшил нь ч аанай байдаг билээ.

## 3. Хот хөдөөгийн зөрөө

Хөдөө орон нутагт сууж байгаа хүмүүсийн монгол хэлний хэрэглээ нь хот дүүргийнхээс сайн байна, хот дүүргийн хүмүүс монгол хятад хоёр хэлийг хавсарган ярих боломж нь өндөр байна. Хот дүүрэгт суурьшиж байгаа хүмүүс нь нийгмийн хэлний орчинд хятад хэлээр ярих тохиолдол олон иймээс гэр бүл дотроо ч санамсаргүй хятад хэлээр ярилцах байдал гардаг байна.

#### 4. Ажил мэргэжлийн зөрөө

Ажил мэргэжил адил бус мэдээлэгчийн дунд, малчин хүмүүсийн монгол хэлний хэрэглээ хамгийн сайн, тариачин хүмүүс

хамгийн муу (тариачин хүмүүс нь цөм Долон Нуур саянийх билээ).

Шилийн Гол аймгийн монголчуудын гэр бүлийн хэлний хэрэглээ нь монгол хэлээр голлож байсан ч судалгаанд оролцогчдын гэр бүлийн хэлний хэрэглээний зөрүүгээс гэр бүлийн монгол хэлний хэрэглээ нь хөгжих нөхцөл боломжоор сайн бус байдал илэрхий харагдаж байна. Ийм учраас гэр бүлийн хэлний бодлогоор гэр бүлийн гишүүдийн хэлний хэрэглээ ба хэлний сонголтыг удирдан монгол хэлний гэр бүлийн үе уламжлалд сайн нөхцөл хангах хэрэгтэй байна.

### АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Chomsky,N.1965.Aspects of the theory of syntax[M].Cambridge,Mass.:The MIT Press.
2. Leech,G.1983.Principles of Pragmatics[M].London:Langman.
3. 李宇明(Li Yuming).语言生活与精神文明建设[J].语文建设,1997(1).
4. Алтанбулаг, Монголчуудын гэр бүлийн хэлний бодлогын тухай судалгаан[D], Өвөр Монголын Их Сургуулийн доктор зэрэг хамгаалсан өгүүлэл, 2016 уны 6 сар.
5. Сацрал, Монголчуудын гэр бүлийн хэл хэрэглэхний үе зэрэглэлийн зөрөөний тухай судалгаа[D], Өвөр Монголын Их Сургуулийн мастер зэрэг хамгаалсан өгүүлэл, 2018 оны 12 сар.

Article info: Mandakh Research, 2021, Vol.06, HUM 602

## PRELIMINARY STUDY XI JINPING'S THOUGHTS ON ADMINISTERING THE COUNTRY

The "Two Outlooks and Three Theories" and "Six Strategies and Nine Policies"  
Constitute the Main Contents of Xi Jinping's Thoughts on State Governance

**Jiang Ailin**

Beijing Zhonghong Zhenxing Digital Technology Research Institute, China  
ailinj@sina.com

### 习近平治国理政思想初探

——“两观三论”与“六韬九策”是习近平治国理政思想的主要内容

作者/姜爱林

#### Abstract

*What are Xi Jinping's Thoughts on Administering the Country? "Xi Jinping's Thoughts on Administering the Country" is a systematic and theoretical general term for Comrade Xi Jinping's administering the country, focusing on the "Two Outlooks and Three Theories" and "Six Strategies and Nine Policies."*

